Table 11. Suffixes That Form Verbs From Passive Stems

**Дагавар Suffixes**

**Жишээ Example**

-л	хагал, сугал, бутал, бяцал, цоол
-р	хагар, сугар, бутар, бяцар, цоор, ээр, аар, мөөр, бээр, хяхар, хэхэр, чухар
-ч	хагач, сугач, цооч, нугач, хугач
-ай, -ий, -ой	гэдий, гялай, онгой, данхай
-схий	цэлсхий, годосхий, арзасхий
-лз	малилз, бондолз, дэрвэлз, бөхөлз
-гана, -гэнэ, -гоно, -гөнө	бондгоно, хазгана, дэлдгэнэ, жирвэгэнэ, соотгоно, бөндгөнө
-хий	тасхий, часхий, падхий, давхий, палхий

-ги, -гэ, -гь, -г	шарги, дарги, цалги, булги, жиргэ, нэргэ, шуугь, жийг
-гина, -гино, -гэнэ	жингэнэ, хангина, гонгино, дүнгэнэ, янгина
-хир/-хэр, -гир/-гэр	архир, бархир, орхир, хүрхэр, хашгир, исгэр
-жигна, -жигнэ, -	
жигно	таржигна, түржигнэ, хоржигно, тачигна, түчигнэ, хорчигно
-чигна, -чигнэ, -чигно	
-ш	тогш, түгш, шогш, лугш, шагш, янш
-л	майл, буйл, хайл, орил, гуугал
-тна, -тнэ, -тно, -тнө	шахтна, хяхтна, бувтна

□ Practice 4. structure of VERBS.

Directions: Identify the stem and the suffix of each verb.

1. хагал _____	тасар _____
хугал _____	цоор _____
сугал _____	хагач _____
тасал _____	хугач _____
хугар _____	сугач _____
сугар _____	нугач _____
2. гэдий _____	цэлсхий _____
сэртий _____	голдолз _____
мэлтий _____	эрвэлз _____
нялцай _____	арвалз _____
гэдэсхий _____	жирвэгэнэ _____
3. жиргэ _____	харжигна _____
хангина _____	тогш _____
жингэнэ _____	түгш _____
мөөр _____	исгэр _____
майл _____	бархир _____
буйл _____	хяхтна _____

## Үйл Үгийн Хэв Formative Verbs 5.4

Verb's *formative endings* **үйл үгийн хэвийн нөхцөл** show a relationship between the agent and the action. These forms are revealed by their endings:

барь Ø  
 бариул  
 баригд  
 барилд  
 барилц

There are five forms:

1. Self-action form **Өөрөө үйлдэх хэв**. An agent acts on its own:

Эхнэр Лхам өглөө босч, өрх татан, гал түлж, цай чанав.

Тэнгэрт одод гялалзаж, алсад адуу янцгаахад талд төөрсөн Сангийн сэтгэл уужрав.

2. Causative form. **Бусдаар үйлдүүлэх хэв**

An agent makes the others act. It has the following endings: -УУЛ/-ҮҮЛ, -ЛГА (-ЛГЭ, -ЛГО, -ЛГӨ), -ГА (-ГЭ, -ГО, -ГӨ), -АА (-ЭЭ, -ОО, -ӨӨ):

уншуул	гарга	бүтээ
дуулуул	түүлгэ	хатаа
бичүүл	томсго	тогтоо

тариул                    өсгө                    өлсөө

### 3. Passive form. **Бусдын эрхэнд үйлдэгдэх хэв**

This is an act under influence or pressure. It has -ГД, -Д/-Т endings:

харагд	томд	хүрт
бодогд	олд	хирт
санагд	дийлд	хуурт

### 4. Interaction form. **Харилцан үйлдэх хэв**

This act is conducted between two or more agents. It has -ЛД ending:

барилд	хуралд	дуудалд
мөргөлд	маргалд	зодолд
тулалд	уралд	таталд

### 5. Cooperative form. **Хамтран үйлдэх хэв**

This act is conducted by two or more agents. It has -ЛЦ ending:

цэвэрлэлц	хөтлөлц	хэлэлц
ярилц	хийлц	уншилц
барилц	туслалц	өргөлц

A structure of a verb can consist of more than one form endings.

It's called a *combined form* **НИЙЛМЭЛ ХЭВ**:

байгуулагд	ноцолдуул	бүтээгд
ярилцуул	шахцалдуул	хатаагд
бодогдуул	дагалдуул	ноогдуул

□Practice 5. formative VERBS.

Directions: Find and underline the verbs in self-action form.

Үүр цүүрээр босч, тэнгэрийн царай, малын бараа харж орж ирээд өвгөн хоймор завилан, гаансаа хааяа нэг сорж хэсэг дуугүй сууна. Бэр нь цайныхаа дээжийг аягалж хоёр гардан барина. Өвгөн нударгаа сэгсрэн зугуухан тосон авч амсаад, өмнөө байгаа аяганы ширээн дээр тавина. Ач хүү нь араас нь мөлхөн очиж дээлээс нь зууран босч, өвгөнийг түшиж дэнжгэнэн алхана. Нялх үнэр нь арилаагүй зулайг нь үнэрлээд газар тавина. Ачийнхаа хөлд орсныг мялааж байгаа нь тэр.

□Practice 6. formative VERBS.

Directions: Read the following riddles. Find and underline the verbs in interaction form.

1. Хонхор дотор хоёр жанжин байлдана. Хойт жалга руу нь жаран цэрэг цуварна. (Юм идэх)
2. Танхил хатан өвдөхөд таван хий нь шогшилдоно. (Шүдэнд мах орох)
3. Арван чавганц өглөө босоод ноцолдоно. (Нүүр гараа угаах)

□Practice 7. formative VERBS.

Directions: Find and underline the verbs in causative form.

1. Арван сар тээж төрүүлээд, ангир уургаа шимүүлэн өсгөж, хөлийг минь дөрөөнд, гарыг минь ганзаганд хүргэсэн энхрий хайрт эхийн минь ач юутай ариун цагаан билээ.
2. Эрхийг сурахаар бэрхийг сур гэж ямагт сурган хэрд минь таарсан ажлын хатууг хийлгэж, ачааны хүндийг үүрүүлсээр хийж бүтээхийн амтанд оруулж эрийн цээнд хүргэсэн хангай шиг түшигтэй аавын минь ухаан бодол юутай холч мэргэн билээ.

□Practice 8. formative Verbs.

Directions: What is the difference between these two sentences?

1. Нохой чоныг хөөв.                    Чоно нохойд хөөгдөв.
2. Дорж Батыг барилаа.                Бат Доржид баригдлаа.
3. Нар биеийг нь шаржээ.              Бие нь наранд шарагджээ.
4. Найз минь аав ээжээ бодно.      Аав ээж нь (найзад минь) бодогдоно.
5. Би алсын барааг харав.            Алсын бараа (надад) харагдав.

□Practice 9. formative VERBS.

Directions: Add the causative form endings to the following verbs.

бод	_____	ир	_____
барь	_____	унт	_____
тогло	_____	хэрэглэ	_____
үрж	_____	сана	_____
хайрла	_____	анхаар	_____
тасал	_____	майл	_____
суу	_____	буу	_____
гүй	_____	харай	_____
туу	_____	нуу	_____
нээ	_____	гуй	_____
ай	_____	гэдий	_____
ороо	_____	өндий	_____
сал	_____	арил	_____
гар	_____	ол	_____
цад	_____	сулд	_____
бэлд	_____	хана	_____
суна	_____	нис	_____
өс	_____	сур	_____
дас	_____	өргөд	_____
багас	_____	нор	_____
бүт	_____	хат	_____
нур	_____	хур	_____
шат	_____	тогт	_____
өнгөр	_____	сэр	_____
зугт	_____	байц	_____

□Practice 10. formative VERBS.

Directions: Complete the sentences. Use the words in parentheses.

Model: (голно/гологдохгүй)

Ажил намайг голно уу гэхээс ажил надад гологдохгүй.

1. (өндөртөнө/намхдахгүй)

Би тэдний багт ороод \_\_\_\_\_.

2. (барина/баруулахгүй)

Ах машинаа өөрөө \_\_\_\_\_.

3. (залуужуулна/хөгшдөхгүй)

Энэ үс засалт түүнийг \_\_\_\_\_.

4. (томдоно/жигжигдэхгүй)

Танд энэ ажил \_\_\_\_\_.

□Practice 11. formative VERBS.

Directions: Find and underline the verbs in passive form.

1. Тайзны хөшиг алгуур нээгдэхэд бүдэгхэн сонсогдож байсан аялгуу улам тодорлоо.

2. Должинг яаж хөгжимдөхийг харах гэж сэтгэл догдлон хүлээж суусан Баатарын нүдэнд хэн ч үзэгдсэнгүйд гайхаш төрөв.

3. Гэвч ганц олдсон завшааныг ашиглаж концертын дараа заавал уулзана гэсэн бодолд автлаа.

□Practice 12. formative VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use the COOPERATIVE FORM.

1. Хуульч нар хоорондоо (яриу) \_\_\_\_\_.

2. Хоёр улсын ерөнхийлөгч гар (*барив*) \_\_\_\_\_ .
3. Та түүнтэй (*таниарай*) \_\_\_\_\_ .
4. Хүн бүр энэ ажлаас (*хийгээрэй*) \_\_\_\_\_ .

□ Practice 13. formative VERBS.

Directions: Find and underline the verbs in interaction form.

1. Хашаан дотор хоёр ишиг мөргөлдөнө.

Хажуу талд нь хоёр хүү барилдана.

Дошны аман дээр хоёр мөндөл хөөцөлдөнө.

Доод талд нь хоёр зурам ноцолдоно.

2. Тал дүүрэн түмэн сүрэг бэлчиж,

Таанын үнэр хамар цоргин ханхална.

Цэнхэр манан уул түшин хөшилдөөд,

Цэвэр агаар цээж ариусган сэнгэнэнэ.

□ Practice 14. formative Verbs.

Directions: Find and underline the verbs with formative endings.

1. Өглөөний улаан наран илч гэрлээ цацруулан, байгаль ертөнцийг гийгүүлнэ.
2. Хорвоогийн нэг өдөр ийнхүү эхлэнгүүт Сүрэнгийн толгойд түмэн бодол эргэлдэж, алсад суугаа буурал ээж нь юу юунаас бодогдоно.
3. Хүний орчлонд төрж жаргалтай өссөн хувь тавиландаа баярлах боловч төрүүлж ангир уургаа шимүүлэн өсгөсөн ачит ээжтэйгээ олон жил уулзаагүй яваадаа харамсах ажээ.
4. Тэгтэл саяхан танилцсан Долгор ээжийнх нь сургийг гаргасан тул нутагтаа буцахаар шийджээ.

□ Practice 15. formative VERBS.

Directions: Circle the right verb in parentheses.

1. Би найзтайгаа хөдөө явж, наадмаар бөх (*барилдсан, барилдуулсан*).
2. Би эмээгээ амралтын газар аваачиж (*амраасан, амруулсан*).
3. Тэд биднийг таксигаар (*угтуулж, угтаж*) авсан.
4. Хүүхдүүд ээ, энэ ажлаас (*хийгээрэй, хийлцээрэй*).
5. Энэ долоо хоногийн хурал амжилттай (*явж, явагдаж*) өнгөрсөн.
6. Би хүүгээ элсэн дээр (*тоглуулсан, тоглосон*).
7. Аав ээж хоёр надтай цасан өвгөн (*хийсэн, хийлцсэн*).

## 5.5 Үйл Үгийн Байдал Conditional Forms of Verbs

Conditional verbs can be formed by adding the endings, or by the method of repeating.

Хүснэгт 12. Байдлын нөхцөлүүд Table 12. Conditional Endings

Condition	Үйл Үгийн Байдлын Нэр	Endings	Example
		Нөхцөл	Жишээ
Simple	Энгийн үйлдэх	∅	унш, ярилц, гарга
Complete	Бүрмөсөн үйлдэх	-чих	уншчих, ярилцчих, гаргачих
Temporary	Түр үйлдэх	-зна ,	хүлээзнэ, барьзна, босозно, өндийзнэ
		-знэ,	
		-зно,	
Intensive	Эрчимтэй үйлдэх	-знө	явсхий, бөхийсхий, шогшуулсхий
		-схий	

		цгаа,	
		-	
Mass	Олноор үйлдэх	цгээ,	уулзацгаа, үзэцгээ, сонсоцгоо, өгцгөө
		-	
		цгоо,	
		-цгөө	

The verbs with coordinating endings, such as -Ж/-Ч, -ААД (-ЭЭД, -ООД, -ӨӨД), -Н, -СААР (-СЭЭР, -СООР, -СӨӨР), show continuous action when they are used in repeated form:

явж явж	үсэрч үсэрч	уншиж уншиж
эрээд эрээд	ялгаад ялгаад	өрөөд өрөөд
бодон бодон	ярин ярин	хүчлэн хүчлэн
майлсаар майлсаар	тодорсоор тодорсоор	үглэсээр үглэсээр

Verbs can have particles in front of them repeated to show the repeated action, for example:

хага хага цохь	сэр сэр салхил	пор пор буцал
хуга хуга тат	түг түг цохил	тас тас хөхөр

□ Practice 16. conditional VERBS.

Directions: Add the conditional endings to the following verbs. Use **-чих, -зна (-ЗНЭ, ЗНО, -ЗНӨ), -схий, -цгаа (-ЦГЭЭ, -ЦГОО, -ЦГӨӨ)**.

хар	_____	_____	_____	_____
бай	_____	_____	_____	_____
чана	_____	_____	_____	_____
өргө	_____	_____	_____	_____
амтал	_____	_____	_____	_____

□ Practice 17. conditional VERBS.

Directions: Complete the sentences. Use the appropriate conditional endings.

- Оройн наран шингэхэд Дашийн хэсгийнхэн модоо хөрөөдөж (*хураа+аад*) \_\_\_\_\_, хоолоо хийж (*ид+ээд*) \_\_\_\_\_ амарч байлаа. Харин аль эрт өвсөө хадаж (*бухалд+аад*) \_\_\_\_\_ байх ёстой Санжийн хэсгийнхэн ажлаа (*хая+сан*) \_\_\_\_\_ байв.
- Би тэр танхимд ороод аль ч учрыг мэдэлгүй (*хүлээ+ж*) \_\_\_\_\_ зогстол ул таних нэгэн хүн:  
– Та үүнийг (*үз+ж*) \_\_\_\_\_ бай гэж нэг зурагтай ном өгөөд яваад өглөө.
- Дасгалжуулагч:  
Нуруугаа (*хотойлго*) \_\_\_\_\_, толгойгоо (*гэдийлгэ*) \_\_\_\_\_ гэж сануулахад тамирчид ёсоор нь гүйцэтгэнэ.
- Тэднийг (*бүжиглэ+ж*) \_\_\_\_\_ байтал аймгийн төвөөс жүжигчид (*ир+в*) \_\_\_\_\_ . Тэд шөнө дөл болтол дуулж, бүжиглэж, тоглож (*нарги+в*) \_\_\_\_\_ .

□ Practice 18. conditional VERBS.

Directions: Find and underline the verbs that show continuous action.

- Дээшлэн дээшилсээр хурдны морь эргэх шиг чавхдан чавхдан, цогин цогин, хатиран хатирсаар улам улам алслуулж, нуур бидэрлэх мэт шуранхайлж зуны наран жаргах адил дуусна.
- Тайлбарлаж тайлбарлаж өгөхөд ойлгосонгүй.
- Бид хотод жолоодсоор жолоодсоор хүрлээ.
- Тэдний зугатсан муурыг хайсаар хайсаар олж чадаагүй.
- Анхны цас орсоор орсоор хотыг бүрхэв.
- Машин нь тар тар дугараад эвдэрсэн бололтой гэнэт хөдөлгөөнгүй зогсов.

7. Энхмаа цонхоороо ширтсээр ширтсээр бодол санаандаа умбав.
8. Тоолсоор тоолсоор нэг мэдэхэд цаг оройтож, нар шингэсэн байв.
9. Тэрээр авсаар авсаар муу зан суржээ.
10. Энэ асуудлыг хэлэлцээд хэлэлцээд үр дүнд хүрч чадалгүй, маргааш нь үргэлжлүүлэхээр шийдлээ.

## 5.6 Үйл Үгийн Төлөв Completing Forms of Verbs

Completing verb endings show person's approach, for example:

Ах минь, та хурдан *ирээрэй*.

Тэд өчигдөр хөдөөнөөс *иржээ*.

In these sentences, the ending *-ээрэй* in the verb *ирээрэй* shows that the 1<sup>st</sup> person advises the 2<sup>nd</sup>, and the ending *-жээ* in the verb *иржээ* shows that the 1<sup>st</sup> person didn't know about the upcoming event.

Endings that show different approaches are called *personal* completing endings.

The particles *бүү, битгий* are used before the predicate with the personal endings to express prohibition.

Also the following particles *даа, ДЭЭ, ДОО, ДӨӨ* are used after the predicate with the personal completing endings to express the speaker's attitude, for example:

яв  $\emptyset$  даа

явъя даа

яваарай даа

яваач дээ

яваасай даа

Хүснэгт 13. Биеийн төлөвийн нөхцөлүүд. Table 13. Personal Completing Endings

Meaning	Person		Endings	Example
	Бие	Нөхцөлийн Утга	Нөхцөл	Жишээ
decide-want	1	шийдэн хүсэх	-я, -е, -ё	ярья, босьё, өгье
assign-command		даалган захирах	-сугай/-сүгэй	боссугай, өгсүгэй
imperative		тушаан захиран	$\emptyset$	бос, өг
advise-command	2	зөвлөн захирах	-аарай, -ээрэй, -оорой, -өөрэй	яваарай, ирээрэй, босоорой, өгөөрэй
demand-command		шаардан захирах	-аач, -ээч, -ооч, -өөч	яваач, бичээч, очооч, өгөөч
respect-command		хүндэтгэн захирах	-гтун/-гтүн	босогтун, өгөгтүн
remind-command	3	сануулан захирах	-уузай/-үүзэй	босуузай, өгүүзэй
allow-want		зөвшөөрч хүсэх	-г	босог, өгөг
wish-want		ерөөн хүсэх	-тугай/-түгэй	бостугай, өгтүгэй
dream-wish		мөрөөдөн хүсэх	-аасай, -ээсэй, -оосой, -өөсэй	яваасай, ирээсэй, босоосой, өгөөсэй

□ Practice 19. completing VERBS.

Directions: Find and underline the verbs with personal completing endings.

1. Эх орондоо гавьяатай,  
Энэ дэлхийд нэртэй  
Эрхэм сайн хүн болохын  
Эвтэй сайхан ерөөлийг

Энд дэвшүүлж айлтгая.

2. Урт насалж, удаан жаргаарай.

Энх явж, мөнх жаргаарай.

3. Үрээ танихгүй өнөр,

Үрээгээ танихгүй баян болог.

□Practice 20. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-аач (-ээч, -ооч, -өөч)**.

Model: *Та машин барьж (сур) сураач.*

1. Та надад гадаад явсан зургаа (үзүүл) \_\_\_\_\_ .

2. Энэ хүүхдийг гадаа салхинд авч (гар) \_\_\_\_\_ .

3. Хурдан (ав) \_\_\_\_\_ ээ.

4. Нууц үгээ (соль) \_\_\_\_\_ .

5. Ажилд (ор) \_\_\_\_\_ .

6. Үсээ (самна) \_\_\_\_\_ .

7. Цэцгээ (усал) \_\_\_\_\_ .

8. Наад муу зуршлаа (хая) \_\_\_\_\_ .

□Practice 21. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-ЦГАА (-ЦГЭЭ, -ЦГОО, -ЦГӨӨ) + г**.

1. Би очъё. Тэд нар (ур) \_\_\_\_\_ .

2. Үлгэрийн ном ав. Унтахдаа (уни) \_\_\_\_\_ .

3. Чи дэлгүүрээс харандаа аваарай. Хүүхдүүд зураг (зур) \_\_\_\_\_ .

4. Би пицца авчиръя. Эд нар (ид) \_\_\_\_\_ .

5. Ус хөргөж тавья. Эд нар дараа нь (уу) \_\_\_\_\_ .

6. Өнөөдөр парк руу явъя. Хүүхдүүд (тоглоцгоо) \_\_\_\_\_ .

7. Эд нарт мөнгө өг. Дуртай юмаа (ав) \_\_\_\_\_ .

8. Энэ зун зуслан гаръя. Эд нар агаарт (амар) \_\_\_\_\_ .

□Practice 22. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-аасай (-ЭЭСЭЙ, -ООСОЙ, -ӨӨСЭЙ)**.

Model: *Өнөөдөр бороо (ор) ороосой.*

1. Ах машинаа хурдан барьж (сур) \_\_\_\_\_ .

2. Эгч бид нарт үлгэр ярьж (өг) \_\_\_\_\_ .

3. Болд хоолондоо давс бага (хий) \_\_\_\_\_ .

4. Ээж ажлаа хурдан тарж (ур) \_\_\_\_\_ .

5. Дарга цалин (нэм) \_\_\_\_\_ .

6. Батхуяг мэргэжлээрээ ажил (ол) \_\_\_\_\_ .

7. Миний хүү энэ тэмцээнд (түрүүл) \_\_\_\_\_ .

8. Би сугалаагаар мөнгө (хож) \_\_\_\_\_ .

□Practice 23. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-я/-ө/-ё гэтэл**.

Model: *Гэрээсээ (гар) гаръя гэтэл ах ирэхгүй байна.*

1. Түүнтэй (ярь) \_\_\_\_\_ утсаа авахгүй юм.

2. Гол руу (зугаал) \_\_\_\_\_ өдөр бүр бороо ороод байна.

3. Ажил (ол) \_\_\_\_\_ олдохгүй байна.

4. Ононд (яв) \_\_\_\_\_ татгалзаад байна.

5. Бэлэг (өг) \_\_\_\_\_ юу авахаа мэдэхгүй байна.

□Practice 24. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-уузай/-үүзэй**.

Model: Түүний үгэнд (итгэ) итгүүзэй.

1. Танихгүй хүнд хаалгаа (нээ) \_\_\_\_\_.
2. Унаад, гэмтэж (бэрт) \_\_\_\_\_.
3. Ундаагаа хувцсан дээрээ (асга) \_\_\_\_\_.
4. Шалгалтандаа (уна) \_\_\_\_\_.
5. Захиагаа авахаа (март) \_\_\_\_\_.

□Practice 25. completing VERBS.

Directions: Read the conversation. Find and underline the verbs with personal completing endings.

Дорлиг: – Та нар гараан дээр дахиад очигтун! Анхаарч байгаарай. Марш!

Зогс! Дахиад гараан дээрээ очоод миний хэлэхийг сонсож бай.

Бат: – Түргэлээч дээ, чамайг гуйя. Энэ яршигтай ажлаа хурдан дуусгая.

Дорлиг: – За, Дулмаа хүлээж л байг. Хүлээх гэж ямар байдгийг тэр мэдэж аваг.

Бат: – За за, чиний санаснаар л болтугай. Чамд ямар өрөвдөх сэтгэл байх биш дээ.

Дорлиг: – Чи тайвшир даа. Дасгал одоохон дууслаа шүү дээ.

□Practice 26. completing VERBS.

Directions: Find and underline the verbs with personal COMPLETING endings.

1. Сааль сүү нь дан тос

Сүүл дэл нь цул алт

Алнаас үнэтэй

Ашигт мал сүргээ магтъя.

2. Аав ээж, ах дүү нартаа ач буян, амжилт бүтээлээ өргөсүгэй.
3. Нөхрөө харж биеэ зас, сүүдрээ харж бүсээ зас.
4. Өрх өсгөж, сум сунгаж яваарай.
5. Хүү минь, чи хурдан хонгороо эмээллээд, хуй салхи шиг давхиач.
6. Та нар тавтай морилогтун.
7. Хүний тусыг мартуузай. Хүсэл зорилгоосоо няцуузай.
8. Тэд эвтэй найртай яваг. Энх тунх амьдраг.
9. Саасан сүү сав дүүртүгэй. Санасан хэрэг сэтгэлчлэн бүттүгэй.
10. Эх орон, элгэн садан минь энх амгалан байгаасай.

□Practice 27. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-аарай**

(-ээрэй, -оорой, -өөрэй), **-аач** (-ээч, -ооч, -өөч), -г, **-аасай** (-ээсэй,

**-оосой, -өөсэй), -уузай/үүзэй, -я/-е/-ё.**

1. Цанаар гулгах сайхан байна. Цас орохоо бүү (зогс) \_\_\_\_\_.
2. Маргааш нүүх ажилтай. Өглөө эрт (бос) \_\_\_\_\_.
3. Ямар халуун өдөр вэ! Бороо (ор) \_\_\_\_\_.
4. Халуун чинь буурахгүй бол эмчид очиж (үзүүл) \_\_\_\_\_.
5. Та манайд хоноод яв. Ачаа тань машинд байж (бай) \_\_\_\_\_.
6. Аль тоог ойлгохгүй байна вэ? Би (тусал) \_\_\_\_\_.
7. Би өглөө хаалгаа будсан. Та нар хувцсандаа будаг (хүргэ) \_\_\_\_\_.
8. Би танайд нарны шилээ мартчихжээ. Та маргааш аваад (ур) \_\_\_\_\_.
9. Тэнүүн өдөржингөө ажилласан. Одоо гэр лүүгээ (яв) \_\_\_\_\_.
10. Хүү минь, хурдан (бос) \_\_\_\_\_ . Хичээлээсээ хоцорлоо.

## 5.7 Үйл Үгийн Цаг Заах Төлөв Verb Tense

Endings that show the past, the present, and the future are called *tense* endings.

Хүснэгт 14. Цаг заах төлөвийн нөхцөлүүд Table 14. Verb Tense Endings

Tense	Үйл Үгийн Цаг	Meaning	Ending	Example
-------	---------------	---------	--------	---------

The particles ҮЛ, ЭС are used before the predicate with the tense endings to express the negative meaning.

The particles ШҮҮ, ДАА<sup>4</sup> are used after the predicate with the tense endings to express remind-warning and thinking over meanings.

The future tense can be expressed three different ways:

1. *will + verb* as the verb/-НА (-НЭ, -НО, -НӨ):

Ажил маргаашнаас ЭХЭЛНЭ.

2. *going to* is expressed as -х гэж байна:

Би хот руу өнөө орой ЯВАХ гэж байна.

3. The past tense endings lose the meaning of the past when the verbs express emotion:

Хурдлаарай, онгоц НИСЛЭЭ.

Хүүе, аяна аа!

За, ингээд өнгөрдөг байжээ.

□ Practice 28. completing VERBS.

Directions: Find and underline the verbs. Identify and label their verb tense.

Борогчны талд болжмор жиргэнэ. Хээр талынхаа энэ бяцхан шувууг хичнээн бага хайрлаж яваагаа сая л ухаарлаа. Өвч цасанд дарагдсан өвлийн цагаан талд болжмороос өөр юу ч жиргэдэггүйг сая л анзаарав. Өнөөх шаргал ангир, алаг нугас, цэнхэр тогоруу аль хэдийн анхны цаснаас өмнө хээр талыг минь орхин оджээ. Гэвч тэдгээр шувуу хавар дахиад л ирнэ. Харин өөдсөн чинээхэн энэ болжморууд л өсч төрсөн нутгаа үл орхино.

(Дармаагийн Батбаяр “Борогчны болжмор”)

□ Practice 29. completing VERBS.

Directions: Write the following verbs in their past, present and future forms.

Model: өргөх	өргөсөн	өргөж байна	өргөнө
зээлэх	_____	_____	_____
хэрэглэх	_____	_____	_____
амлах	_____	_____	_____
уйлах	_____	_____	_____
бэлдэх	_____	_____	_____
таах	_____	_____	_____
унших	_____	_____	_____

□ Practice 30. completing VERBS.

Directions: Complete the sentences with the verbs from the following list.

ярих	орох	✓ нүүх
барих	явах	үзүүлэх
эрхлэх	авах	худалдаж авах

- Бид энэ хагас сайнд \_\_\_\_\_ **нүүх** \_\_\_\_\_ гэж байгаа.
- Ээж дэлгүүр \_\_\_\_\_ гэж байна.
- Болдбат шинэ ажилд \_\_\_\_\_ гэж байгаа.
- Тус корпорац шинэ орон сууц \_\_\_\_\_ гэж байна.
- Нараа найзынхаа хуучин машиныг \_\_\_\_\_ гэж байгаа.
- Бид хоёр хувийн бизнес \_\_\_\_\_ гэж байна.
- Хөрш маань хүүхдээ цэцэрлэгээс нь \_\_\_\_\_ гэж байна.
- Би одоо хүүгээ эмчид \_\_\_\_\_ гэж байна.
- Зурагтаар шинэ жүжгийн тухай \_\_\_\_\_ гэж байна.

□ Practice 31. completing VERBS.

Directions: Compare two sentences. Identify the verb tense.

Label them PAST, PRESENT, or FUTURE.

- Машины засварчин цонх *шиллэсэн байж магадгүй.* \_\_\_\_\_ **PAST**

- Машины засварчин цонх *шиллэх байх*.  
 2. Баатарынх малаа энэ худгаас *усалдаг байх*.  
 Баатарынх малаа энэ худгаас *усалж магадгүй*.  
 3. Тэртүүх *судалсан байж магадгүй*.  
 Тэр түүх *судалсан байх*.  
 4. Энэ дэлгүүр *хаагдаж магадгүй*.  
 Энэ дэлгүүр *хаагдсан байж магадгүй*.

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

Practice 32. VERB tense.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-х гэж** form.

Model: *Та хаашаа (нүү) нүүх гэж байна вэ?*

- Хоол (бол) \_\_\_\_\_ байна уу?
- Бид саналаа (өг) \_\_\_\_\_ цугларлаа.
- Болор охиноо сургуульд (оруул) \_\_\_\_\_ бэлдэж байгаа.
- Чулуундорж азаа (тури) \_\_\_\_\_ сугалаа худалдаж авав.
- Манай хүү хичээл дээрээ материал (танилцуул) \_\_\_\_\_ хоёр долоо хоног бэлдэв.
- Бид нарын (үз) \_\_\_\_\_ байсан рок концерт хойшлогдлоо.

Practice 33. VERB tense.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-х гэж байхад** form.

Model: *Би түүнийг ажилдаа (яв) явах гэж байхад нь уулзлаа.*

- Би гадагшаа (гар) \_\_\_\_\_ аадар бороо орлоо.
- Гомбо (нис) \_\_\_\_\_ онгоц нь саатлаа.
- Намуун хичээлээ (хий) \_\_\_\_\_ найз нь дуудлаа.
- Сүрэн ажлаасаа (гар) \_\_\_\_\_ би болиуллаа.
- Би энэ киног (үз) \_\_\_\_\_ найз нар маань өөр кино үзье гэлээ.

Practice 34. VERB tense.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-х гэж байж, -х байж, байж** forms.

- Мэдэхгүй \_\_\_\_\_ цуурхалд үнэмшээд хэрэггүй.
- Өглөө эрт (бос) \_\_\_\_\_ шөнөжингөө зурагт бүү үз.
- Халуунтай \_\_\_\_\_ гадагш бүү гар.
- Машинтай \_\_\_\_\_ автобусаар явж хэрэггүй.
- Ресторан (ор) \_\_\_\_\_ хоол идээд хэрэггүй.

Practice 35. VERB tense.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-х шахлаа** form.

- Машин эвдрээд хөлдөж (үх) \_\_\_\_\_ .
- Чи надаа сануулаагүй бол яг (март) \_\_\_\_\_ .
- Энэ ургамлын тосыг ундаа гэж бодоод (уу) \_\_\_\_\_ .
- Тэр хүүхэд муу дүн авсандаа (уйл) \_\_\_\_\_ .
- Би шөлөө яг (асга) \_\_\_\_\_ .

Нөхцөлийн Утга

Нөхцөл

Жишээ

-в уншив, үзэв

-

Мэдэгдэж

лаа, -

өнгөрсөн

лээ, уншлаа, үзлээ,

Informed

- одлоо, өглөө

Өнгөрсөн

лоо, -

Past

цаг

лөө

		Мэдэгдээгүй өнгөрсөн Non- informed	- жээ/- чээ	тусчээ, үзжээ
Present	Одоо цаг		- ж/-ч байна	уншиж байна, асч байна
Future	Ирээдүй цаг		- на, нэ, но, -нө	уншина, үзнэ, одно, өгнө

## Үйл Үгийн Холбох Хэлбэр Connective Forms of Verbs

### 5.8

The *connective* endings connect the verbs with the other verbs or the nouns.

The connective endings are classified into two categories: *conditional* and *definitive*.

## Үйл Үгийн Нөхцөлдүүлэн Холбох Хэлбэр conditional Connective Form

### 5.8.1

The *conditional connective* form connect the verbs with other verbs, for example:

Уурлаж эхэлбэл ичгүүрээр дуусна.

Хүснэгт 15. Нөхцөлдүүлэн холбох нөхцөлүүд Table 15. Conditional Connective Endings

Name	Нөхцөлийн Нэр	Ending Нөхцөл	Example Жишээ		
Parallel	Зэрэгцэн холбох	-ж/- ч	бичиж, босч		
Coordinating	Зэрэгцүүлэн Холбох	Advancive	Урьдчилан холбох	аад, - ээд, - оод, - өөд	яваад, бичээд, олоод, өгөөд
		Unitive	Хам холбох	-н	бичин, босон
		Continuous	Үргэлжлэн холбох	- саар, - сээр, - соор, - сөөр	явсаар, ирсээр, боссоор, өгсөөр
Concessive	Дутагдан холбох	-вч	бичивч, босовч		
Conditional	Болзон холбох	- вал, - вэл, - вол, - вөл, -	ярьвал, бичвэл, босвол, өгвөл, явбал,		
		-			

			бал, -	болбол, төлбөл, хэлбэл	
			бэл, -		
			бол, -		
			бөл		
			-		
	Preparative	Бэлтгэн холбох	магц, - мэгц, - могц, - мөгц	явмагц, ирмэгц, очмогц, өгмөгц	
			-		
Subordinating	Limitive	Угсруулан Холбох	Угтан холбох	тал, - тэл, - тол, -төл	явтал, иртэл, ортол, өгтөл
			-		
	Ensuive	Дагалдан холбох	хлаар, - хлээр, - хлоор, - хлөөр	авахлаар, бичихлээр, орохлоор, өгөхлөөр	
			-		
	Usive	Далимдан холбох	нгуут/- нгүүт	явангуут, бичингүүт	
			-		
	Benefitive	Дашрамдан холбох	нгаа, - нгээ, - нгоо, - нгөө	явангаа, бичингээ, оронгоо, өгөнгөө	
			-		
	Negative	Үгүйсгэн холбох	- лгүй	бичилгүй, босолгүй	

□ Practice 36. connective VERBs.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-ж/-ч**.

Model: Би түүний хуриманд (оч) очиж чадахгүйдээ харамсаж байна.

1. Би тус ажлыг амжилттай (явуул) \_\_\_\_\_ чадсандаа баяртай байна.
2. Энэ хавар бид мод (суулга) \_\_\_\_\_ байгаа.
3. Бид тэдний төлөвлөгөөтэй (танилц) \_\_\_\_\_ байна.
4. Бид төрөл бүрийн бараа (нийлүүл) \_\_\_\_\_ байгаа.
5. Археологчид ховор амьтны яс (ол) \_\_\_\_\_ шинжив.

□ Practice 37. connective VERBS.

Directions: Combine two sentences into one sentence. Use **-магц (-МЭГЦ, -МОГЦ, -МӨГЦ)**.

Model: Хөгжим дугарав. Хүмүүс бүжиглэв. – Хөгжим дугармагц хүмүүс бүжиглэв.

1. Бялууг жигнэж дуусав. Хөргөгчинд хийж хөргөв.

---

2. Тоо бодов. Толгой сэргэв.

---

3. Нуурын эрэгт очив. Майхнаа засав.

---

4. Салхи хүчтэй салхилав. Тоос шороо бослоо.

---

5. 8 цаг болов. Концерт эхлэв.

---

□ Practice 38. connective VERBS.

Directions: Combine two sentences into one sentence. Use **-нгуут/-нгуут + аа (-ээ, -оо, -өө)**.

Model: *Чи будаг авчир. Би ханаа будна. – Чамайг будаг авчрангуут би ханаа будна.*

1. Хүүгийн хичээл тарна. Бид номын сан орно.

---

2. Би ажил дээрээ очно. Би уулзалтанд орно.

---

3. Миний хүүхэд төрсөн. Түүнд нэр өгсөн.

---

4. Тэр өглөө сэрдэг. Нэг цагийн турш гүйдэг.

---

5. Зун дулаарна. Мэлхий хад руу явна.

---

6. Би босдог. Халуун кофе уудаг.

---

7. Найзындаа оч. Над руу яриарай.

---

8. Онгоц бууна. Надад хэлээрэй.

---

9. Миний охин сэрсэн. Шинэ жилийн бэлгээ хараад баярласан.

---

10. Би ажлаа тарсан. Найзтайгаа ресторанд уулзсан.

---

□ Practice 39. connective VERBS.

Directions: Combine two sentences into one sentence. Use **-нгаа (-НГЭЭ, -НГОО, -НГӨӨ)**.

Model: *Хөгжим сонсов. Дасгал хийв. – Хөгжим сонсонгоо дасгал хийв.*

1. Зурагт үзэв. Цамц нэхэв.

---

2. Машин барив. Дуу дуулав.

---

3. Хоол хийв. Найзтайгаа уулзав.

---

4. Эмчийг хүлээв. Сонин сэтгүүл харж суув.

---

5. Ууланд гарав. Цэцэг түүв.

---

□ Practice 40. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-саар (-СЭЭР, -СООР, -СӨӨР) байгаад** form.

1. Өдөржингөө (*алх*) \_\_\_\_\_ ядарчихлаа.

2. (*Бод*) \_\_\_\_\_ учрыг ойлголоо.

3. Шөнөжингөө (*давхи*) \_\_\_\_\_ үүрээр хүрч очлоо.

4. Хичээлээ (*давт*) \_\_\_\_\_ сайжирсан.

5. Хүнд юм (*өргө*) \_\_\_\_\_ бие нь муудсан.

□ Practice 41. connective VERBS.

Directions: Find and underline the verbs with CONDITIONAL connective endings.

1. Хаврын урь унаж, газар дэлхий цасан цагаан хөнжлөө ногоон магнагаар солив.
2. Нуур цөөрөм, гол мөрөн мөсөн хуягаа тайлаад, нүүдлийн шувууд ирж, жигүүрээ амраан, нуур усандаа жаргалаа.
3. Байгаль ертөнц аажим аажмаар дулаарсаар зуны найртай сайхан улиралтай золголоо.
4. Чухам ийм үед би төрсөн нутгаа зорив.
5. Нутгийн уулс алсад харагдавч улам ойртвол алаглан ногоорон үзэгдэнэ.
6. Уул усандаа ойртон очтол унаган хүү намайгаа тэврэн мэндлэх адил санагдав.
7. Эр хүн өтөлж өвгөрөхлөөрөө унасан газар, угаасан усаа мөрөөддөг нь жам билээ.
8. Багадаа тоглож өссөн Билүүтийн бууцандаа очмогц мориноосоо буун нутгийн агаараар цээж дүүрэн амьсгалангуут хамаг бие сэтгэл амран, дахин төрсөн мэт бодогдоно.

□Practice 42. connective VERBS.

Directions: Combine two sentences into one sentence. Use **-саар (-СЭЭР, -COOP, -CӨӨР)**.

Model: Миний охин хөлд орсон. Хоёр хонож байна.

Миний охин хөлд орсоор хоёр хонож байна.

1. Бид зусланд гарсан. Сар өнгөрч байна.

---

2. Миний эгч Япон явсан. Нэг жил болж байна.

---

3. Манайх адуутай болсон. Долоо хонож байна.

---

4. Шинэ ажилд орсон. Гурван долоо хонож байна.

---

5. Манайх энд нүүж ирсэн. Арван жил болж байна.

□Practice 43. connective VERBS.

Directions: Find and underline the verbs with conditional connective endings.

1. Намрын их хайланга цаг болоод ч тэр үү, морь нь усан хулгана шиг болж, хөх мах нь чичрэн, нүдний ухархайнаас хүртэл хөлс дусалж байхы нь харсан ээжий нь ч бас дуугүй өнгөрсөнгүй.
2. Энэ хэдэн үгийг солилцсоны дараа хэн хэн нь ус балгасан юм шиг хэсэгхэн чимээгүй болж, Цэвэлмаа гэр зуурын ажлыг хийж, Цоодол тамхиныхаа утааг манаруулан суутал Түмэн орж ирэв.
3. Цэн шувуу ирэхэд,  
Цаст уул гэсэхэд,  
Цагаан шарагч гүү унагалахад  
Цаглашгүй их даллага иртүгэй.
4. Сономхүү гэнэт өвчилж, мэс засал хийлгээд, овоо тэнхэрлээ.
5. Орноосоо өндийн эмнэлгийн цонхоор гадагш харвал тэртээ уулын цас энгэрээсээ тарлантан хайлаад, цонхны тушаах модон дээр бяцхан бор шувууд чөлөөтэй нисэн, суун жаргалдана.

NOTE: The conditional connective ending -лгүй can be used with яах вэ. In this case, it has a meaning of permission, agreement, and certainty.

GRAMMAR RULE:

Вэ is a question particle. However, in this case, a question mark is not used.

□ Practice 44. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-лгүй**.

Model: Чи одоо эртхэн (яв) явалгүй болохгүй, оройтох вий.

1. (Тэг) \_\_\_\_\_ яах вэ.
2. Явж (бол) \_\_\_\_\_ яах вэ.
3. Дугуй унаж (чад) \_\_\_\_\_ яах вэ.
4. Сургуулиа (төгс) \_\_\_\_\_ дээ, хэдэн жил болж байна.
5. Энд ганц ирснийх найзтайгаа очиж (уулз) \_\_\_\_\_ бол болохгүй.
6. Завиар (яв) \_\_\_\_\_ удсан байна.
7. Түүнтэй (ярь) \_\_\_\_\_ зургаан сар болж байна.
8. Тэр хаалга (тогши) \_\_\_\_\_ орж ирсэн.
9. Хоолоо (асга) \_\_\_\_\_ идээрэй.
10. Та кинотеатрт кино (үз) \_\_\_\_\_ хэр удаж байна?
11. Зураг (авуул) \_\_\_\_\_ олон жил болжээ.
12. Ном руугаа (хар) \_\_\_\_\_ хэлж мэдэх үү?
13. Идэрээ орж ирэнгүүтээ (мэндэл) \_\_\_\_\_ гараад явчихлаа.
14. Чи хөргөгчөө (хаа) \_\_\_\_\_ орхисон байна лээ.
15. Тэр тэмцээн (дуусга) \_\_\_\_\_ явсан байна.

## 5.8.2 Үйл Үгийн Тодотгон Холбох Хэлбэр Definitive Connective Form

The *definitive connective* endings connect the verbs with the nouns:

Миний төрсөн зуун.

Алсаас ирсэн айлчин.

The definitive connective endings show the past, the present and the future. Therefore, they become predicate in a sentence:

Би өчигдөр ахтайгаа уулзсан.

Ах манайд хааяа ирдэг.

Тэд хөдөө яваа.

Хүснэгт 16. Тодотгон холбох нөхцөлүүд Table 16. Definitive Connective Endings

Meaning	Нөхцөлийн Нэр	Ending Нөхцөл	Example Жишээ
Past	Өнгөрсөн цаг	-сан, -сэн, -сон, -сөн	явсан, орсон, идсэн, одсон
Present	Үргэлжилж байгаа	-аа, -ээ,	яваа, суугаа, нисээ,
Progressive	одоо цаг	-оо, -өө	ороо, өгөө
Present Simple	Байнга үйлдэх одоо цаг	-даг, -дэг, -дог, -дөг	суудаг, ирдэг, ордог, өгдөг
Simple Future	Энгийн ирээдүй цаг	-х	явах, суух
Possible Future	Боломжит ирээдүй цаг	-маар, -мээр, - моор, -мөөр	явмаар, идмээр, ормоор, өгмөөр

A negative ending **-гүй** is used after the definitive connective ending and shows that no action happened, is happening, or will happen:

явсан – явсангүй

уулзаж байна – уулзаагүй байна

буцдаг – буцдаггүй

мэдэх – мэдэхгүй

When expressing that someone is good/not good at something, a dative case ending is added to the noun and -хдаа, (-ХДЭЭ, -ХДОО, -ХДӨӨ) is added to the verb. The verb can be omitted. In that case the noun takes the dative case ending:

морь унахдаа сайн –  
(уна + х + д + аа)

моринд сайн

GRAMMAR RULE:

In a role of nouns, the verbs with definitive connective endings can take the plural, case and possessive endings:

Дуулсныг хураавал эрдэм. The word *дуулсныг* is in the accusative case.

□Practice 45. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use -х.

1. Нар (*шингэ*) \_\_\_\_\_ дөхжээ.
2. Өвлийн тасхийм хүйтэн шөнө бүдэг гэрэлтэй байшинд (*сууцгаа*) \_\_\_\_\_ хэдэн хүн бол намын гишүүд байжээ.
3. Равжаа одоо хэрэв энх тунх байгаа бол түүнтэй уулзаж (*яриц*) \_\_\_\_\_ юмсан.
4. Төрөлх нутаг, газар шороогоо хайрлан (*хамгаал*) \_\_\_\_\_ ёстой.
5. Байгаль дэлхийн баялаг ховордож (*хомсд*) \_\_\_\_\_ нь нөхөгдөж сэргэхээсээ хурдан байдаг.
6. Нарангэрэл хүү мөчир хугалсан оромжноос нь зөндөө их давирхай гоожсон нь цус гарсан мэт санагдаад, тун их (*гэмш*) \_\_\_\_\_ сэтгэл төржээ.

□Practice 46. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use -х.

Model: Би (*бүжиглэ*) бүжиглэх дуртай.

1. Урт (*насла*) \_\_\_\_\_ нь нийгмийн болон амьдралын байдлаас хамаарна.
2. Би балет (*үз*) \_\_\_\_\_ дуртай.
3. Хүүхдийн ордонд соёл урлагийн үйлчилгээ (*явуул*) \_\_\_\_\_ гэж байгаа.
4. Хүүхдийг амьдралд (*бэлтгэ*) \_\_\_\_\_, шинийг эрэлхийлсэн бүтээлч ухаанд (*сурга*) \_\_\_\_\_ нь гол зорилт болж байна.
5. Та кофе (*уу*) \_\_\_\_\_ дуртай юу?
6. Банкинд мөнгө (*тушаа*) \_\_\_\_\_, мөнгө (*ав*) \_\_\_\_\_ зэрэгт маягт хэрэглэдэг.
7. Бат усанд сэлж, хөл бөмбөгийн спортоор (*хичээллэ*) \_\_\_\_\_ дуртай.

□Practice 47. connective VERBS.

Directions: Circle the right verb in parentheses.

1. Тараг бүрэхэд хөрөнгө, сүүний халаалтаа (*тохируулсан, тохируулах*) нь чухал.
2. Айргийн амт чанар саамын найрлагаас гадна хүний ур чадвараас ихээхэн (*шалтгаалсан, шалтгаална*).
3. Манай ардын аман зохиолд цэцэн оюун билэгтний уран үгс уламжлагдаж (*иржээ, ирдэг*).
4. Ёгт үлгэр нь хүмүүсийн хоорондох харилцааг адгуусан амьтад, тэдний хооронд болж байгаа үйл явдлаар (*төлөөлүүлсэн, төлөөлүүлсэн байдаг*).
5. Анх энэ зусланд ирээд, орой харуй бүрийд гарахаасаа ч (*айсан, айдаг байж*) билээ.
6. Бид хамтдаа нэг сургууль төгсч, тус тусын мөрөө хөөх (*болдог, болсон*).
7. Амжилттай явахад шантрахгүй байх нь чухал үүрэг (*гүйцэтгэсэн, гүйцэтгэдэг*).

□Practice 48. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use -Х + ын/ийноронд.

Model: Өдөржин (*унт*) унтахын оронд босч үр бүтээлтэй юм хий.

1. Юм (үз) \_\_\_\_\_ явж цанаар гулгая.
2. Айлтай цуг (амьдар) \_\_\_\_\_ тустаа гар.
3. Хүний гар харж (суу) \_\_\_\_\_ өөрөө босоод хий.
4. Өнөөдөр уул руу (яв) \_\_\_\_\_ гол руу явцгаах уу?
5. Хүний эрхээр (жарга) \_\_\_\_\_ өөрийн эрхээр зов.

□Practice 49. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-х юмсан**.

Model: Уулын орой дээр (гар) гарах юмсан.

1. Зуны амралтаараа Тэрэлж (яв) \_\_\_\_\_ .
2. Алдсан мөнгөө (ол) \_\_\_\_\_ .
3. Өнөө орой кино (үз) \_\_\_\_\_ .
4. Өнөөдөр ээжийгээ (баярлуул) \_\_\_\_\_ .
5. Найзыгаа очиж (эргэ) \_\_\_\_\_ .

□Practice 50. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use the appropriate endings.

1. Өчигдөр итали ресторанд лазанья (ид) \_\_\_\_\_ .
2. Ус түмэн бодисыг (тэжээ) \_\_\_\_\_ .
3. Одоо явдаг цаг ойртож дээ гэж санамагц халуун зүрхний цохилт олширч, ирээдүйн баясгалант аж байдлыг (угт) \_\_\_\_\_ .
4. Энэхнийг эргэцүүлэн бодохын зуур хонин сүрэг нь салхи сөрөн (явчих) \_\_\_\_\_ .
5. Манай үе тэнгийнхэн чөлөөт цагаа янз бүрээр (өнгөрөө) \_\_\_\_\_ .
6. Хөнгөн атлетикийн улсын аваргын тэмцээнд хот хөдөөгийн зуу гаруй тамирчин (оролц) \_\_\_\_\_ .

□Practice 51. connective VERBS.

Directions: Find and underline the verbs with both conditional and definitive connective endings.

Хуучин хүү хул морин дээрээ хөндлөн сууж хатируулсаар хүрч ирэв. Цагаан даавуу алчуураар толгойгоо ороожээ. Ширэлдсэн хар гэзгийн сэрвийсэн хэдэн үс нь шанаа руу нь унжина. Тавхийтэл мориноосоо буун, тасхийтэл жолоогоо сойгоод, тоосонд дарагдсан урт хормойгоороо наранд борлосон нүүрнийхээ хөлсийг арчиж, нусаа хүрхийтэл нийгээд гэрт оров.

(Дашдоржийн Нацагдорж “Хуучин хүү”)

□Practice 52. connective VERBS.

Directions: Find and underline the verbs with definitive connective endings.

1. Түүний ярих нь хурдан, хийх нь удаан тул хамт ажиллаж байгаа нөхөд нь бүр залхжээ. Тэдний ярьдгаар бол, Дорж хагархай хэнгэрэг л гэсэн үг. Юу ярьж байгаагаа ч бараг мэдэхгүй. Өчигдөр орой байрандаа намайг ирэхэд тэр их л урвагар царайтай сууж байв. Учрыг нь асуувал, би хүний хэлдгийг хэлж, хийдгийг хийж чадна шүү. Чи хүнийг битгий доромжлоод байгаарай гэж хэлээд гарч одлоо. Би түүний тухай юу ярьснаа бодоод бодоод олсонгүй.
2. Хяруу унасан намрыг өглөө хаярах үүрээр эртлэн босов. Махирласан голын эрэг рүү очиж, мэхээрийн хулганын зоорийг хайв.

□Practice 53. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Change the verbs into negative.

Use **-аагүй (-ээгүй, -оогүй, -өөгүй), -х + гүй**.

Model: Би өчигдөр жүжиг (үзсэн) үзээгүй. Би өнөөдөр жүжиг (үзнэ) үзэхгүй.

1. Дарьсүрэн өнөөдөр ажилдаа (явна) \_\_\_\_\_ .
2. Хүүхдүүд гадаа (гарсан) \_\_\_\_\_ .
3. Ажилчид бямба гаригт (амарсан) \_\_\_\_\_ .
4. Болд гэртээ (харьсан) \_\_\_\_\_ .

5. Охин минь захиа (бичсэн) \_\_\_\_\_ .
6. Тулгаагийн аав ээж нь энэ хавар ногоо (тарина) \_\_\_\_\_ .
7. Тэднийхэн энэ жил хотод (амьдарна) \_\_\_\_\_ .
8. Би даваа гаригт өдөр (ажилласан) \_\_\_\_\_ .
9. Бид орой ресторанд (хооллоно) \_\_\_\_\_ .

□Practice 54. connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Add -ж/-ч өгөх to the verbs. Use the appropriate tense.

1. Би та нарт энэ ховор ургамлын тухай (ярь) \_\_\_\_\_ .
2. Охин хүү хоёр ээждээ зураг (зур) \_\_\_\_\_ .
3. Би дүүдээ орчин үеийн поп дууны си-ди (ав) \_\_\_\_\_ .
4. Оюунгэрэл намайг онгоцны буудал руу (хүргэ) \_\_\_\_\_ .
5. Ах надад түүхийн ном (ол) \_\_\_\_\_ .
6. Ээж маань дүү бид нарт малгай, ороолт (нэх) \_\_\_\_\_ .
7. Чи Тэгшсайханы мартсан хавтсыг нь ажил дээр нь (аваач) \_\_\_\_\_ .
8. Дарга хөдөө явахдаа ажлаа туслахдаа түр (хүлээлгэ) \_\_\_\_\_ .
9. Баатар найзынхаа эвдэрсэн машиныг (зас) \_\_\_\_\_ гэж байгаа.
10. Би чамд өрөөг чинь (янзал) \_\_\_\_\_ .

□Practice 55. VERB tense.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use the appropriate tense.

1. Сэрүүн сайхан Туул голын хөвөөнд, сэргэлэн сайхан дэнж дээр үзэсгэлэн төгөлдөр олон янзын гэрэл солонгорсон үзэмжит шинэ хот (сүндэрлэ) \_\_\_\_\_ .
2. Энэ ертөнцөд хүн гэж (төр) \_\_\_\_\_ , эрдэм сурахгүй тэнэгээр (өтөл) \_\_\_\_\_ үү?
3. Ухаан хэдий сэргэлэн боловч уурлахаараа мунхаг (бол) \_\_\_\_\_ .
4. Булаг ус (бургил) \_\_\_\_\_ , цэцэг ногоо жигдэрсэн өргөн сайхан талын дунд уяхан эгшиг (хангина) \_\_\_\_\_ , уургын үзүүр үе үе (сэрвэлз) \_\_\_\_\_ .
5. Урьхан салхи (сэвэлз) \_\_\_\_\_ , горхины бяцхан хүрхрээ (шуугь) \_\_\_\_\_ , зуны улирлын ариун анхилам агаар цээж дүүрэн (амьсгал) \_\_\_\_\_ .
6. Түмэн бодисын (улир) \_\_\_\_\_ хувьсахыг судалдаг шинжлэх ухааныг биологийн шинжлэх ухаан (гэ) \_\_\_\_\_ .
7. (Ажилла) \_\_\_\_\_ гэвэл сур. (Сур) \_\_\_\_\_ гэвэл оролд.
8. Эрдэнэ хэдэн жилийн өмнө ямар ч халхавчгүй өргөн говьд машинтай (яв) \_\_\_\_\_ байгаад, бүтэн хоёр хоног угалзанд (цохиул) \_\_\_\_\_ тул говийн угалзын аюулыг сайн мэднэ.
9. Сүхбаатар консулын дэнжийн орос хүүхдүүдтэй (тогло) \_\_\_\_\_ (наад) \_\_\_\_\_ явахдаа оросоор бага сага ярих (бол) \_\_\_\_\_ .
10. Цахир цагаан хяруунд (хучигд) \_\_\_\_\_ жихүүцэн даарсан навчис дагжин (чичирхийл) \_\_\_\_\_ , өнгө алдсаар нэг хоёроороо унаж (эхэл) \_\_\_\_\_ .

□Practice 56. connective VERBS.

Directions: Read the verb phrases and the verbs with auxiliary verb байх.

Add a word to make them free phrases.

- уншиж байх \_\_\_\_\_
- оюутан болох \_\_\_\_\_
- сурч эхлэх \_\_\_\_\_

гарч өгөх \_\_\_\_\_  
идэж орхих \_\_\_\_\_  
бичиж суух \_\_\_\_\_  
ингэвэл таарах \_\_\_\_\_  
дулаан болох \_\_\_\_\_  
ажиллаж байх \_\_\_\_\_

□Practice 57. structure of VERBS.

Directions: Complete the sentences with the words in parentheses.

Use **-х + д + аа (-ээ, -оо, -өө)**.

Model: Нөхөр маань морь (уна) унахдаа сайн.

1. Дамба шатар (нүү) \_\_\_\_\_ сайн.
2. Та спорт (хичээллэ) \_\_\_\_\_ хэр зэрэг вэ?
3. Хулан тоо (бод) \_\_\_\_\_ сайн.
4. Наран хэл (сур) \_\_\_\_\_ хэр зэрэг вэ?
5. Ах чинь (бүжиглэ) \_\_\_\_\_ сайн уу?
6. Эгч юм (оё) \_\_\_\_\_ сайн.
7. Эмээ (дуул) \_\_\_\_\_ сайн.
8. Би усанд (сэл) \_\_\_\_\_ тийм ч сайн биш.
9. Тэр залуу ажил (хий) \_\_\_\_\_ сайн.
10. Цэдэндорж эмч хүнтэй (харьц) \_\_\_\_\_ хэр вэ?

□Practice 58. structure of VERBS.

Directions: Complete the sentences with the verbs. Change the adjectives in parentheses into verbs. Use **-д + аад (-ээд, -оод, -өөд) байна**.

Model: Ажил маань гэрээс (хол) холдоод байна.

1. Энэ пиджак надад (хөгийн) \_\_\_\_\_ .
2. Энэ бүс надад (нарийхан) \_\_\_\_\_ .
3. Энэ ачаа надад (хүнд) \_\_\_\_\_ .
4. Надад ажиллах хүч (цөөхөн) \_\_\_\_\_ .
5. Энэ туфли надад (бага) \_\_\_\_\_ .
6. Миний дээл надад (нимгэн) \_\_\_\_\_ .
7. Шүдээ угаахад энэ ус (хүйтэн) \_\_\_\_\_ .
8. Энэ ор надад (зөөлөн) \_\_\_\_\_ .
9. Өдөн куртка надад (зузаан) \_\_\_\_\_ .
10. Энэ чихрийг хазахад (хатуу) \_\_\_\_\_ .
11. Таны харц түүнд арай (ширүүн) \_\_\_\_\_ .

□Practice 59. VERB tense.

Directions: Complete the sentences with the words in parentheses.

Use **-ж/-ч байсан**.

Model: Та зургаан сарын өмнө хаана юу (хий) хийж байсан бэ?

1. Би долоо хоногийн өмнө Архангайд (ажилла) \_\_\_\_\_ .
2. Хоёр цагийн өмнө би үдийн хоолоо (ид) \_\_\_\_\_ .
3. Таван жилийн өмнө би их сургуульд (сур) \_\_\_\_\_ .
4. Гучин минутын өмнө би оюутнуудад хичээл (заа) \_\_\_\_\_ .

□Practice 60. VERB tense.

Directions: Circle the right verb in parentheses.

1. Хаврын нэг сайхан орой (байна, байлаа).
2. Би өөрийн нэрийг (сонсож, сонсоод) итгэсэнгүй.
3. Өнгөрсөн долоо хоногт шинэ жүжиг (гарч байгааг, гарч эхэлснийг) сонссон уу?

4. Эхнэр чинь ямар үнэртэй усанд (*дуртай, дуртайг*) мэдэх үү?
5. Малчин охин Гаамаа (*баярлаж хөөрсөндөө, баярлаж хөөрөхдөө*) тэр шөнө унтаж чадсангүй.
6. Үр хүүхдээ хар багаас нь бэрхшээлээс үл (*шантардаггүй, шантардаг*) болгохыг эрмэлзэнэ.

□Practice 61. VERB tenSe.

Directions: Complete the sentences with the words in parentheses.

Use **-х + аас (-ЭЭС, -ООС, -ӨӨС) өмнө**.

Model: Хичээлдээ (яв) *явах*аас өмнө өглөөний цайгаа уугаарай.

1. Очиж (уулз) \_\_\_\_\_ утсаар ярьж тохироорой.
2. Ээжийг (ир) \_\_\_\_\_ хоолоо хийнэ.
3. Шинэ жил (бол) \_\_\_\_\_ хүүхдүүддээ бэлэг авна.
4. Амралтанд (яв) \_\_\_\_\_ энэ ажлаа дуусгана.
5. Хүүхдээ (төр) \_\_\_\_\_ гэрээ янзалж тохижуулна.
6. Худалдаж (ав) \_\_\_\_\_ сайн шалгаж үзээрэй.

□Practice 62. VERB tenSe.

Directions: Complete the sentences with the words in parentheses. Use **-ж/-Ч байгааг**.

Model: Би түүнийг (ан хий) *ан хийж байгааг* мэдээгүй.

1. Тэргэлийг хоол (хий) \_\_\_\_\_ хэзээ ч хараагүй.
2. Чамайг түүнтэй (гэрлэ) \_\_\_\_\_ би мэдээгүй.
3. Ээжийг нь гадаад (яв) \_\_\_\_\_ дуулаагүй.
4. Чамайг усанд (сэл) \_\_\_\_\_ хэзээ ч хараагүй.
5. Тэр түүний зардлыг (даа) \_\_\_\_\_ би мэдээгүй.

□Practice 63. conditional VERBS.

Directions: Read the sentences. Identify the endings of the *italicized* verbs.

1. Дамбыг гэртээ ирэхэд дүү нь *явчихсан* байлаа.
2. Тэрээр орон дээрээ *суузнах* зуур гаднаас хүүхдүүд дуудав.
3. Цочин босч *гүйсхийн* гарахад хэдэн шавь нь хаалган дээр зогсож байлаа.
4. *Явцгааж* байтал цэргийн бааз тааралдав.

□Practice 64. VERBS.

Directions: Read a poem. Memorize it.

Аргалын утаа боргилсон  
 Малчны гэрт төрсөн би  
 Атар хээр нутгаа  
 Өлгий минь гэж боддог.  
 Цэнхэр манан суунагласан  
 Алсын барааг ширтээд,  
 Цэлгэр сайхан нутгаа  
 Сэтгэл бахдан харахад  
 Үлээж байгаа салхи нь  
 Үнсээд ч байгаа юм шиг,  
 Өршөөлт ээжийн минь гар  
 Илээд ч байгаа юм шиг.  
 Энэрэнгүй сайхан санагдахад  
 Элэг зүрх минь догдолж,  
 Хосгүй баярын нулимс  
 Хоёр нүдийг минь бүрхдэг.

(Дашдоржийн Нацагдорж “Би Монгол хүн”)

□Practice 65. VERB phraseS.

Directions: Categorize the phrases in the sentences according to the structures

given below.

1. Бат ахынхаа тухай *ярих тусам* Сүхийн сэтгэлд аав нь орж ирнэ.
2. Мөнөөх чоно цагаан гэгээ *орохтой зэрэг* хил даваад явчихдаг байв.
3. Нэг цаг орчим *эргэцүүлсний хойно* арай гэж нэг сэдэв олов.
4. Бас цайгүй *болохтой зэрэг* гар бүр хөдлөхгүй, нүд ч бүрэлзээд байх юм.
5. Итгэлт, Ням гуай хоёрыг элдвийг *ярилцан байх завсар* Хишигт гуай архи халааж аягалав.
6. Энэ дууг Дагданы эхнэр *сонссон даруй* гэрийн үүдийг чанга хаян гарч ирнэ.
7. Өндөрт *гарах тутам* дэлхий уужран тэнгэр цэлийнэ.
8. Энэ орой гэрийн эзэд *ёслох цагаалахын хамт* гаднаас зочид гийчид ирэх нь тоогүй олон.

1) noun + auxiliary word: \_\_\_\_\_

2) verb + auxiliary word: \_\_\_\_\_

3) noun + conjunction: \_\_\_\_\_

4) verb + conjunction: \_\_\_\_\_

□ Practice 66. definitive connective verbS.

Directions: Complete the comparison sentences with the verbs in parentheses.

Use **-САН (-СЭН, -СОН, -СӨН) + аас (-ЭЭС, -ООС, -ӨӨС)**.

Model: *Очиж (уулз) уулзсанаас утсаар ярьсан нь дээр.*

1. Гадуур явж (*хай*) \_\_\_\_\_ интернетээр хайсан нь дээр.
2. Биеэрээ очиж цаг (*алд*) \_\_\_\_\_ утсаар ярьсан нь дээр.
3. Аль хэдийн өглөө болсон хойно оройтож (*бос*) \_\_\_\_\_ эрт босч, ажил амжуулсан нь дээр.
4. Өөх тос ихтэй юм (*ид*) \_\_\_\_\_ ногоо жимсийг илүү хэрэглэсэн нь биенд сайн.
5. Зурагт байнга үзэж (*суу*) \_\_\_\_\_ гадаа агаар салхинд гарч байсан нь дээр.

□ Practice 67. definitive connective VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-маар (-МЭЭР, -МООР, -МӨӨР) байна**.

1. Би өлсөж байна. Юм (*ид*) \_\_\_\_\_ .
2. Би халууцаж байна. Усанд (*сэл*) \_\_\_\_\_ .
3. Ядарч байна. (*Амар*) \_\_\_\_\_ .
4. Усан онгоцоор явж (*үз*) \_\_\_\_\_ .
5. Хүүхэдтэй (*бол*) \_\_\_\_\_ .
6. Бүжгэнд (*яв*) \_\_\_\_\_ .

## Үйл Үгийн Баймж Чанар Modal Verbs 5.9

The modal particles, such as шүү, даа, даг, юм, биз, байх, бололтой, хэрэгтэй, хэрэггүй, ёстой, ёсгүй, байлгүй are used after the predicate with the definitive connective endings (see Table 16, page 84) and express different additional meanings:

явсан шүү	явах хэрэгтэй
явсан юм	явах ёстой
явсан даг	явсан бололтой
явсан биз	явсан байх

NOTE: The modal particle хэрэггүй can take endings -Ж/-Ч, -САН (-СЭН, -СОН, -СӨН)+ Ы/ИЙ:

тийшээ ЯВЖ хэрэггүй

мөнгө ТӨЛСНИЙ хэрэггүй

мод руу АВИРЧ хэрэггүй

над руу ЯРЬСНЫ хэрэггүй

үүнд ГАЙХСАНЫ хэрэггүй

тэднийд ОЧСОНЫ хэрэггүй

□ Practice 68. modal VERBS.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use the appropriate endings.

1. Чи онгоц (*нисгээ*) \_\_\_\_\_ чадах уу?
2. Би маргааш танайд (*оч*) \_\_\_\_\_ чадна.
3. Би танай саналыг хүлээн (*ав*) \_\_\_\_\_ чадахгүй.
4. Тангай (*уулз*) \_\_\_\_\_ болох уу?
5. Чи манайд түр (*бай*) \_\_\_\_\_ болно.
6. Цаг орой болсон хойно хүүхдүүд гадаа (*гар*) \_\_\_\_\_ болохгүй.
7. Би энэ тэмцээнд заавал (*түрүүл*) \_\_\_\_\_ хэрэгтэй.
8. Хүйтэн усанд (*ор*) \_\_\_\_\_ хэрэггүй.
9. Үүнийг заавал өнөөдөр (*дуусга*) \_\_\_\_\_ хэрэгтэй юу?
10. Би үүнийг (*орчуул*) \_\_\_\_\_ хэрэггүй юу?

# 6 Тэмдэг Нэр Adjectives

## 6.1 Тэмдэг Нэр Бүтэх Ёс Formation of Adjectives

The *adjectives* are a word class that expresses quality, color and shape and size. They play a role of a complement. They are used in their word base form and do not take endings:

quality: хурдан, гайхамшигтай, эрэлхэг, хурдан, удаан, баян

color: улаан, ягаан, цэнхэр, цагаан, хөх, хээр, хул, буурал

shape and size: гонзгой, бүдүүн, том, сартгар, гурвалжин, хавтгай

Adjectives can act as nouns when a noun is omitted. In this case, they can take endings:

Сайныг дагавал сарны гэрэл. – Сайн (хүнийг) дагавал сарны гэрэл.

Улаануудыг нь би идсэн. – Улаан (өнгөтэйнүүдий) нь би идсэн.

### □Practice 1. ADJECTIVES.

Directions: Find and underline the adjectives.

1. Шиврээ борооны чийг ханхлан, газраас бүлээн уур савсаж, нарсан ойн шулуухан модод улам ч урт гоолигхон болчихсон харагдана.
2. Нар дээр хөөрч, ойн доторх гялалзсан сахлаг ногооны өнгө бүдгэрч, моддын завсар зайгаар хөх суунаг татна.
3. Удаж өжсөн хөвд өвсний үнэрийг нялх ногооны сэнгэнэсэн үнэр, цэцгийн хурц анхилам үнэр даран ханхална.
4. Ойн тунгалаг агаарт шувуудын шулганан жиргэх нь сэтгэлд жигтэй зохицох бөгөөд алс тэнгэрийн хаяа бүдэгхэн саарал өнгөтэй болжээ.
5. Зулзаган нарсны торгон үзүүрийн дээгүүр хөх тэнгэр мэлтийж, үдийн нар бид хоёрын чанх орой дээр гарчээ.
6. Горхины хоёр хөвөөгөөр ойрхон ойрхон олон хот айл бууж, хөндий дүүрэн мал багшран, нутгийн айлууд булгийн эхээс нэлээд доогуур зусна.

Хүснэгт 17. Нэр үгээс тэмдэг нэр үүсгэх дагаврууд

Table 17. Suffixes That Form Adjectives From Nouns

Дагавар Suffixes	Жишээ Example
-н	тарган, хурдан, уран, цэцэн
-тай, -тэй, -той, -т	амжилттай, зоригтой, эрчимтэй, амттай, аюулт, үзэсгэлэнт, гэрэлт
-гүй	зориггүй, амжилтгүй, модгүй, чимээгүй, гэрэлгүй, элсгүй
-гч, -гчин	борогч, хулагч, шарагч, харагч, хөхөгчин, цагаагчин
-лаг (-лэг, -лог, -лөг)	хүрлэг, шинэлэг, модлог, эвлэг, чинээлэг, өөхлөг
-рхаг (-рхэг, -рхог, -рхөг)	усархаг, үсэрхэг, сөлөрхөг, хүчирхэг, найзархаг, тосорхог, өвсөрхөг

Хүснэгт 18. Үйл үгээс тэмдэг нэр үүсгэх дагаврууд

Table 18. Suffixes That Form Adjectives From Verbs

Дагавар Suffixes	Жишээ Example
-уу/-үү	ядуу, хатуу, хөлдүү, тэвдүү, дээрэлхүү, ёсорхуу
-уун/-үүн	хөшүүн, халуун, өрнүүн, аргуун, дэврүүн
-н	дүүрэн, доголон, салан
-нга, -нгэ, нгө, нги	байнга, сөөнгө, тогтонги, саланги, зогсонги, татанги, жийнгэ
-нгуй/-нгүй	давшингуй, хураангуй, үсрэнгүй, дэлгэрэнгүй
-г	махлаг, гоёмсог, хүчирхэг, эрэлхэг, цэнгэг, эрхэмсэг

-маг (-мэг, -мог, -мөг)	чадмаг, сурмаг, хуурмаг, цочмог
-мхай/мхий, -мгай/-мгий	аймхай, идэмхий, сурамгай, түрэмгий
-мтгай/-мтгий	гуймтгай, сургамтгай, үрэмтгий
-хай, -хий, -хой	тодорхой, балархай, хагархай, цоорхой, эвдэрхий
-нхай, -нхий, -нхой	туранхай, эцэнхий, татанхай, цооронхой
-уур/-үүр	хянуур, няжуур, долгинуур, гэдгэнүүр
-аа (-ээ, -оо, -өө)	гуншаа, нуршаа, үглээ, гувшаа, босоо, хэвтээ, орилоо
-га (-гэ, -го, -гө)	шударга, аварга
-мал (-мэл, -мол, -мөл)	зурмал, бэлдмэл, будмал, сонгомол, тогтмол, түгээмэл, өрмөл
-шгүй	хувиршгүй, хөдөлшгүй, харьшгүй
-ууштай/-үүштэй	авууштай, хийгүүштэй, сонсууштай, хэлүүштэй

Хүснэгт 19. Идэвхгүй язгуураас тэмдэг нэр үүсгэх дагаврууд

Table 19. Suffixes That Form Adjectives From Passive Stems

Дагавар Suffixes	Жишээ Example
-гар <sup>4</sup>	саргар, сэргэр, гэдгэр, бөндгөр, тонтгор
-р	долир, солир, хялар
-н	дэлдэн, шодон, годон
-гай, -гий, -гой	хазгай, хэлтгий, хавтгай, гонзгой, гулзгай
-д, -т	дээд, хойт, гадаад

□ Practice 2. ADJECTIVES.

Directions: Find and underline the adjectives. Tell what they express.

Чулууны өнгө тоолж баршгүй олон. Улаан, ногоон, бор, шар, хөх, цагаан чулуу дангаараа буюу холилдон оршино. Чулуу бас зөөлөн, хатуу, халуун, хүйтэн, иртэй, иргүй, мөлгөр, бас бүлээхэн, эелдэг байдаг. Өндөр уулын орой дээрх чулуу салхины урсгалд элэгдэн зөөлөрсөн боловч хүйтэн байна. Харин асгын чулуу юунд ч элэгдээгүй учир хатуу, хурц, бас хүйтэн байдаг. Аяа, чулуу чи ертөнцийн хөрсөнд ургасан хатуу цэцэг юм билээ.

(Дармаагийн Батбаяр)

□ Practice 3. structure of ADJECTIVES.

Directions: How are the following adjectives formed from the other parts of speech?

Underline the adjectives that are non-formed.

мартамхай	ууртай	уйтгартай	ухамсартай
унтамхай	тайван	журамт	тэнэг
аймхай	хувиа бодсон	сайхан сэтгэлтэй	нөхөрсөг
сурамгай	худалч	ухамсаргүй	ганцаардуу
түрэмгий	эрэмгий	хэлэмгий	нүүрэмгий
ичимхий	хариуцлагатай	хариуцлагагүй	залхуу
ажилсаг	тэвчээртэй	тэвчээргүй	аминчхан
нийтгэч	харамч	өглөгч	тусламтгай

□ Practice 4. ADJECTIVES.

Directions: Complete the sentences by choosing your own words. Express your opinion.

1. Миний найз \_\_\_\_\_ хүн.
2. Миний багш \_\_\_\_\_ хүн.
3. Миний аав \_\_\_\_\_ хүн.

□ Practice 5. ADJECTIVES.

Directions: Find and underline the adjectives.

1. Өдөр гурвалжин, шөнө дөрвөлжин. (Өрх)
2. Салхитай тэнгэрийн үүл хурдан,  
Саруул ухаантны санах хурдан,  
Сайн морины явдал хурдан.
3. Өртэй хүний өнөөдөр олон,  
Өнчин хүний ноён олон,  
Өрөвч хүний хөөрхий олон.
4. Бой нь арилсан хүүхэд нэг хөөрхөн,  
Борвио нээсэн унага нэг хөөрхөн,  
Босч тэнцэж байгаа ботго нэг хөөрхөн.

□ Practice 6. ADJECTIVES.

Directions: Identify the adjectives and the nouns in comitative case.

- |               |                   |                   |
|---------------|-------------------|-------------------|
| ✓ ахтай уулз  | аавтайгаа адилхан | ээжтэйгээ хамт    |
| ✓ модтой уул  | ухаантай хүн      | чонотой тааралд   |
| өвстэй газар  | багштай ярь       | зоригтой барилд   |
| ботготой ингэ | эмээлтэй морь     | найзтайгаа барилд |

1. Adjectives: модтой уул. \_\_\_\_\_

\_\_\_\_\_

2. Nouns in the comitative case: ахтай уулз. \_\_\_\_\_

\_\_\_\_\_

□ Practice 7. ADJECTIVES.

Directions: Find and underline the adjectives.

Сайн морины нүд нь ширүүн болон уулирхай\* бөгөөд шөрмөс нь сэртгэр, цээж нь нимгэн хавчуу, магнай нь зузаан, бэрэвхий нь богино, хойт туруу нь моголцог урт, шөрмөс нь хийтэй, тэлүү өргөн, сэрвээ өндөр, аман хүзүү бүдүүн, толгойн мах хатингар, олон ясны уулзвар агуу, сүвээний хавирга матаастай, тэлүү, ташаа нь цухал, зоо нуруу нь бөгтөрдүү, хөл нь эрс шударга, хүзүү нь нарийн урт, сүүл нь эрчтэй хатуу, бөгс нь туранхайвтар байх ажээ.

(Халтарын Лувсанбалдан “Хүлгийн шинж”)

\* уулирхай – нулимс гүйлгэсэн

□ Practice 8. ADJECTIVES.

Directions: Read the praise words. When do you say them?

1. Урт насалж, удаан жарга.

Энх явж, мөнх жарга.

2. Буурал жил морилж, буянтай жил ирж,

Өвгөн жил морилж, өлзийтэй жил ирж,

Баясгалантай шинэлсний билгийг айлтгая!

3. Эд нь хэврэг, эзэд нь мөнх байх болтугай!

4. Дал хүртлээ дал хувааж идье.

5. Унасан морь чинь жороо бол,

Унага даага чинь хурдан бол,

Ухаан санаа чинь сэргэлэн бол.

□ Practice 9. ADJECTIVES.

Directions: Read the sentences. Find and underline the adjectives.

1. Ялгуун саарал морь нь тогтон ядан, гоо сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар.

2. Монголын дорнот тал талбиун болоод цэнхэр, монгол хүний сэтгэл талаан дагаад тэнэгэр.
3. Шударга гэгч зөрүүдийг биш, шантаршгүйг хэлдэг.
4. Мөрөн гол цутгалант ширгэшгүй их далай мэт,  
Мөнхөд үр ач нарын залгамжаар бадранхан дэлгэрч,  
Хөндий цээжинд орогч бүгдийг нэвтрүүлэх чадалт,  
Хөгжим мэт яруу баясгалант монгол хэл минь.
5. Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа. Элстэй шанд, буттай цайдмыг дагаж хааяа нэг бор гэрээс утаа суунаглана.

## Тэмдэг Нэрийн Эрчимжүүлсэн ба Бууруулсан Утга 6.2

### Intensified and Diminished Adjectives

The general meaning of adjectives can be *intensified* **эрчимжүүлсэн утга** or *diminished* **бууруулсан утга**.

Particles that intensify the adjective:

ЦОО шинэ	ПАД хар	ЦЭВ цэвэрхэн
НЭН хурдан	ЧАС улаан	ШАЛ тэнэг
ЧАС халуун	ТУН шударга	МАШ хатуу
ДӨВ дөрвөлжин	БӨВ бөгтөр	ПИГ дүүрэн

The suffixes, such as -втар (-втэр, -втор, -втөр), -дуу/-дүү are added to the stem of the adjective to diminish the meaning to a lower degree. They indicate the approximate quality:

шинэвтэр	цэвэрхэндүү	улаавтар
хурдавтар	дөрвөлжиндүү	бөгтөрдүү
халуувтар	шударгадуу	харавтар

□ Practice 10. intensified ADJECTIVES.

Directions: Complete the sentences with the intensified adjectives.

Use the following list.

час хүйтэн	шив шинэхэн	хав халуун	маш хүйтэн
ганцаараа	цав цагаан	✓ бов бор	пиг дүүрэн

1. Саранмандах зусланд амраад бов бор болсон байна лээ.
2. Өглөөний хүйтэнд \_\_\_\_\_ какао уусан.
3. Зун \_\_\_\_\_ жимсний ундаа уух сайхан байдаг.
4. Өнөөдөр өдөржингөө \_\_\_\_\_ орсон цасан дээр цанаар гулгаж тоглолоо.
5. Нуурын ус \_\_\_\_\_ байсан учраас орж чадсангүй.
6. Хүүхдүүд төгсөлтийн өдрөөр \_\_\_\_\_ цамцаар ижилслээ.
7. Гав \_\_\_\_\_ явснаас гэр бүлтэйгээ хамтдаа явна.
8. Наадмаар цэнгэлдэх хүрээлэн \_\_\_\_\_ хүнтэй байсан.

□ Practice 11. intensified ADJECTIVES.

Directions: Find and underline the intensified adjectives in the following sentences.

1. Тамжидыг үнэхээр хөдөлмөрч хүн гэдгийг манай нутгийнхан маш сайн мэдэхээр барахгүй тун олон хүн түүний шавь болсон доо.
2. Цоо шинэхэн машиндаа пиг дүүрэн хүн суулгаад, төрсөн нутгийнхаа зүг хөлгийн жолоо залсан Жаргал гурав хоноод Булган сумын төвд ирлээ.
3. Цав цагаан сүү цагаан шаргал уургийнх, цагаан шаргал уураг нь цагаан сэтгэлт эхийнх.

□ Practice 12. intensified and diminished ADJECTIVES.

Directions: Intensify and diminish the meaning of the following colors.

Model: цагаан      цагаандуу      цагаавтар      цав цагаан

1. ногоон \_\_\_\_\_
2. хүрэн \_\_\_\_\_
3. шар \_\_\_\_\_
4. улаан \_\_\_\_\_
5. хар \_\_\_\_\_
6. ягаан \_\_\_\_\_
7. бор \_\_\_\_\_
8. цэнхэр \_\_\_\_\_
9. саарал \_\_\_\_\_

□ Practice 13. intensified ADJECTIVES.

Directions: Intensify the meaning of the following adjectives.

1. \_\_\_\_\_ том
2. \_\_\_\_\_ сайн
3. \_\_\_\_\_ амжилттай
4. \_\_\_\_\_ дугуй
5. \_\_\_\_\_ хөөрхөн
6. \_\_\_\_\_ жижигхэн
7. \_\_\_\_\_ их
8. \_\_\_\_\_ удаан
9. \_\_\_\_\_ баян
10. \_\_\_\_\_ бага
11. \_\_\_\_\_ гурвалжин
12. \_\_\_\_\_ эрэлхэг
13. \_\_\_\_\_ харанхуй
14. \_\_\_\_\_ зузаан
15. \_\_\_\_\_ галзуу
16. \_\_\_\_\_ аальгүй
17. \_\_\_\_\_ ганган
18. \_\_\_\_\_ туранхай
19. \_\_\_\_\_ бүдүүн
20. \_\_\_\_\_ гарамгай

## Тэмдэг Нэрийн Харьцуулсан Зэрэг 6.3 Comparison Degrees of Adjectives

Comparison degrees of adjectives are classified into three categories:

1. absolute form. **Ижил зэрэг**

This is the base form of the adjective. There are no inflectional ways of expressing the same degree.

These notions are expressed syntactically, using ШИГ, МЭТ:

ган ШИГ хатуу	түүн ШИГ ухаантай	цас ШИГ цагаан
салхи ШИГ хурдан	над ШИГ өндөр	сум МЭТ хурдан

2. Comparative form. **Илүү зэрэг**

The comparison is to a higher degree. It uses the ablative case endings:

салхинаас хурдан	яснаас хатуу	өднөөс хөнгөн
цаснаас цагаан	түүнээс ухаантай	надаас өндөр

3. Superlative form. **Давуу зэрэг**

This is the highest degree. It uses the word хамгийн:

хамгийн өндөр  
хамгийн нам

NOTE: Other synonyms can be used to express the superlative form. In that case, these

words have certain degree of emotional feeling, for example:

адгийн муу

туйлын сайн

хосгүй ухаантай

□Practice 14. comparison degrees of ADJECTIVES.

Directions: Identify the degree of the adjectives.

1. Савх шиг нарийхан, хавх шиг бахимхан энэ олон гар.  
Мөчир шиг туранхай, мөнгө шиг цагаан энэ олон гар.
2. Бүргэд хүнээс хол харах боловч хүний нүд бүргэдийнхээс давуу зүйлийг ажиглаж чадна.
3. Монголын хамгийн өндөр хүмүүсийн нэг Өндөр Гонгорын хэрэглэж байсан мөнгөн аяга нь бие хүний эдэлж хэрэглэж байсан аяганаас одоогоор бидэнд мэдэгдэж байгаа хамгийн том аяга юм. Тэр мөнгөн аяганы амсрын тойргийн урт нь 68 см, ёроолынх нь 48 см бөгөөд 1.5 литр эзэлхүүнтэй.
4. Манай орны хамгийн илчлэг мод бол заг юм. Түүний илчлэг 4500 гр калорид хүрдэг.  
Иймээс загийг урган цэцэглэдэг чулуун нүүрс гэж нэрлэдэг.

□Practice 15. comparison degrees of ADJECTIVES.

Directions: Read about a camel that has the qualities of animals of the twelve years. Notice that that same level comparison word **шиг** is omitted.

Хулгана чихтэй,	Морин дэлтэй,
Үхэр гэдэстэй,	Хонин ахартай,
Барс тавхайтай,	Бичин гуятай,
Туулай хамартай,	Тахиа өрөвлөгтэй,
Луу хүзүүтэй,	Нохой борвитой,
Могой нүдтэй,	Гахай сүүлтэй.

□Practice 16. ADJECTIVES.

Directions: Read the poem. Find and underline the adjectives.

Хар ус нуурын шагшуурга  
Намрын салхинд исгэрнэ.  
Харахад нэг л уйтгартай  
Намс намс бөхөлзөнө.  
Нүдэнд торох бараагүй  
Нуурын ус цэнхэртэнэ.  
Нүцгэн уулс чимээгүй  
Өнгөн дээр нь сүүдэртэнэ.  
Хээлэн үлээх салхи  
Нимгэн мандлыг нь бидэрлэнэ.  
Зөөлөн исгэрэх шагшуурга  
Хөнгөн уйтгар төрүүлнэ.  
Намрын сэрүүн болохоор  
Нуурууд ийм байдаг юм уу?  
Хотон шувуудаа явчихлаар  
Хатан хар ус уйдаа юу?

(Бэгзийн Явуухулан “Хар ус нуурын шагшуурга”)

# Тооны Нэр Numerals 7

## Тооны Нэрийн Ангилал Classification of Numerals 7.1

The *numerals* are a word class that shows the number, order, togetherness, whole and part, and number of times of certain actions. There are SEVEN categories of numerals:

Cardinal	Үндсэн тоо	түмэн адуу
Ordinal	Дэс тоо	хоёрдугаар анги
Collective	Хам тоо	гурвуул малла
Round	Тойм тоо	мянгаад хурга
Repeat	Дахих тоо	нэг удаа усал
Distributive	Түгээл тоо	тавь тавиар нь хөөвөрлө
Fraction	Бутархай тоо	гуравны хоёр нь төллө

### Үндсэн Тооны Нэр Cardinal Numbers 7.1.1

The *cardinal* numbers express definite number and answer the questions *хэд? хичнээн?* They can be *simple* **энгийн тооны нэр** and *compound* **нийлмэл нэрийн тоо**.

Simple numerals consist of one word, for example: нэг, хоёр.

Compound numerals consist of two words, for example: тавин зургаа, гучин хоёр.

The cardinal numbers become the base for forming the other numerals.

GRAMMAR RULE:

The numeral takes the suffix -Н in complex numerals and when it connects to other words, for example: арван нэг, хорин хүн.

NOTE: When an ending -ХАН (-ХЭН, -ХОН, -ХӨН) is added to the numeral, it means **зөвхөн ... л**:

Надад хоёрхон харандаа байна. = Надад **зөвхөн** хоёр **л** харандаа байна.

□Practice 1. NUMERALS.

Directions: Complete the sentences with the CARDINAL NUMBERS. Write them in letters.

Model: Чи хэдэн настай вэ? – Би (17) арван долоотой.

1. Чи хэдэн настай вэ? – Би (20) \_\_\_\_\_ настай.
2. Та хэдэн цагт ирэх вэ? – Би (6) \_\_\_\_\_ цагт ирнэ.
3. Тэр хэдэн хүүхэдтэй вэ? – Тэр (3) \_\_\_\_\_ хүүхэдтэй.
4. Түүний охин хэдтэй вэ? – Охин нь одоо (7) \_\_\_\_\_.
5. Чамд хэдэн зураг байгаа вэ? – Надад (5) \_\_\_\_\_ бий.

□Practice 2. NUMERALS.

Directions: Find and underline the cardinal numbers.

1. Аймшиггүй чин зоригт их жанжин Сүхбаатар 1893 оны хоёрдугаар сарын хоёрны өдөр төржээ.
2. Тэрээр арваад настайгаасаа ах нартайгаа хамт мод зомгол түүж, эцэг эхдээ тусалдаг байв.
3. 1907 онд буюу түүнийг арван дөрөвтэйд нь эцэг Дамдин хүрээний нэртэй багш Жамъянд шавь оруулж, монгол бичиг, тоо бодлого заалгажээ.
4. Гэвч Дамдин хүнд амьдралаа хөнгөвчлөхийн тулд арван зургаан настай хүүгээрээ хөлсний ажил хийлгэхээр шийджээ.
5. Ийнхүү Сүх хүү Хүрээ, Хиагтын хоорондох их замын арван нэгэн өртөөний нэгэнд улаа нэхэж байлаа.
6. 1911 оны сүүлчээр Халх дөрвөн аймгаас тус бүр мянган цэрэг татах шийдвэр гарчээ.
7. Энэ шийдвэрийн ёсоор 1912 оны эхээр Сүхбаатар цэрэгт татагджээ.

□Practice 3. NUMERALS.

Directions: Read the following song lyrics about twelve years.

Эрдэнийн зүйлээр бөөлжөөд байдаг	Холын газрыг товчлоод байдаг
Эрүү цагаан хулгана <i>нэгэн</i> жил.	Хомбон туурайтай морь <i>долоон</i> жил.
Эвэр сүүл нь тэнцүүхэн байдаг	Хонхор газрыг хорголоор дүүргэдэг
Эзэндээ ээлтэй үхэр <i>хоёр</i> жил.	Хотондоо ээлтэй хонь <i>найман</i> жил.
Арын модонд алаглаад байдаг	Үзсэн бүхнийг элэглээд байдаг
Алаг эрээн барс <i>гурван</i> жил.	Илбэч эрдэмтэй бич <i>есөн</i> жил.
Дэлхий дээгүүр дэгдээд байдаг	Үүрийн шөнөөр донгодоод байдаг
Дэлдэн чихтэй туулай <i>дөрвөн</i> жил.	Эвэр хошуутай тахиа <i>арван</i> жил.
Хөх тэнгэрт хүржигнээд байдаг	Хортон дайсныг хоргоогоод байдаг
Хүч ихтэй луу <i>таван</i> жил.	Хон хон дуутай нохой <i>арван нэгэн</i> жил.
Цаг үргэлж цагираглаад байдаг	Хөрст дэлхийг сэндийлээд байдаг
Цагаан эрээн могой <i>зургаан</i> жил.	Хөндлөн соёотой гахай <i>арван хоёр</i> жил.

## Дэс Тооны Нэр Ordinal Numbers 7.1.2

The *ordinal* numbers express order and answer the questions *хэддүгээр? хэд дэх?*

They are formed by adding the suffixes -дугаар/-дүгээр, дахь/дэх:

хоёр <u>дугаар</u>	дөрөв <u>дүгээр</u>	арав <u>дахь</u>
гурав <u>дугаар</u>	нэг <u>дүгээр</u>	ес <u>дэх</u>

GRAMMAR RULE:

The suffixes -дугаар, -дүгээр are written together, and дахь, дэх are written separately:

Сүх Нэгдүгээр байранд шалгарсан.

Хоёр дахь оролдлогоороо би давж үсэрч чадсан.

### □ Practice 4. NUMERALS.

Directions: Find and underline the ordinal numBers.

1. Монголын нууц товчоо хэмээх алдарт бүтээл арван гуравдугаар зууны тэргүүн хагаст буюу 1240 оны долдугаар сард Хэрлэний Хөдөө аралд зохиогджээ.
2. Энэ нь арван хоёр бүлэг, хоёр зуун наян хоёр зүйлтэй түүх, уран зохиол, хэлний гайхамшигт дурсгал юм.
3. Монголын нууц товчооны хоёр зуун наян хоёрдугаар зүйлд хэзээ хаана бичиж дуусгасан тухай тодорхой мэдээ бий.
4. Үүнээс үндэслэж, зохиогдсоны нь 750 жилийн ойг арван долдугаар жарны цагаан морин жил манай ард түмэн ёслон тэмдэглэж, их даншиг хийсэн билээ.

### □ Practice 5. NUMERALS.

Directions: Complete the sentences with the ORDINAL NUMBERS.

Write them in letters.

1. Чи хэддүгээр ангид сурдаг вэ? – Би (8) \_\_\_\_\_ ангид сурдаг.
2. Тэр хэддүгээр байранд шалгарсан бэ? – Тэр (4) \_\_\_\_\_ байранд шалгарсан.
3. Танайх хэддүгээр байранд байдаг вэ? – Манайх (59) \_\_\_\_\_ байранд байдаг.

## 7.1.3 Хам Тооны Нэр Collective Numbers

The *collective* numbers express togetherness and answer the question *хэдүүл?* They are formed by adding the suffixes -УУЛ/-ҮҮЛ:

хоё <u>ул</u>	таву <u>ул</u>	найму <u>ул</u>
гур <u>вуул</u>	зур <u>гуул</u>	ес <u>үүл</u>
дөр <u>вүүл</u>	долу <u>ул</u>	ар <u>вуул</u>

In a numeral нэг there's no collective meaning, but there's specific word ганцаар that answers the question *хэдүүл?*

## GRAMMAR RULE:

Collective numbers are able to attach the case and the possessive endings:

Би ганцаараа амьдардаг.

Тэд тавуулаа нуур луу явсан.

Гурвуулангий нь ир гэж дууд.

Чи зургуулангий нь авчирсан уу?

### Practice 6. NUMERALS.

Directions: Find and underline the collective numbers.

- 1967 оны тос даасан намрын нэгэн өдөр ардын багш болох чин хүсэлдээ хөтлөгдсөн бид хорин тавуулаа нэг багштай ургац хураахаар Улаанбаатараас гарч билээ.
- Зарим нь нутгаасаа хоёул гурвуул, нэг хэсэг нь ганцаараа ирсэн тул таних хүн ховор байлаа.
- Сөгнөгөрийн ногооны тасагт очиход алдарт ногоочин агсан Долгор хоёр хүнтэй гурвуул угтав.
- Хөвгүүд бид арван гурвуулаа ногооны тасгийн улаан буланд байрлалаа.
- Удирдаж явсан багш Дашдорж маань ардын ёс заншил, үлгэр домог, түүх соёлыг нэвтэрхий сайн мэдэх тул чөлөөт цаг ч үр ашигтай өнгөрдөгсөн.
- Оюутны анхны намрын жараад хоног бидний сэтгэл зүрхэнд олон сайхан дурсамж үлдээсэн билээ.

### Practice 7. NUMERALS.

Directions: Complete the sentences with the COLLECTIVE NUMBERS. Write them in letters.

- Бид (5) \_\_\_\_\_ амьдардаг.
- Өчигдөр тэд (6) \_\_\_\_\_ ирсэн.
- Бид тэднийд (2) \_\_\_\_\_ очно.
- Би (4) \_\_\_\_\_ нь гэртээ урьсан.

## Тойм Тооны Нэр Round Numbers 7.1.4

The *round numbers* do not tell the exact amount, but round them up and tell the approximate amount. They answer the questions *хэд орчим? хэдий хэр?*

The round numbers are formed as follows:

- Adding a suffix -аад<sup>4</sup>. It applies to whole numbers, such as 10, 100, etc.:

арваад	наяад	жараад
хориод	ерээд	зуугаад

- Adding auxiliary words, such as орчим, эргэм, хавьцаа, хэрийн, шахам, гаруй, хэдэн, etc.:

арван тав орчим	тавь хэрийн	дал гаруй
хорь шахам	гуч хавьцаа	дөч эргэм

- Combining two successive numerals:

хоёр гурав	хоёр гурван зуу	тавь жар
ганц нэг	арван тав зургаа	тав арав

### Practice 8. NUMERALS.

Directions: Find and underline the numerals.

- Баян Болдын нас нь дөчөөд, толгой нь халзан, сахал нь битүү, нүд нь улбар. Түүний эхнэр Дэжидийн нас нь дөч орчим, ааш хурдан, үг хэл ширүүн.
- Долингор шуурганаас огт далдирахгүй, улмаар хоёр гурван өдөр явахад алс хол хошуу байтугай аймаг алсалжээ.
- Намайг бага байхад манай нутагт хээр голдуу мянгаад адуутай Мягмарынх гэдэг баян айл байлаа. Мягмар гуай тэр үед тавь эргэм насны тарган бор эр байв. Тэдний дөрвөн хүүтэй нь би үерхэнэ. Тэднийх адуу олонтой болохоор айраг цагаа элбэгтэй, хөл ихтэй айл байлаа. Ёстой л дайраад ирэхэд далай шиг, буцаад ирэхэд булаг шиг айл байж билээ.

□Practice 9. NUMERALS.

Directions: Change the cardinal numbers into the round numbers.

ес \_\_\_\_\_  
ная \_\_\_\_\_  
тавин гурав \_\_\_\_\_  
хоёр зуу \_\_\_\_\_  
дөрвөн зуун гуч \_\_\_\_\_  
долоон мянга \_\_\_\_\_  
арван тав \_\_\_\_\_  
хорин зургаа \_\_\_\_\_

## 7.1.5 Дахих Тооны Нэр Repeat Numbers

The *repeat* numbers express how many times the certain action happened and they answer the questions *хэдэн удаа? хэд дахин?*

They are formed as follows:

1. Adding auxiliary words, such as удаа, дахин;
2. Adding suffixes -таа<sup>4</sup>.

In spoken and written language, it's common to leave the words удаа, дахин out:

Могой гурав тасравч гүрвэлийн чинээ.

Давахгүй гэсэн даваагаар гурав давна, уулзахгүй гэсэн хүнтэйгээ гурав уулзана.

□Practice 10. NUMERALS.

Directions: Find and underline the repeat numbers.

Энд ирж бууснаас хойш тэнгэр нэг ч удаа цэлмэсэнгүй, үргэлж бороо асгаад байх юм. Сумын төвөөс муу дүү минь гурав дахин эргэж ирлээ. Нэг шөнө харанхуйд төөрөөд энэ хойт толгойг дөрөв таван удаа тойроод, нохой хуцах чимээнээр олж ирсэн гэсэн. Наадмаас хойш Цээмаагийн анх удаа ирж байгаа нь энэ ажээ.

□Practice 11. NUMERALS.

Directions: Find and underline the repeat numbers.

1. Долоо хэмжиж, нэг огтол.
2. Олон удаа бодож, нэг удаа хэл.
3. Төрж өссөн нутгийнхаа энэ буурал ууланд би мянгантаа залбирч, түмэнтээ мөргөсөн хүн.

Хишиг буянаа надад их ч хайрласан даа гэж өвгөн анчин өгүүлэв.

## Түгээл Тооны Нэр Distributive Numbers 7.1.6

The *distributive* numbers express the division into groups and answer the questions *хэд хэдэн?* They are formed by repeating the same numeral:

арав арван хүн	НЭГ НЭГ багш	зуу зуун километр
хорь хорин чулуу	хоёр хоёр ном	мянга мянган цэрэг
тав таван адуу	гурав гурван эгнээ	сая саян доллар

The numerals нэг нэг, хоёр хоёр can be substituted with simple words нэжгээд, хошоод respectively:

Бид гурав дэлгүүрээс нэжгээд үзэг, хошоод дэвтэр авлаа.

However, in spoken language these forms are rarely used.

□Practice 12. NUMERALS.

Directions: Complete the sentences with the numerals in parentheses.

Change them into the distributive numbers.

Model: Энэ нэгтийн дэвсгэртүүдийг (хорь) хорь хориор боогоорой.

1. Сурагч бүр (нэг) \_\_\_\_\_ шүлэг цээжил.
2. Энэ зурагнуудыг (тав) \_\_\_\_\_ нь ялгаж дугтуйд хийгээрэй.

3. Машин бүрт (*дөрөв*) \_\_\_\_\_ сууцгаа.
4. Саруул цэцэг болгоноос (*гурав*) \_\_\_\_\_ худалдаж авав.
5. Хөзрөө (*долоо*) \_\_\_\_\_ тараа.
6. Хүн ихтэй үед зөөгч бүрт ширээнүүдийг (*хоёр*) \_\_\_\_\_ хариуцуул.

□Practice 13. NUMERALS.

Directions: Find and underline the distributive numbers.

1. Манай нутгийн сайн малчин Дамбынх арваад жилийн өмнө тав зургаан хоньтой, чөдрийн ганц морьтой, ам бүл зургуул, сумын төвд ядуу зүдүү амьдарч байв.
2. Амьдрахын эрхээр хөдөө гарч мал маллахаар шийдэж, нутгийнхаа хоёр малчнаас арав арван эм төлөг түрээсээр авчээ.
3. Уйгагүй хөдөлмөрлөсний ачаар мал малын захтай болсон төдийгүй дөрөв дэх жилдээ хорь хорин хургатай хонь, нэжгээд тугалтай үнээг түрээслэн авсан хоёр малчиндаа өгсөн байна. Гар хөдөлбөл ам тосдоно гэдгийн нэг жишээ энэ ажээ.

## 7.1.7 Бутархай Тооны Нэр Fraction Numbers

The *fraction* numbers express part or whole and answer the question *хэдний хэд?*

They are revealed by the genitive case ending:

хоёрны нэг	гуравны хоёр	зуугийн дал
аравны долоо	дөрөвний гурав	долооны тав
тавны гурав	зургааны тав	мянганы арав
наймны тав	есний долоо	түмний нэг

□Practice 14. NUMERALS.

Directions: Find and underline the numerals.

Label them according to their category.

1. Сайн эцэг эхийн үлдээсэн буян хоёр зуугаад хонь ямаа, гуч дөчин адуу, арван хэдэн үхэр, ачлагын долоо найман тэмээтэй, шилэн байж ахрын ноосоор хийсэн хэдэн давхар бүрээстэй шагхийсэн дөрвөн ханатай гэртэйгээр хорин насандаа өөрөөсөө хоёр гурав дүү бүсгүйтэй айл гэр болж билээ.
2. Удам дамжсан эцэг, хүү, ах, эгч, дүү тамирчидтай цөөнгүй л уулзаж явлаа. Тэр бүхний дундаас ах дүү таван цаначинтай Хандгайтад уулзсан тухайгаа өгүүлье.

Надад үл мартагдах энэ уулзалт 1987 оны гуравдугаар сарын долоонд Хандгайтын цаначдын хотхонд болсон юм. Тэр өдөр Монголын бүх ард түмний YIII спартакиадын цаначдын уралдаан үргэлжилж байлаа. Эрэгтэй цаначид хамгийн холын зай буюу 50 км-т хурд сорих байсан тул үзэгчид олон байлаа. 50 км-ийн уралдааны барианаас цаначид гуч гучин секундын зайтаагаар хос хосоороо гарлаа. Хамгийн эхний тамирчнаас арваад минутын хойно буюу хорь дахь гараанд гарсан Л. Дорж өөрөөсөө түрүүлж замд гарсан бүх тамирчныг гүйцэж хол тасархай түрүүлж ирэхэд нь уулзаж товч ярилцсан юм. Л. Дорж:

– Бид эхээс есүүлээ. Зургаа нь хүү, гурав нь охин. Бидний тав нь цаначин. Би улсын аваргын тэмцээн болон бүх ард түмний спартакиадад 19 удаа түрүүлсэн.

□Practice 15. NUMERALS.

Directions: Find and underline the numerals in the text. What numerals are they?

1. Залаатын тохилог сайхан өвөлжөөнд өвгөн Дондогийнх хоёр хүүгийнхээ хамт гурван гэрээр өвөлжиж байна.
2. Тэднийх мянга таван зуугаад толгой малтай бөгөөд гуравны хоёр нь бог мал ажээ.
3. Богийнх нь тэн хагас нь энэ жил төллөх тул өвс хадлангаа хангалттай авч, хашаа хороогоо сайн дулаалсан байна.
4. Тэднийхэн хоёр зуу гаруй адуутай ба дөрөвний нэг нь гүү юм.
5. Тэднийх ам бүл тавуул боловч хоёр том хүү нь өрх тусгаарлажээ.
6. Отгон охин нь наймдугаар ангид сурч байгаа бөгөөд амралтаараа ирсэн үедээ малчин эмэгтэйчүүдийн хийх бүхнийг хийнэ.

□Practice 16. NUMERALS.

Directions: Find and underline the numerals. Label their category.

1. Зуун түмэн үед монгол хүний идээшсэн зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө, би.
2. Холбоо хоёр нум хотос хотос тахилзана. Солбио хоёр хөл тахис тахис гүйнэ.
3. Дөрөв дөрвөн улиралтай наян жилийг үүрч дүүрсэн, дөмөн дуурсах талын жигүүр шархтай бүргэд миний өвөө.
4. Хоёр сэтгэлт эрийг эр бус, эм хэмээлтэй. Нэгэн сэтгэлт эрийг эр бус, эрдэнэ хэмээлтэй.
5. Олон таван үггүй наад ажлаа хурдан дуусгачихаад, тэр таван амттайгаа уулзаж үз.
6. Түмний эхийн харайсан эх газрын хөрсөн дээр түмэн газар зурайсан цагаан тоос татсан юм.

## 8 Төлөөний үг Pronouns

### 8.1 Төлөөний Үгийн Ангилал Classification of Pronouns

The *pronouns* are a word class that does not directly name people, animals, things, phenomena, and their quality, number, action, location and time. They represent:

Verbs	Үйл Үг	яах, хэрхэх, ингэх, тэгэх
Nouns	Нэр Үг	би, чи, бид, өөрөө, хэн, юу
Adjectives	Тэмдэг Нэр	ийм, тийм, аль, ямар
Prepositions	Орон Цагийн Нэр	хаана, хэзээ, энд, тэнд, өдийд
Numerals	Тооны Нэр	өд, төд, хэд, хичнээн

#### □Practice 1. PRONOUNS.

Directions: Find and underline the pronouns. Label which part of speech they represent.

1. Монголын үзэсгэлэнт сарангоо намайг төрүүлсэн эжий, зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн эжий.
2. Хуур хөгжим хангир жингэр сонсдоод, хушийн мөчир нэлбэс дэлбэс ганхаад, ийм л сайхан, тийм л соньхон.
3. Чи үүнийг хаана нууж, хэзээ ил гаргах хүн бэ? Тэр тунхгийн зүйл чинь хэзээ нэгэн цагт эрхбиш задрахад хүрнэ. Шөвгийг уутанд яаж нуух билээ.
4. Өдий төдий хүн ирж явж л байх юм. Чухамхүү тэр нь таны сураглаж яваа хүн гэдгийг мэдэх юм алга даа. Харин цаад хашааны чинь буланд хэдэн залуу ноос ялгаж байгаа. Тэд л мэдэж магадгүй.
5. Бид олон хөлийн газар очоод, яахаа мэдэхгүй будилж явахад гар сунгасан хүн бол Дондов багш яах аргагүй мөн шүү.

#### □Practice 2. PRONOUNS.

Directions: Find and underline the pronouns.

1. Тулах цэгийг надад аль, дэлхийг би хөдөлгөө.
2. Боловсрол бол баялаг, хөдөлмөр бол түүний түлхүүр.
3. Хэн түүнийг анх удаа хээрийн нугаас түүгээ бол.
4. Өөрийн хийсэн юм өөртөө зөв.

### Төлөөний Үгийн Төрөл Types of Pronoun 8.2

Pronouns have the following SIX types:

Personal	Биеийн төлөөний үг	би – бид, чи – та, тэр – тэд
Demonstrative	Заах төлөөний үг	энэ – тэр, ийм – тийм, өд – төд
Interrogative	Асуух төлөөний үг	хэн, юу, аль, ямар, хэд, хичнээн, хэзээ, хаана, яах, хэрхэх
Indefinite	Тодорхойгүй төлөөний үг	хэн ч, хэзээ ч, аль ч
Distinguishing	Ялгах төлөөний үг	бүх – ондоо, бүгд – бусад, цөм – зарим
Reflexive	Өөрийн төлөөний үг	өөрөө, өөрсдөө

#### Биеийн Төлөөний Үг Personal Pronouns 8.2.1

The *personal* pronouns identify the speakers or the first person, listeners or the second person:

би бид чи та тэр тэд

There's no word that shows the third person. A demonstrative pronoun, when represents a person, shows the third person. The personal pronouns represent the nouns. Therefore, they take the plural, case and possessive endings.

□Practice 3. personal PRONOUNS.

Directions: Complete the sentences. Fill in the blanks with the appropriate pronoun.

1. Би (*чи, чамд, чамайг*) \_\_\_\_\_ хайртай.
2. Эгч (*түүнд, түүний, түүнийг*) \_\_\_\_\_ дургүй.
3. Малчид (*тэдний, тэдэнд, тэднээс*) \_\_\_\_\_ дургүй.
4. Тэр эмэгтэй (*надаас, надаар, надад*) \_\_\_\_\_ дургүй.

□Practice 4. personal PRONOUNS.

Directions: Find and underline the different case endings of the pronoun **би**.

Даваа гаригийн өглөө намайг өрөөндөө орж ирэхэд Ариунболд тайлан тооцоогоо дэлгэчихсэн сууж байснаа намайг хараад инээд алдан:

– За хөө, надад баяр хүргэж болно шүү гээд над руу гараа сарвайхад нь би очиж гарыг нь атгаад:

– Өө, за баяр хүргэе. Хүүтэй болсон уу, охинтой болсон уу? гэхэд:

– Хүүтэй болсон гээд надаас нэг юм хүсэн хүлээж байсан юм шиг ширтэхэд нь миний сэтгэлд урьдын нэгэн явдал гэнэт орж ирлээ.

– Чи ч надтай олон шижмээр холбоотой хүн шүү. Би чамд бүх л талаар туслах ёстой. Одоо надаар хийлгэх ямар ажил байна даа гэж сандран хэлэв.

## 8.2.2 Заахын Төлөөний Үг Demonstrative Pronouns

The *demonstrative* pronouns show quality, count, action, location and time:

энэ	тэр	энд	тэнд
ийм	тийм	ингэ	тэг
өд	төд	өдийд	төдийд
өчнөөн	төчнөөн		

Besides the words with the stems Э-, ТЭ-, there are other words that function as pronouns:

нөгөө	тухайн	тус
уг	өнөө	эл

□Practice 5. demonstrative PRONOUNS.

Directions: Find and underline the pronouns with the stems **э-**, **тэ-**.

Нэг өглөө тээр тэнд буусан аянчны гадаа уяатай нохой шиг хар юмыг тойроод энд тэнд нь гараад байхыг хадам эх нь харжээ. Тэр тэндээс буцаж ирээд, аянчны хар даагыг ямар ч хамаагүй үнээр ав гэж нөхөртөө хэлжээ. Тэр жилдээ хошуу найрт уралдуулсанд нөгөө арвайн чинээ биетэй жижиг хээр даага нь ганцаараа дэгдэж иржээ. Харин Арвай хээрийн хөндий гэж энэ газрыг нэрлэсэн учир бол тэр уужим тал хөндийгөөр хориод жилийн турш урдаа морь гаргалгүй түрүүлж явсан болохоор тэгж нэрлэсэн гэдэг.

(Сумъяагийн Жамбалдорж “Арвай хээр”)

□Practice 6. demonstrative PRONOUNS.

Directions: Find and underline the demonstrative pronouns. Label what part of speech they represent.

1. Голын эрэгт энгийн нэг бут ургажээ. Түүнийг хэн ч тоодоггүй байв. Гэтэл үерт урссан хүний гарт өнөөх бут өртөгдөж, түүний амийг аварчээ. Ингэж энгийн нэг бут их ачтан болсон ажээ.
2. Тэртээх уулсын бэлд төрж өссөн гэр орон минь байгаа. Өдийд аав минь хүүгийнхээ хайртай сартай зээрдийг барьж уячихаад хүлээж суугаа. Ийш тийш өнгөрөх аянчны их зам тосож, идээ цагааныхаа дээжийг барьсаар насныхаа буянг хурааж яваа ээж минь муу хүүгээ харуулдан суугаа. Ийм буянтай буурлууд олон боловч аав ээж хоёрыг минь орлох хүн нэг ч үгүй.
3. Өвлийн цагт цас хичнээн хунгарлавал хөмгийн ногоо төчнөөн их сугсарна. Өсөхийн цагт хал хичнээн үзвэл хүний ухаан төчнөөн их хэрсүүжнэ.

## Асуух Төлөөний Үг Interrogative Pronouns 8.2.3

The *interrogative* pronouns ask questions about quality, count, action, location and time of

independent words:

ХЭН, ЮУ – nouns

аль, ямар – adjectives

ХЭД, ХИЧНЭЭН – numerals

ХЭЗЭЭ, ХААНА – prepositions

ЯАХ, ХЭРХЭХ – verbs

The interrogative pronouns that represent nouns or other words in a role of a noun can take the plural, case and possessive endings:

Чи ХЭНТЭЙ уулзсан бэ?

Чи АЛИЙГ нь авах вэ?

The interrogative pronouns that represent verbs can take the formative, conditional, connective and completing endings:

Чи ЯАМААР байна вэ?

Тэнд ЯАЖ хүрэх үү?

GRAMMAR RULE:

In question sentences, the particles ВЭ/БЭ, УУ/ҮҮ are used at the end.

□ Practice 7. interrogative PRONOUNS.

Directions: Complete the sentences with the interrogative pronouns.

Use the following list.

ямар            яаж            хэзээ            хаашаа

✓ хэдэн            юу            хаанаас            хэр

1. Чи \_\_\_\_\_ хэдэн настай вэ?
2. Та нар \_\_\_\_\_ явах гэж байна вэ?
3. Энэ гөлгийг \_\_\_\_\_ олов?
4. Та нар үүнийг \_\_\_\_\_ гэж бодож байна?
5. Чи \_\_\_\_\_ утсаар ярих гэж байна вэ?
6. Ээж \_\_\_\_\_ үнэртэй ус авсан бэ?
7. Танай нутагт очоод тантай \_\_\_\_\_ холбоо барих вэ?
8. Та түүнийг \_\_\_\_\_ удаан хүлээв?

□ Practice 8. interrogative PRONOUNS.

Directions: Find and underline the interrogative pronouns.

1. Хаана, хэзээ, хэнээс ч билээ, төөрсөн хүн газар чагнахад ойр хавь айл амьтан байвал мэдэгддэг юм гэнэ дээ гэж сонссоноо санаж, газар элэглэн хэвтээд чихээ наан чагнавал хатуу дүлий газрын хайрга чулуу шанаагий нь нухан, хатсан өвс ногоо хатгахаас өөр юу ч түүнд мэдэгдсэнгүй.
2. Аль газрын хэний хэн гэгч хэзээ, хаанаас хүрээд ирснийг хэлээд өгөх хүн байна уу, та минь ээ!

## 8.2.4 Тодорхойгүй Төлөөний Үг Indefinite Pronouns

The *indefinite* pronouns express indefinite quality, count, action, location and time:

хэн ч            хэрхэх ч

хэн нэгэн      яах ч

аль ч            хаа нэгэн

аливаа          хаана ч

ямар ч            хэзээ нэгэн

ямарваа        ямар нэгэн

хэд ч            хэзээ ч

The indefinite pronouns are created based on the interrogative pronouns.

They are expressed by the following methods:

1. The modal particle ч is used after the interrogative pronoun.
2. The numerals нэг, нэгэн are used after the interrogative pronoun.

3. In spoken language, indefinite pronouns are created, such as хэн л бол хэн, юу л бол юу.

4. There are two unusual forms of indefinite pronouns, such as аливаа, ямарваа.

□Practice 9. indefinite PRONOUNS.

Directions: Complete the sentences with the INDEFINITE PRONOUNS. Use the following list.

хэзээ ч      хаашаа ч      ямар ч  
аль ч      хэд ч      ✓ юу ч

1. Чамд сайхан зохиж л байвал \_\_\_\_\_ юу ч \_\_\_\_\_ хамаагүй өмс.
2. Та бид нарт \_\_\_\_\_ хамаагүй үлгэр яриад өг.
3. Тэр \_\_\_\_\_ хамаагүй манайд ирж магадгүй.
4. \_\_\_\_\_ хамаагүй нэг сайхан газар явмаар байна.
5. Энэ санд боломжийн хэрээрээ \_\_\_\_\_ хамаагүй мөнгө хандивлаарай.
6. Энэ дөрвөлжин талбайд \_\_\_\_\_ төрлийн хамаагүй цэцэг тариарай.

□Practice 10. indefinite PRONOUNS.

Directions: Answer the questions. Include the indefinite pronouns in your answers.

Model: Та төмс тарьж байсан уу? – Би хэзээ ч төмс тарьж байгаагүй.

1. Танд хэн нэгэн энэ тухай хэлсэн үү?

2. Та энэ дэгдээхэйд ямар нэр өгөх вэ?

3. Та захаас юу авах вэ?

□Practice 11. indefinite PRONOUNS.

Directions: Complete the sentences with the INDEFINITE PRONOUNS.

Use the following list.

ямар ч      юугаар ч      хаана ч      аль нь ч  
хэнтэй ч      ✓ хэзээ ч      хаашаа ч      хэн ч  
юу ч      аль ч      хэнд ч      хэзээ нэгэн

1. Парк руу \_\_\_\_\_ хэзээ ч \_\_\_\_\_ очиж болно. Өдөр бүр ажиллаж байгаа.
2. Би өдөржингөө өвдөөд \_\_\_\_\_ хийж амжсангүй.
3. Энэ зундаа бид нар \_\_\_\_\_ явахгүй, гэр зуураа байна.
4. Хүнсээ \_\_\_\_\_ дэлгүүрээс цуглуулж болно.
5. Өнөөдөр надад \_\_\_\_\_ зав алга. Маргааш өглөө дипломын ажлаа хамгаална.
6. Та энд \_\_\_\_\_ сууж болно.
7. \_\_\_\_\_ миний ном биш.
8. Та манайд \_\_\_\_\_ зочилж болно.
9. Та захиагаа үзгээр ч, харандаагаар ч \_\_\_\_\_ бичсэн болно.
10. Миний утасны дугаарыг \_\_\_\_\_ битгий хэлээрэй.
11. Би өчигдөр \_\_\_\_\_ яриагүй.
12. \_\_\_\_\_ цагт би заавал амласандаа хүрнэ.

□Practice 12. indefinite PRONOUNS.

Directions: Find and underline the pronouns.

1. Маргааш энд хэн ирэх вэ?

– Хэн ч ирэхгүй.

– Хэн нэгэн хүн ирэх байх.

2. Та нар хөдөө юугаар явах вэ?

– Юугаар ч явсан яах вэ.

– Ямар нэгэн унаагаар л явна даа.

3. Танай адуунд ямар зүсмийн морьд байна вэ?

– Ямар ч зүсмийн морь бий.

– Ямар л бол ямар зүсмийн морь бий шүү.

4. Одоо хэдүүлээ яах вэ?

– Яасан ч яах вэ.

– Яах ч үгүй.

5. Тэмцээнд хэдэн хүн оролцож болох вэ?

– Хэдэн ч хүн оролцож болно.

– Хэд л бол хэд оролцож болно.

## 8.2.5 Ялгах Төлөөний Үг Distinguishing Pronouns

The *distinguishing* pronouns unite or separate:

бүх ондоо

бүгд бусад

цөм зарим

нийт өөр

бүр хагас

They can be used either before or after the object:

бүх хүн – хүн бүхэн

зарим хүн – хүмүүсийн зарим нь

Most of them represent the nouns and take the case and possessive endings.

□ Practice 13. distinguishing PRONOUNS.

Directions: Fill in the blanks with **бүр**, **болгон**, **бүх**, **бүгд** where necessary.

Model: \_\_\_\_\_ **Ө** \_\_\_\_\_ улс \_\_\_\_\_ **бүр** \_\_\_\_\_ өвөрмөц шинж агуулдаг.

1. \_\_\_\_\_ хүн \_\_\_\_\_ сайны төлөө явах эрхтэй.

2. \_\_\_\_\_ суудал \_\_\_\_\_ эзэнтэй.

3. Өнөөдөр \_\_\_\_\_ ажилчид \_\_\_\_\_ цагтаа ирсэн.

4. \_\_\_\_\_ бид нар \_\_\_\_\_ хөдөө байхдаа морь унаж сурсан.

5. \_\_\_\_\_ хүн \_\_\_\_\_ саналаа өгөөрэй.

6. \_\_\_\_\_ хүүхэд \_\_\_\_\_ өөрийн гэсэн онцлогтой.

7. \_\_\_\_\_ айл \_\_\_\_\_ энэ байрны дэг журмыг сахина.

□ Practice 14. distinguishing PRONOUNS.

Directions: Find and underline the distinguishing pronouns.

1. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй.

2. Нийтийн үйл хэрэг, хотол олныхоо сайн сайхны төлөө тэмцэж, хүч чадал, авъяас билгээ зориулж явсан ахмад настан, алдар цуутнууд одоо бидэнтэй мөр зэрэгцэн амьдарч ажиллаж байгаагаар нь бахархах ёстой.

3. Бусдын үйл хэргийн төлөө өөрийгөө зориулсан хүнийг жинхэнэ ариун цагаан үйлстэн гэж нэрлэнэ.

4. Миний хүү өрөөлд бол уултай жишим өндөр хүүхэд гэж хэлэхэд үг багадам өсгөлүүн. Миний хүү өөрт минь бол гараас нь чихрийн үнэр салаагүй, зулайнаас нь сүүний үнэр арилаагүй нялх амьтан.

5. Харсан бүхнийхээ өнгөтэй өөдтэй болгоныг гуйж гувшиж явдаг Дамбын шунал одоо л нэг арилсан бололтой.

## Өөрийн Төлөөний Үг Reflexive Pronouns 8.2.6

The *reflexive* pronouns **өөрөө**, **өөрсдөө** represent the agent of the action.

They represent nouns, therefore can take plural, case and possessive endings:

Өөрөө сураад **өрөөлийг** сурга.

Өөрийн хийсэн юм өөртөө зөв.

Өөрийгөө өнгөтэй өөдтэй авч явах нь өөрөөс чинь л шалтгаална.

Өөрөө өөрөөрөө бахархаж явахаас гадна бусдыг өөртэйгээ жишиж алдаа оноогоо цэгнэж явах хэрэгтэй.

Сайн үйлс бүтээж, бусдын сэтгэлийг өөр лүүгээ татаж, үлгэрлэж явах сайхан.

#### □ Practice 15. reflexive PRONOUNS.

Directions: Find and underline the pronouns.

– Тэгвэл миний мөнгийг цөмийг нь тэдэнд өгөөч гэж Цэрмаа яаран өгүүлэв.

– Юу гэсэн үг вэ? Тэр чинь та нарт хэрэг болно. Ямар ч гэсэн энэ бүхнийг би биедээ хүлээе. Та ингэтлээ зовж зүдрэх ёсгүйсэн. Үнэхээр гоо сайхныг бидэнд тэр болгон заяадаггүй шүү дээ. Та надад итгэж болно. Би үзэл санаанаасаа ухардаггүй, цэрэг дайны хатуужилтай боловч бас энэрэнгүй угсааны хүн шүү. Цэрмаа би танд оройн зоог барья. Манай нутгийн амтат дарс жаахан уугаад тайван нойрс л доо. Маргааш өглөө би тэнд очиж танд амласнаа биелүүлнэ гэж Монарел найр тавин өгүүлэв. Сэтгэлийн үймээн дунд ийм нэг итгэл найдварын үзүүр гарангуут амь тэмцэн зууралдахаас өөр хэрхэх билээ.

(Сэнгийн Эрдэнэ “Оготны нүхэн дэх сувд”)

## 9 Орон Цагийн Нэр Prepositions

### 9.1 Орон Цагийн Нэрийн Ангилал Classification of Prepositions

*Prepositions* are a word class that expresses a relationship of meaning between two parts of a sentence, showing how the two parts are related in space or time.

Location	Орон байр	дээр, доор, хойно, өмнө, дотор, гадна, цаана, наана, дэргэд, хооронд
Direction	Зүг чиг	дээш, доош, цааш, нааш, дотогш, гадагш, дэргэдүүр, дээгүүр, доогүүр, хойгуур, урдуур
Past time	Өнгөрсөн цаг	ноднин, уржигдар, өчигдөр, саяхан, уржнан
Present time	Одоо цаг	одоо, өнөөдөр, эдүгээ, өнөө
Future time	Ирээдүй цаг	маргааш, нөгөөдөр, удахгүй, аажимдаа, дараа, мөдхөн, хойтон
General time	Ерөнхий цаг	үргэлж, дандаа, байнга, тогтмол, үүрд, заримдаа, хааяа, турш

Single word prepositions can be formed by adding a suffix to the stem of the word.

Хүснэгт 19. Орон цагийн нэр үүсгэх дагаврууд Table 19. Suffixes That Form Prepositions

Дагавар Suffixes	Жишээ Example
-р	дээр, доор, дотор
-на, -нэ, -но, -нө	цаана, наана, гадна, хойно
-ш, -гш	дээш, доош, гадагш, урагш, нааш
-уур, -үүр, -аар, -ээр	дээгүүр, урдуур, баруугаар, зүүгээр
-д	ард, хожид, мөнхөд, үүрд, гэнэт, хажууд

Multi-word prepositions include two words:

урьд хожид	уржигдар өглөө
хожуу хойно	нөгөөдрийн маргааш

эрт орой	маргааш орой
эргэн тойрон	баруун урд
хаа яагүй	зүүн өмнө
дээр доор	баруун хойно
цаана наана	эрт урьд

The prepositions of location mostly take the ablative case endings:

дээр <u>ээс</u>	наана <u>ас</u>	хажууна <u>ас</u>
-----------------	-----------------	-------------------

The prepositions of time mostly take the ablative and genitive case endings:

урьд <u>ын</u>	үүрд <u>ийн</u>	нөгөөдр <u>өөс</u>
----------------	-----------------	--------------------

#### GRAMMAR RULES:

The adjectives can be formed by adding the suffix -Д to the words with the stems дээ-, доо-, цаа-, наа-, хой-. Don't confuse this with the prepositions. When suffix -X is added to prepositions, they act as nouns and take plural, case or possessive endings:

дээрхүү <u>д</u> нь	дээрхийг нь	дээрхийнх нь
---------------------	-------------	--------------

In a sentence, prepositions are used independently. The prepositions of location subjugate the words before them using the genitive and ablative case endings:

модны цаана	голоо <u>с</u> нааш
-------------	---------------------

The words before the prepositions of location, such as дээр, доор, дотор, can be expressed with a zero genitive case ending:

гэр $\emptyset$ дээр	байшин $\emptyset$ дотор	сандал $\emptyset$ доор
----------------------	--------------------------	-------------------------

Besides being connected to the verbs mostly with their stem, the prepositions can also take the case endings:

Өчигдрийн ирсэн хоёр хүүгийн ХОЙНООС хэн ч асуусангүйд хүмүүс их л гайхаж байлаа.

Өчигдрийг өнөөдөртэй харьцуулах хэрэггүй.

NOTE: In Mongolian language, prepositions may either proceed or follow. Therefore, the prepositions that follow could be appropriately called *postpositions*. Please compare:

ӨНӨӨДӨР явсан (expresses time)

машины ард (expresses location)

Practice 1. prepositions.

Directions: Classify the following prepositions into two groups: location and time.

✓ баруун хойно	хаа сайгүй	хожим хойно
----------------	------------	-------------

✓ зүүн урд	алдаг оног	үр зуур
------------	------------	---------

эрт орой	мэр сэр	ойр орчим
----------	---------	-----------

ашид мөнх	өнө эрт	эргэн тойрон
-----------	---------	--------------

Location: баруун хойно.

Time: эрт орой.

Practice 2. prepositions.

Directions: Find and underline the prepositions.

1. Майхан дээрээ маг маг, маргааш өглөө дэг дэг. (Алаг даага)

2. Урдаа сэрээтэй, дундаа хөхүүртэй, ардаа ташууртай. (Үхэр)

3. Өглөөний хонь хойшоо бэлчинэ. Үдшийн хонь урагшаа бэлчинэ. (Өрх татах)

4. Ирээгүй дайсны өмнөөс томоогүй хүүхэд явуулсан. Наашаа ч хэлгүй, цаашаа ч хэлгүй. (Мануухай)

Practice 3. prepositions.

Directions: Complete the sentences with prepositions. Use the following list.

өдөр бүр	үдээс хойш
----------	------------

✓ өнөө орой	хойтон
✓ ирэх жил	хоолны дараа
дараа	өдөр
одоо	ирэх долоо хоногт

1. Амарсайхан \_\_\_\_\_ ирэх жил \_\_\_\_\_ хөдөө явна.
2. Тэр охин \_\_\_\_\_ гимнастик хийдэг.
3. Энэ бүсгүй \_\_\_\_\_ чамд бүжиг заана.
4. Тамир \_\_\_\_\_ их сургуульд сурна.
5. Тэр эрэгтэй \_\_\_\_\_ үсээ засуулна.
6. Би \_\_\_\_\_ утсаар ярья.
7. Ганболд \_\_\_\_\_ тийшээ банк руу явна.
8. Цогоо найз нартайгаа \_\_\_\_\_ кино үзэхээр тохирсон.
9. Чи \_\_\_\_\_ манайхаар ирэх үү?
10. Би \_\_\_\_\_ хоол хийх гэж байна.

□ Practice 4. prepositions.

Directions: Find and underline the prepositions.

1. Маргаашийн өөхнөөс өнөөдрийг уушги.
2. Урдаас нь харвал ухна ишиг шиг,  
Хойноос нь харвал хомтой тэмээ шиг.
3. Наанаа нандин хээтэй,  
Цаанаа чамин хээтэй.
4. Наашаа харвал наад далайн загас жараахай тоологдмоор,  
Цаашаа харвал цаад далайн загас жараахай тоологдмоор.
5. Дээрээс буусан юм шиг,  
Доороос ургасан юм шиг.

□ Practice 5. prepositions.

Directions: Complete the sentences with the nouns in parentheses.

Use the **-ын/-ийн, -ы/-ий, -н + дараа**.

Model: Үдийн (хоол) хоолны дараа би музей үзэхээр явна.

1. Таван (жил) \_\_\_\_\_ би сургуулиа төгсөнө.
2. Зургаан (сар) \_\_\_\_\_ Европоор аялна.
3. Нэг (цаг) \_\_\_\_\_ хоёулаа уулзъя.
4. Гучин (минут) \_\_\_\_\_ хоолондоо гарцгаая.
5. Хоёр долоо (хоног) \_\_\_\_\_ зуслан гарна.

□ Practice 6. prepositions.

Directions: Complete the sentences. Fill in the blanks with the form

**-ын/-ийн, -ы/-ий, -н + турш**.

Model: Тэр нэг (цаг) цагийн турш зогсолтгүй гүйж чадна.

1. Тэр өвгөн (өдөр) \_\_\_\_\_ нэг юмаа л яриад байсан.
2. Энхээ хоёр (цаг) \_\_\_\_\_ утсаар ярив.
3. Аав өдөр бүр хорин (минут) \_\_\_\_\_ гимнастик хийдэг.
4. Ээж гурван (жил) \_\_\_\_\_ гэртээ суусан.
5. Ариунтуяа арван (сар) \_\_\_\_\_ Эрдэнэт хотод амьдарсан.
6. Би 1990-1994 (онууд) \_\_\_\_\_ их сургуульд оюутан байсан.

□ Practice 7. prepositions.

Directions: Find and underline the prepositions and adjectives.

1. Тоглоом тоотой нь дээр,  
Толгой мөлжүүртэй нь дээр.

2. Чулуун дээр ногоо ургуулахад нэг бэрх,  
Усан дээр гал түлэхэд нэг бэрх,  
Үхрийн эвэр дээр цас тогтооход нэг бэрх.
3. Цаасан дээр нэртэй, цасан дээр мөртэй.
4. Дээр газрын агаар сийрэг тул сэрүүн,  
Доор газрын агаар нягт тул дулаан.
5. Манай эх нутгийн хөрсөн доор асар их баялаг бий.
6. Эрдэм номтой цэцнээс эд хөрөнгөтэй тэнэг долоон дор.
7. Дахан дор эр, даахин дор хүлэг.
8. Мөнх тэнгэрийн дор Монгол орон мөнх оршино.
9. Энэ газар олон жилийн турш нэг дор амьдарч, ижил дасал болсон бид бие биеэ сайн мэднэ.

□Practice 8. prepositions.

Directions: Find and underline the prepositions.

1. Саяхан нэг орой манай нутгийн анчин Дармаа Модотын шил дээр урьд өмнө үзэгдээгүй хоёр том амьтантай гэнэт тулгарчээ.
2. Гэтэл өчигдөр ууланд жимс түүж явсан хүүхдүүд нэг бүдүүн модны дэргэд хоёр том эрээн алаг амьтан хэвтэж байхыг холоос харсан байна.

□Practice 9. prepositions.

Directions: Find and underline the prepositions.

Дээрээс нар шарж, доороос элс төөнөсөн их говийн аагим халуунд ангаж ядарсан бяцхан хүү Болд хэдэн тэмээнийхээ хойноос мацна. Гэнэт элсэн манхны цаана хүн хашгирахыг сонсмогцоо босон харвал хэн ч үзэгдсэнгүй. Удалгүй манхны баруун урдуур хэдэн адуу туусан хоёр хүн гарч ирэхэд айж ганцаардсан хүүгийн нүдэнд баярын нулимс бүрхэв. Мөдхөн хүүгийн дэргэд тэд давхиж ирэхэд нэг нь нагац ах Дагдан болохыг хүү танив. Уржигдар тэмээгээ эрэхээр гэрээсээ гараад унасан морь нь зогссон тул олсон тэмээгээ гүйцэхгүй ядарч яваагаа түүнд ярьжээ.

□Practice 10. prepositions.

Directions: Complete the sentences with the prepositions. Use the following list.

дандаа	үргэлж	заримдаа	голдуу
ихэвчлэн	хааяа	✓ хэзээ ч	байнга

1. Аударь \_\_\_\_\_ хэзээ ч \_\_\_\_\_ хичээл тасалдаггүй.
2. Би \_\_\_\_\_ ус уудаг тул \_\_\_\_\_ усны сав авч явдаг.
3. Ах \_\_\_\_\_ нэг утсаар ярьдаг.
4. Гоогормаа \_\_\_\_\_ чихэртэй кофе уудаг.
5. Би өглөө оройгүй \_\_\_\_\_ кофе уудаг.
6. Энд \_\_\_\_\_ халуун байдаг.
7. Жаргал эмээтэйгээ \_\_\_\_\_ хөзөр тоглодог.
8. Би \_\_\_\_\_ чихэрлэг юм идмээр санагддаг.

## Холбох Үг Conjunctions 10

### Холбох Үгийн Ангилал Classification of Conjunctions 10.1

Auxiliary words that join clauses or parts of clauses are called *conjunctions*. There are two categories of conjunctions: *coordination* and *subordination*.

#### Зэрэгцүүлэн Холбох Үг Coordinating Conjunctions 10.1.1

The *coordinating* conjunctions link units which have the same status in the sentence, such as

two clauses, two noun phrases, or two adjectives. They have four functions:

Хүснэгт 20. Зэрэгцүүлэн холбох үг Table 20. Coordinating Conjunctions

Function	Нөхцөлийн үүрэг	Жишээ
Addition and Sequence	Ялган зэрэгцүүлэх	ба, бөгөөд, буюу, агаад, болоод, болон, хийгээд, хоёр
Contrast	Эсрэгцүүлэн зэрэгцүүлэх	харин, бөгөөтөл, боловч, гэвч, атал, авч, гэтэл, эсвэл, нэг бол, ч гэсэн, нөгөөтэйгүүр
Progress	Лавшруулан зэрэгцүүлэх	мөн, бас, байтугай, үл барам, барахгүй, өөрөөр хэлбэл, цаашилбал, мөн түүнчлэн
Explanation	Тайлбарлан зэрэгцүүлэх	иймээс, ийм учраас, иймд, ингэхлээр, хэрвээ, тэгвэл, нэгдүгээрт, тухайлбал

□ Practice 1. coordinating conjunctions.

Directions: Find and underline the coordinating conjunctions.

1. Уртнасан өөрөө хөлд нь сууж барьдаг, унахдаа бас аргаддаг зан сургачихсан морьд билээ.
2. Хэдхэн үгтэй тал хуудас боловч хүний хувь тавиланг тас харлуулж ч дөнгөдөг, дүүлэн нисэх жигүүртэй ч болгож чаддагийг би одоо л ухаарч байна.
3. Сүрлэг агаад ихэмсэг алхаатай, цаанаа л нэг бардам байдалтай тэр манж ноён хамт ирсэн монгол ноёноо өргөөнд түрүүлэн ор гэж гараа дэлгэн зааж худлаа маяглаж байгаа нь илт ажиглагдаж байв.
4. Үүдний баруун хатавчинд нохойн идүүр, том модон тэвш байх бөгөөд дотор нь хоолны үлдэгдэл, ямар нэг том амьтны түүхий элэг гэсгээжээ.

□ Practice 2. coordinating conjunctions.

Directions: Explain the function of the italicized conjunctions.

1. Тохсон эмээл нь ясан хяртай, мөнгөн хэрэглэлтэй *ба* бүүрэг навтгар, загас уужим *бөгөөд* олонцог нь бага урагджээ.
2. Аргаа барсан Ундармаа охиноо *нэг бол* ээждээ орхиод, *эсвэл* өөрөө ажилдаа авч явсаар хэдэн сарыг өнгөрөөв.
3. Хоёр хөлтэй хүн *байтугай* дөрвөн хөлтэй адгуус ч бүдэрдэг.
4. Зуны шөнө богино *тул* өглөөний найман цагт нар нэгэнт дээр гарч хамаг юм алган дээр тавьсан юм *шиг* үзэгдэнэ.
5. Хасаг тэрэгний хяхнах *тутам* Лувсангийн сэтгэл уйтгарлаж, хүрэн шарын хашигнах бүр түүний уур хүрнэ.
6. Хаантан минь, таныг миний *төлөө* харамсаж байна *гэвэл* хэн ч үнэмшихгүй.

□ Practice 3. coordinating conjunctions.

Directions: Complete the sentences with the conjunctions. Use the following list.

*ба*                      *эсвэл*                      ✓ *байтугай*  
*буюу*                      *бөгөөд*                      *боловч*

1. Харганатын даваан дээр гарахад хүн \_\_\_\_\_ *байтугай* \_\_\_\_\_ морь ч зүдэрдэг юм даа.
2. Хүүхэд насандаа энэ үлгэрийг Баярсайхан өөрөө зохиосон билүү, \_\_\_\_\_ үеийн найзууд нь хэлж өгсөн үү, одоо ер санах юм алга.
3. XVII жарны цагаан морин жил \_\_\_\_\_ 1990 он морьтон монголчуудын хувь заяанд нэн онцгой жил боллоо.
4. Сүүлийн үед зүүдлэх бүртээ л энэ наадмыг зүүдлэх \_\_\_\_\_ наран улам холдох тутам түүний зүүднээ араас нь нэхэн хөөх морьдын төвөргөөн улам ойртох болов.

5. Улмаар эрт \_\_\_\_\_ одоо, хол \_\_\_\_\_ ойрыг улируулан бодох тутам хүний амьдралын алаг эрээн улам тодрох ажээ.
6. Балбар эрдэм номын мөр хөөгөөгүй \_\_\_\_\_ амьдралын хар ухаанаар хэнийг ч дагуулахгүй эр гэдгийг энэ голынхон ер андахгүй.

□Practice 4. coordinating conjunctions.

Directions: Find and underline the conjunctions.

1. Эрхэм сайн хөвгүүний ёс нь:  
 Эцгийн сургаалаар явах бөгөөд  
 Эрдэм билиг сурахад дуртай  
 Энхрий ухаантай хөвгүүн лүгээ нэг.  
 Ах дүү хэнд ч аятай  
 Алинд ч зарваас ялгам сайн  
 Ааль зан нь дөлгөөн агаад номхон  
 Уургүй шударга хөвгүүн лүгээ хоёр болно.
2. Өгөр муу хөвгүүний ёс нь:  
 Эцгийн сургаалыг үл сонсогч  
 Эгнэгт тэнэг бөгөөд хэдэр  
 Эд малаа нууж хадгалагч  
 Эгэл муу хөвгүүн лүгээ нэг  
 Алиа болоод эрх танхи  
 Ахас ба ихсийг хараагч  
 Алинд ч зарваас ашид үл хөдлөгч  
 Адаг муу хөвгүүн лүгээ хоёр болно.
3. Дөрвөн буруу аль буй хэмээвээс:  
 Хэнд ч үйлдсэн нь тусгүй боловч үнэрхэх буруу  
 Хэтэрхий сайн мэдэлгүй боловч дэмий цэцэрхэх буруу  
 Хэнээс ч доор боловч ямагт хүчирхэх буруу  
 Хэмжээтэй хэдэн малтай боловч гэнэт баярхах буруу
4. Хүн бүрт сайн ба саар тал гэж бий. Тиймээс хүнийг хэрэглэхдээ түүний товойсон сайн талыг үзэж хэрэглэх нь чухал. Жишээлбэл, эрэлхэг баатар бөгөөд эрдэм бодлоготой хүнийг цэргийн жанжнаар хэрэглэж, нарийн нямбай бөгөөд залхуугүй хүнийг ачаа хөсгийн удирдах ажилд хэрэглэвэл зохино. Аравтын дарга болж чадвал мянгатын дарга болж бас чадна.

## 10.1.2 Угсруулан Холбох Үг Subordinating Conjunctions

The *subordinating* conjunctions subordinate one word to another, or one clause to another clause. In other words, they join units which do not have the same grammatical status in the sentence.

Угсруулан холбох үг Subordinating Conjunctions

тулд (тул)	дахин	шахам	бүр (бүрийд)	хүртэл
учир (учраас)	удаа	замд (замдаа)	дор	чинээ
төлөө	орчим	үед	дашрамд	адил
тухай	хавьцаа	алдад	ялдамд	мэт
талаар	эргэм	хэрд	аваас (бөгөөс)	шиг
турш	гаруй	тутам	болтол	сацуу
тусаар	уршгаар	улмаас	болохоор	бол (болбол)
зэрэг	ачаар	дагуу	зэрэгцээгээр	ёсоор

□Practice 5. subordinating conjunctions.

Directions: Find and underline the subordinating conjunctions in the sentences.

1. Хүнд эрдэм буй бол түүнд тус бий. Хэнд эе буй бол түүнд нөхөр бий.

2. Эх орон, ард түмнийхээ аз жаргал, сайн сайхны төлөө халуун амь, бүлээн цусаа өгсөн баатруудын гавьяа мөнхөжнө.
3. Хүүгийнхээ тухай олныг эргэцүүлэн бодож, алс хэтийн амьдралынх нь талаар цаг үргэлж санаа сэтгэлээ шаналгаж суугаа Бадарч өвгөний толгойд ёстой л бодол сэтгэлийн дайн болж байлаа.
4. Дулмааг зүтгүүлсээр даваан дээр гарахын алдад холоос харж суусан Жамган мориндоо мордон ташуур өгөхөд саарал морь ингэхийг л хүлээж байсан юм шиг нисэх мэт давхисаар дэргэд нь ирлээ.
5. Тэднийг ирэх бүрийд сэтгэлийн тэнхээ авч байдаг Жавын бие энэ удаа бүр эрүүл саруул болчихсон юм шиг санагдав.

□ Practice 6. conjunctions.

Directions: Find and underline the conjunctions. Label them coordinating or subordinating.

Эх нутгаа орхин явснаас хойш олон жилийн дараа би нэг сарын амралтаа өнгөрүүлэхээр буурал ээжийндээ ирсэн бөгөөд бага залуу насандаа ойн цагдааг бусадтай адил зэвүүрхэн үздэг байжээ. Харин одоо ном бичигт шунамхайрч, байгаль ертөнц, хүн амьтны элдэв явдлыг ихэд сонирхох болсон тул ойн цагдааг амьдралын нэгэн үзүүрт сэтгэл санаагаа нууцалж, хүнээс онцгой явах тавилантай болсон сонин хачин хүн гэж түүний амьдралын учир явдлыг уудлан илрүүлэхээр санаа шулуудан аль байдаг ухаанаа зарж, ой хөвчийн тухай үлгэр домгийг нь өдөөн яриулж, аливаа санал бодлыг нь даган баясч тал өгсний учир би дотно хүн нь болж авлаа.

(Сэнгийн Эрдэнэ “Хонгорзул”)

□ Practice 7. subordinating conjunctions.

Directions: Complete the sentences with the subordinating conjunctions. Use the following list.

<i>тулд</i>	<i>улмаас</i>	<i>алдад</i>	<i>болохоор</i>
<i>ялдамд</i>	<i>төлөө</i>	✓ <i>бүр</i>	<i>зэрэгцээгээр</i>

1. Түүн рүү залгах \_\_\_\_\_ **бүр** \_\_\_\_\_ утсаа авахгүй байна.
2. Хүүхдүүд нь том болсон \_\_\_\_\_ тустаа гарцгаасан.
3. Мартсаны \_\_\_\_\_ гар гарсан байна.
4. Тэнд хүрэхийн \_\_\_\_\_ морь хэрэгтэй.
5. Амьдралаа дээшлүүлэхийн \_\_\_\_\_ л тэд зүтгэж байна.
6. Цаадах чинь сургуульдаа сурахын \_\_\_\_\_ ажлаа бас хийж байгаа.
7. Биднийг явахын \_\_\_\_\_ бүрэнхий болов.
8. Ээжтэйгээ уулзах \_\_\_\_\_ хамт кафе орсон.

□ Practice 8. subordinating conjunctions.

Directions: Complete the sentences. Use the word that fits the most:

**тутам, тутмаа, тусам, ог тусмаа.**

1. Байгалийн сайхныг хэвээр нь хадгалагдах \_\_\_\_\_ сайн.
2. Удах \_\_\_\_\_ дасч байна.
3. Өдөр бүр давтах \_\_\_\_\_ ойлгож байна.
4. Машины тоо ихсэх \_\_\_\_\_ замын түгжрэл нэмэгдсээр.
5. Ганбат явах \_\_\_\_\_ шинийг олж мэддэг.
6. Түүний тухай бодох \_\_\_\_\_ миний сэтгэл уйтгарлана.
7. Бороо орох \_\_\_\_\_ зүлэг ногоорч байна.
8. Сүүлийн үеийн шинэ технологийг нэвтрүүлэх \_\_\_\_\_ ажил сайжирч байна.
9. Хүн витаминлаг хоол хүнс хэрэглэх \_\_\_\_\_ эрүүл мэндэд сайн.
10. Хийх \_\_\_\_\_ ажил улам ундардаг.

# 11 Чимэх Үг Particles

## 11.1 Чимэх Үгийн Ангилал Classification of Particles

The *particles* express different approaches of the speaker. In other words, they extend a sentence with additional meanings. The particles can either proceed or follow the word they are related to.

Хүснэгт 21. Чимэх үгийн ангилал Table 21. Classification of Particles

Meaning	Чимэх Үгийн Ангилал	Particles Чимэх үг
Emphasizing	Онцлон чимэх үг	л, ч, зөвхөн, бас, ялангуяа, гагцхүү, яг, чухам (чухамхүү), ер нь, уг нь (угтаа)
Question	Асуун чимэх үг	вэ (бэ), уу (үү), юу (юү)
Negative	Үгүйсгэн чимэх үг	үл, эс, биш, бус
Confirmative	Батлан чимэх үг	мөн, юм, үнэхээр, гарцаагүй, заавал, зайлшгүй, мэдээж
Prohibiting	Хориглон чимэх үг	бүү, битгий, ёсгүй, хэрэггүй
Reminding	Сануулан чимэх үг	шүү, даа, даг
Describing the action	Үйл байдал дүрслэн чимэх үг	хага, хуга, цоо, цөм, сад, гуд, няц, бяц
Intensifying	Эрчимжүүлэн чимэх үг	маш, нэн, тун, пад, пид, тас, пиг, таг, цэлдэн, бүр, үлэмж, улам, лав
Guessing	Таамаглан чимэх үг	биз, байх, байлгүй, бололтой, магадгүй, төлөвтэй, маягтай, магад
Permitting	Зөвшөөрөн чимэх үг	ёстой, хэрэгтэй
Imitating	Дуурайн чимэх үг	пад, тас, сэр, час, тог, пал, пүл, жир
Describing	Төрх байдал дүрслэн чимэх үг	гялс, сартас, арзага, бондого, ярс, хотос, бөндөг, гялав

Particles that proceed:

бүү ялангуяа  
үл үнэхээр  
маш заавал  
яг зөвхөн  
ер нь хуга  
пад бяц

Particles that follow:

вэ байлгүй  
даг ёстой  
биш бололтой  
шүү мөн  
л юмсан  
биз даа

## Ээлдэг Хэлбэр Polite Forms 11.2

The particles УУ and ҮҮ are used after the verb ending -НА<sup>4</sup> in polite forms:

Та үүнийг авна уу.

Та энэ номыг уншина уу.

Та цай ууна уу.

The particle ЮУ is used after the verb ending -чихгүй to ask someone to do something in less formal way:

Та түүнд үүнийг дамжуулчихгүй юу.

Чи энэ захиаг замаараа явуулчихгүй юу.

GRAMMAR RULE:

Remember that no question mark is required after these particles.

□Practice 1. partICLES.

Directions: Answer the questions. Use **л**, **ч**. Write the sentences.

Model: *Чи рок хөгжим сонсдог уу, поп хөгжим сонсдог уу?*

a. Би рок хөгжим **л** сонсдог, поп хөгжим сонсдоггүй.

b. Би рок хөгжим **ч** сонсдог, поп хөгжим **ч** сонсдог.

c. Би рок хөгжим **ч** сонсдоггүй, поп хөгжим **ч** сонсдоггүй.

1. Чи өглөө босоод йога дасгал хийдэг үү, аэробик хийдэг үү?

a. \_\_\_\_\_

b. \_\_\_\_\_

c. \_\_\_\_\_

2. Зугаалганд ундаа авч явах уу, ус авч явах уу?

a. \_\_\_\_\_

b. \_\_\_\_\_

c. \_\_\_\_\_

3. Та төрийн ажил хийдэг үү, хувийн бизнес эрхэлдэг үү?

a. \_\_\_\_\_

b. \_\_\_\_\_

c. \_\_\_\_\_

4. Та машин барих дуртай юу, мотоцикл унах дуртай юу?

a. \_\_\_\_\_

b. \_\_\_\_\_

c. \_\_\_\_\_

□Practice 2. partICLES.

Directions: Complete the sentences with the particles. Use **вэ (бэ)**, **уу (үү)**, **юу**.

1. Ариунаа юу хийж байна \_\_\_\_\_? Зурагт үзэж байна \_\_\_\_\_?

2. Та хэд нүүх гэж байна \_\_\_\_\_? Хэзээ нүүх гэж байна \_\_\_\_\_?

3. Дондог өрөөндөө байна \_\_\_\_\_? Тэр хаана байна \_\_\_\_\_?

4. Энэ юун чимээ \_\_\_\_\_? Бороо орж байна \_\_\_\_\_?

5. Та театр явах гэж байна \_\_\_\_\_? Юу өмсөж явах \_\_\_\_\_?

6. Охиноо хооллосон \_\_\_\_\_? Юу идүүлж байна \_\_\_\_\_?

□Practice 3. partICLES.

Directions: Complete the sentences with the particles.

Use **байх**, **магадгүй**, **бололтой**.

1. Маргааш бороо орох \_\_\_\_\_.

2. Бид орой явж \_\_\_\_\_.

3. Тэр маргааш ирэх \_\_\_\_\_.

4. Бат өнөөдөр завгүй \_\_\_\_\_.

5. Тэнд хүйтэн байж \_\_\_\_\_.

6. Болд өнөөдөр явахгүй \_\_\_\_\_.

□Practice 4. partICLES.

Directions: Find and underline the particles.

Аав намайг нэвт шувт харах мэт над руу удаан ширтсэнээ:

– Чи арай морио голж байгаа юм биш биз. Морь гэдэг чинь хүнийг голно уу гэхээс хүнд гологдохоор хийморьгүй амьтан биш шүү. Эцэг өвгөдийн үеэс хүний хэргийг бүү хэл төрийн хэргийг ч бүтээж, улс гэрийг төвхнүүлэх үйлсэд хүчин зүтгэж яваа унаа. Наад Халзан үрээ чинь өнөөдөр бие давжаа, явдал удаантай ч манай хурдан хул азарганы удам юм шүү. Нас шүд нь гүйцээд ирэхээр яах ч юм билээ.

□Practice 5. partICLES.

Directions: Complete the sentences. Change imperatives in parentheses into polite forms.

1. Та даргыг иртэл энд (хүлээ) \_\_\_\_\_.
2. Та энэ захидлыг (дамжуул) \_\_\_\_\_.
3. Та энэ бичгийг тарааж (өг) \_\_\_\_\_.
4. Та над руу утсаар яаралтай (ярь) \_\_\_\_\_.
5. Та факсаа одоо (явуул) \_\_\_\_\_.
6. Та энэ номыг уншаад сэтгэгдлээ (хэл) \_\_\_\_\_.

## Үгийн Сан Vocabulary 12

### Хоршоо Үг Compound Words 12.1

The term *compound* is used to define the two words that together have the same meaning as one word. For example:

энх тайван

эрх чөлөө

эцэг эх

### Зэрэгцсэн Хоршоо Үг Parallel Compound Words 12.1.1

In a *parallel compound* structure, a word has an independent meaning and is similar to the meaning of the other word. These words consist of two words of the same word class.

эрх чөлөө	өдий төдий	цовоо сэргэлэн
эв эе	наргиж цэнгэ	санаа сэтгэл
эрх танхи	эрт орой	ард түмэн
элбэг дэлбэг	хожим хойно	ашиг шим
урьд хожид	тав зургаа	эргэн тойрон
уйлж унж	ганц хоёр	энд тэнд
жаргаж зов	зүүн урд	арван долоо
аз жаргал	нялх балчир	энх тайван

In a *simple parallel* **энгийн зэрэгцсэн** structure, words consist of synonyms and antonyms.

хүсэл мөрөөдөл	энд тэнд	тав зургаа
хүч хөдөлмөр	өч төчнөөн	зовж шанал
ах дүү	ийш тийш	хорь гуч
амраг садан	хэлж барь	хожим хойно
эгэл жирийн	ирж оч	түм бум
алс хол	наадаж нарги	эрт орой

In a *repeated parallel* **давтан зэрэгцсэн** structure, the second word repeats the first. However, the first letter of the second word changes into one of the letters М, З, С.

ном <u>з</u> ом	хэн <u>м</u> эн	долоо <u>м</u> олоо
нохой <u>м</u> охой	ингэж <u>м</u> ингэ	дээр <u>м</u> ээр
хүн <u>м</u> үн	ийм <u>м</u> ийм	тавь <u>м</u> авь
өндөр <u>м</u> өндөр	маргаж <u>з</u> арга	эрт <u>м</u> эрт
бага <u>с</u> ага	явж <u>м</u> ав	одоо <u>м</u> одоо
жижиг <u>с</u> ажиг	унтаж <u>м</u> унт	бүжиг <u>м</u> үжиг

The repeated parallel compounds are used in conversations and have a broader meaning. For instance, *номоо унш* means *to read a book only*, *ном зомоо унш* means *to read a book, a newspaper, or a magazine* etc.

GRAMMAR RULE:

The word *авч ир* can be replaced with *авчир*. The infinitive form of would be *авчрах*. Therefore, both

forms can be equally used: *авч ирсэн = авчирсан*.

□ Practice 1. Vocabulary: COMPOUND words.

Directions: Add a verb to the following parallel COMPOUND nouns.

ашиг шим \_\_\_\_\_  
аз жаргал \_\_\_\_\_  
найз нөхөд \_\_\_\_\_  
дэлхий ертөнц \_\_\_\_\_  
бичиг баримт \_\_\_\_\_  
ажил хөдөлмөр \_\_\_\_\_  
хайр халамж \_\_\_\_\_  
ан амьтан \_\_\_\_\_

□ Practice 2. Vocabulary: COMPOUND words.

Directions: Find and underline the parallel COMPOUND nouns.

Унаж босоход минь сургаж, ухаан бие хоёрыг минь борогшуулсан Их дэлгэрэхийн чулууг би хүндэлнэ. Тусад орж хонь хурганы бэлчээрт хүрэх болсон цагаас тоглох тоглоом минь чулуу болсон. Адуу мал, айраг цагаа, авдар савнаас эхлүүлээд эцэг эхийн хэрэглэдэг бүхнийг би чулуунаас эрнэ.

□ Practice 3. Vocabulary: COMPOUND words.

Directions: Identify which group of words is the Parallel verbs and which one is the COMPOUND verbs.

1. тоглож наад, харж суу, цэнхэрлэн харагд, жирэлзэн урс, доголж яв, эвлүүлж тавь, гайхаж зогс \_\_\_\_\_

2. хахаж цац, тас цохь, өсч өндий, цоо хатга, үргэж бусга, шуу гүй, эргэж хурга, хайрлан хамгаал \_\_\_\_\_

□ Practice 4. Vocabulary: COMPOUND words.

Directions: Find and underline the parallel compound nouns in the following sentences.

1. Залуу зүрх сэтгэлд нөлөөлөгч маш нарийн арга барил гэвэл, миний бодлоор, үг ба гоо сайхан хоёр юм.
2. Оюун ухааны эрхэм сайхан хүмүүжилд байгалийн гоо сайхан их үүрэг гүйцэтгэдэг.
3. Хүн төрөлхтний амьдрал, гоо сайхны эх булаг болсон эмэгтэйчүүдтэй зөв харьцдаг, эх хүнийг хүндэтгэдэг харилцаа сургуулийн газарт ноёрхож байх ёстой.
4. Гэрэлмааг эмнэлэгт хэвтэхэд ажлын газрын хамт олон нь эргэж очив.

□ Practice 5. Vocabulary: COMPOUND words.

Directions: Find the compound adjectives. Mark them with ✓.

_____ алтан нар	_____ зээрд халзан
_____ мөнгөн сар	_____ номин цэнхэр
_____ алтан шарга	_____ үнсэн саарал
_____ мөнгөн цагаан	_____ цоохор үхэр
_____ хун цагаан	_____ хөх цоохор
_____ хээр алаг	_____ цөсөн шар
_____ хээр морь	_____ цагаан хонь
_____ зээрд унага	_____ сувдан цагаан

□ Practice 6. Vocabulary: COMPOUND words.

Directions: Add a noun to each of the following parallel compound adjectives.

нялх балчир \_\_\_\_\_  
нягт нямбай \_\_\_\_\_  
сэргэлэн цовоо \_\_\_\_\_

эвлэг зөөлөн	_____
онгорхой цоорхой	_____
хазгай муруй	_____
хол ойр	_____
ядуу зүдүү	_____
элбэг баян	_____
эрх танхи	_____
хүнлэг энэрэнгүй	_____
хүйтэн цэвдэг	_____

## 12.1.2 Угсарсан Хоршоо Үг Successive Compound Words

In a *successive compound* structure, one word is dependent upon another. And it only makes sense as a whole phrase:

усан үзэм	бяц дэвс	хээр алаг
алтан хараацай	огло харай	ямаан арц
цагаан толгой	гуд тат	хонин гүрвэл
хөх цоохор	баруун нойно	үхэр буу
хар халзан	зүүн урд	тэмээн хяруул
зүүн урд	наян найм	морин шарилж
бут ниргэ	улаан буурал	зохион байгуул
бүтээн босго	хөх цоохор	цагаан цэнхэр
арван долоо	зээрд халзан	хар хөх
гучин зургаа	хөх алаг	улаан зээрд
хар цоохор	цагаан сар	шар шувуу
тавь жар	тэмээн хяруул	мөнгөн ус
бодож болгоо	хянан шалга	халууны шил

When a word connects to the other word with its stem, it's called an *added connection*

### хамжуулах холбоо.

цагаан толгой	улаан бурхан
хөх дэглий	шар шувуу

When a word connects to the other word with the endings, it's called a *mixed connection*

### найруулах холбоо.

үхрийн нүд	нөгөөдрийн маргааш
нохойн хошуу	зохион байгуул
шинжлэх ухаан	лавлах товчоо
дүрслэх урлаг	унадаг дугуй
хоёрны нэг	нисдэг тэрэг

□ Practice 7. Vocabulary: COMPOUND words.

Directions: Add a noun to each of the following successive compound adjectives.

улаан хүрэн	_____
хар хээр	_____
цагаан цэнхэр	_____
зээрд халзан	_____
хар цоохор	_____
гал улаан	_____
ангир шар	_____
дун цагаан	_____
номин цэнхэр	_____
шийр алаг	_____

магнай халзан

уян хатан

□ Practice 8. Vocabulary: COMPOUND words.

Directions: Find and underline the compound words.

Хөх ногоон, ухаа шаргал алагласан энэ их тал нутаг ертөнцийн түмэн галавт ийнхүү амгалан бөгөөд хувиршгүй мэт боловч хүний үр нэгэн төрөл өнгөрөх хооронд юуг эс үзнэм билээ. Өвгөн Ёнхор ухаан орсон цагаас энэ уужим талд хөлгийн шандас сунгаж, жилийн дөрвөн улирлыг төгсгөлгүй нүүдэл суудалд өнгөрүүлжээ. Тийнхүү өнгөрүүлсэн жаргал зовлонгийн өдрүүдийг тэнцүүлэн тооцох аргагүй. Үр ач нар хүний зэрэгтэй болж гал голомт залгалаа. Тал, хүн хоёр эх үр шиг амин хүйсийн холбоотой ажээ. Тэр ч байтугай ухаан санаа, зориг хүслэн, алдаа эндэгдэл цөмөөрөө холбоотой. Өөрийн ааш араншин, урвал хувиралтай энэ тал хүнийг хүн болгож хатуужуулан амьдралд тэнцэх чадлыг нь шалгана.

(Сэнгийн Эрдэнэ “Өвгөн хүн чулуу хоёр”)

□ Practice 9. Vocabulary: COMPOUND words.

Directions: Find and underline the COMPOUND words.

1. Монголын байгаль орчныг хамгаалах нийгэмлэгээс эрхлэн гаргасан Улаан номд дэлхий дахинаа нэн ховор болж устах аюулд дөхөөд байгаа цагаан тогоруу, хар тогоруу, цэн тогоруу, жороо тоодог, реликт цахлай, хургач бор хэмээх зургаан зүйл, мөн нутгийн ихэнх хэсгээр ховордож байгаа борцгор хотон, халбаган хошуут, хар өрөвтас, гангар хун, хуруут хун, хээрийн галуу, хошуу галуу, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, цасны хажир, гургуул, тоодог зэрэг арван хоёр зүйл шувууг оруулжээ.

(Сумъяагийн Жамбалдорж)

2. Говь нутагт нэлээд элбэг тохиолддог цагаан тэмээ хэмээх аалз маш сонин амьтан юм. Түүний явж байгааг харахад хар өнгөтэй мэт байх боловч үнэндээ цайвар цагаан өнгөтэй бөгөөд зулзаганууд нь эхийнхээ нуруун дээр шавснаас хар харагддаг байна. Уг аалзны зулзаганууд нь өсөн өндийтлөө эхийнхээ шим шүүсийг сорж, идэж бардаг муу ёрын амьтан гэж хүмүүс ярьдаг. Хөөрхий, цагаан тэмээг хамгийн үйлтэй амьтан гэхээс өөр юу гэх вэ? Хүн төрөлхтөнд л ийм үйл бүү заяагаасай гэж бодном.

(Сумъяагийн Жамбалдорж)

## 12.2 Олон Утгат Үг Polysemantics

Besides the main *direct meaning* **шууд утга**, a word can have several other *figurative meanings* **шилжсэн утга**. It's called *polysemantics*. Direct meaning forms a base for the figurative meanings. A figurative meaning is formed based on the similarities of shape, appearance, relationship, function and purpose.

There are three categories of similarities.

Comparison **зүйрлэн нэрлэсэн** is based upon appearance and function:

*тохой* – гарын тохой

голын тохой

*жолоо* – хүлгийн жолоо

эрдмийн жолоо

төрийн жолоо

амьдралын жолоо

*гар* – хүний гар

дугуйны гар

хадуурын гар

гар харах

гар дүрэх

гараа гаргах

гар татах

гар сунгах

Substitution **солин нэрлэсэн** is based upon location and time:

хул айргийг уух – хулыг уух  
аяга будаа идэх – аягыг идэх

Representation **төлөөлөн нэрлэсэн** is based upon a fact that a whole represents a part and vice versa:

өрх – айл  
ам – хүн  
толгой – мал

□Practice 10. Vocabulary: polysemantics.

Directions: Notice the meaning of the word **толгой**. Identify which has the direct meaning and which has the figurative.

1. Өвгөн Дондог өдөржин халуун наранд хонь хяргаснаас *толгой* нь өвдөж, дотор нь эвгүйрхсэн тул ач хүү Бадарчийгаа дуудаж толгойгоо бариулав. \_\_\_\_\_
2. Сэвэлзүүр салхинд өвсний *толгой* найган ганхаж, талын болжмор жиргэх нь нэн таатай. \_\_\_\_\_
3. Өглөөний нарны шаргал туяа хойт уулын *толгойд* туссан нь алтан титэм өмссөн баатар эрийг санагдуулна. \_\_\_\_\_
4. Хал үзэж, халуун чулуу долоосон хөгшин *толгой* иймэрхүү юманд хууртахгүй гэдгийг би даанч санасангүй. \_\_\_\_\_

□Practice 11. Vocabulary: polysemantics.

Directions: Read and learn the different meanings of the same word.

Fill in the blanks with those words.

1. ам – хүний \_\_\_\_\_ 5. дээр – ширээн \_\_\_\_\_  
уулын \_\_\_\_\_ ажил \_\_\_\_\_  
даавууны \_\_\_\_\_ \_\_\_\_\_ газар  
бөхийн \_\_\_\_\_ явах нь \_\_\_\_\_  
нүхний \_\_\_\_\_ 6. хүрэх – нойр \_\_\_\_\_  
аяганы \_\_\_\_\_ залхуу \_\_\_\_\_  
бууны \_\_\_\_\_ насанд \_\_\_\_\_
2. татах – өрх \_\_\_\_\_ эгдүү \_\_\_\_\_  
хөшиг \_\_\_\_\_ дургүй \_\_\_\_\_  
салхи \_\_\_\_\_ инээд \_\_\_\_\_  
сэрүү \_\_\_\_\_ ханиад \_\_\_\_\_  
манан \_\_\_\_\_ уур \_\_\_\_\_  
сугалаа \_\_\_\_\_ гижиг \_\_\_\_\_  
татвар \_\_\_\_\_ сэжиг \_\_\_\_\_  
хань \_\_\_\_\_ 3. зөөлөн – \_\_\_\_\_ даавуу  
тамхи \_\_\_\_\_ \_\_\_\_\_ суудал  
нүд \_\_\_\_\_ \_\_\_\_\_ сэтгэл  
униар \_\_\_\_\_ \_\_\_\_\_ дарс
4. таван – \_\_\_\_\_ морь \_\_\_\_\_ ажил  
\_\_\_\_\_ амтай \_\_\_\_\_ чихтэй  
\_\_\_\_\_ үс  
олон \_\_\_\_\_ үггүй  
\_\_\_\_\_ хуруу тэгш

□Practice 12. Vocabulary: polysemantics.

Directions: Find and underline the words used in the figurative meaning.

1. Тахирлан урсах Суман голын нэгэн тохойд хүрч, түр саатах зуураа байгаль эхийн түмэн гайхамшгийг бахдан биширч билээ.

2. Эх орон, ард түмнийхээ тусын тулд төрийн жолоо атгалцаж явсан хариуцлагатай бөгөөд буянтай үйлсийн алтан үе зүрх сэтгэлд минь үргэлж хадаастай байдаг.
3. Өлсөж цангаж, ядарч зүдэрч явсан болохоор тэр их хоол ундыг хараад баярлан гайхаж нэлээд зогсов. Тэгээд айрагнаас нь гурван хулыг ууж, будаанаас нь хоёр аягыг идээд ум хумгүй гарч одлоо.
4. Манай сум 600 гаруй өрх, 2000 гаруй хүн ам, 80-аад мянган толгой малтай.

□Practice 13. Vocabulary: polysemantics.

Directions: Find and underline the words used in the figurative meaning.

1. Хутгаа билүүдсэн хүн мах иднэ. Хэлээ билүүдсэн хүн ял эдэлнэ.
2. Хүний зөөлнийг хүн олох, модны зөөлнийг тоншуул олох.
3. Төр гэдэг төмөр нүүртэй, төрсөн бие махан нүүртэй.
4. Хүний эрээн дотроо, могойн эрээн гаднаа.
5. Хурц сэлэм, хурдан морь, хурц ухаан, хурдан зан.
6. Ханан гэр холдож, хадан гэр ойртох.
7. Улааныг үзэж урвах, шарыг үзэж шарвах.
8. Атан тэмээ ачаа даадаг, аавын хүү үг даадаг.
9. Хадгийг барихдаа, өгөх хүн рүүгээ амыг хандуулан хүндийн эрэмбээр мэхийх, эсвэл сөгдөж барина. Цаад хүн хариу мэхэсхийж, хадгийг хоёр гардан аваад, аятай эвхэж хямгадах ёстой.

□Practice 14. Vocabulary: polysemantics.

Directions: Read and learn the meaning of the following allegories.

1. Бадарчин явсан газар балагтай, батгана суусан газар өтгэй.
2. Алтны дэргэд гууль шарлана, сайны дэргэд муу сайжирна.
3. Муугаас муу, модноос хөө.
4. Үзүүр хүрвэл уяа хүрдэг, үг хүрвэл хариу дуулдаг.
5. Ниссэн шувуу эргэдэг, ирсэн зочин буцдаг.
6. Их санасан газар есөн шөнө хоосон.
7. Нэг үхрийн эвэр доргиход мянган үхрийн эвэр доргино.
8. Нэг тэмээний хорголд мянган тэмээ халтирдаг.
9. Овоо босгоогүй бол шаазгай юунд суух вэ.
10. Урьтаж дуугарсан хөхөөний ам хөлдөнө.

## Ойролцоо Утгат Үг Synonyms 12.3

The *synonyms* are lexemes different in writing and pronunciation, but similar in their meaning. Notice how synonyms are used in the following parallel compounds.

1. хань ижил	төрөл садан	сэтгэл санаа
үр дүн	хүч чадал	аз жаргал
2. эрх танхи	идэр залуу	цовоо сэргэлэн
нялх балчир	шулуун шударга	сүрлэг том
3. бодож болгоо	тэжээж тэтгэ	харж ханд
уулзаж учир	эргэж хурга	өсч төлж
4. хожим хойно	үүрд мөнх	эргэн тойрон
эрт урьд	өнө мөнхөд	урьд өмнө

The synonyms can be created by using the words in *honorific хүндэтгэсэн буюу дээд найруулга*, *generic ерийн буюу дунд найруулга* or *demeaning доромж буюу доод найруулга* contexts. There may be stylistic difference or difference of emotional feeling.

мэлмий	–	нүд	–	хонхор
тэргүүн	–	толгой	–	бөндгөр
мутар	–	гар	–	савар

айлдах – хэлэх – чалчих  
залах – урих – дуудах

□Practice 15. Vocabulary: synonyms.

Directions: Fill in the blanks with the word that fits the most.

1. Үлэмжийн сайхан \_\_\_\_\_ (*ертөнцөд, орчлонд, хорвоод*) тээж төрүүлсэн ээжийгээ үсэн буурал болох бүр \_\_\_\_\_ (*гэнэ гэнэхэн, үе үе, байн байн*) л санах юм. Үүрийн цагаан гэгээтэй \_\_\_\_\_ (*урьтан, анхлан, эхлэн*) золгох энгэрт \_\_\_\_\_ (*мөнхөд, насад, үүрд*) нойрссон шарилыг нь байн байн л эргэх юм. (Бэгзийн Явуухулан)
2. Бүгдийг гэрэлтүүлэн, \_\_\_\_\_ (*цөмийг, бүхнийг, хамгийг*) баясгагч наран үнэхээр гайхамшиг. Амьсгалыг сольж, амьтныг \_\_\_\_\_ (*жаргуулагч, наргиулагч, цэнгүүлэгч*) агаар үнэхээр гайхамшиг. Ургамал, амьтан, бодисыг \_\_\_\_\_ (*тэтгэгч, тэжээгч, хооллогч*) ус үнэхээр гайхамшиг. (Дашдоржийн Нацагдорж)
3. Саахалт \_\_\_\_\_ (*айлын, гэрийн*) хооронд салахыг мартан \_\_\_\_\_ (*тоглож, наадаж*), хорвоогийн \_\_\_\_\_ (*жаргал, цэнгэл*) эдэлсэн хоёр балчрыг \_\_\_\_\_ (*үзээд, хараад*), \_\_\_\_\_ (*үлгэр, жишээ*) болгомоор цэвэрхэн \_\_\_\_\_ (*нөхөрлөл, үерхэл*) гэдгийг ухаарлаа. (Д. Пүрэвдорж)

□Practice 16. Vocabulary: synonyms.

Directions: Fill in the blanks with the word that fits the most.

1. \_\_\_\_\_ (*хөндий, уужим, саруул, тэгш*) тал байвч шавар намгийг нь мэдээрэй.
2. Банкинд төлөх \_\_\_\_\_ (*зээл, өр шир, хүү сан*) толгойтой үснээс олон болов.
3. Хүн \_\_\_\_\_ (*хандиваар, тусламжаар, өргөл барьцаар, тэтгэмжээр*) баяждаггүй, харин ажил хөдөлмөрөөрөө баяждаг.
4. Дорж гуайнх манай \_\_\_\_\_ (*садан, төрөл, хамаатан*) юм.

□Practice 17. Vocabulary: synonyms.

Directions: Find as many synonyms as possible for the following words.

гэрлэх – *ээр бүл болох*, \_\_\_\_\_

Нас барах – *үхэх*, \_\_\_\_\_

## Эсрэг Утгат Үг Antonyms 12.4

The *antonyms* are lexemes which contradict and are opposite in meaning:

1. Things or phenomena:

ах – эгч	амьдрал – үхэл	тоглоом – шоглоом
дайн – энх	сэргэлт – мөхөл	өдөр – шөнө
жаргал – зовлон	эм – хор	том хүн – хүүхэд
тэнгэр – газар	ажил – амралт	эхлэл – төгсгөл
хот – хөдөө	баяр – гуниг	дарга – цэрэг

2. Actions:

босох – суух	онгойлгох – хаах	зугтах – хөөх
ирэх – явах	унтах – сэрэх	өргөх – буулгах
салах – нийлэх	мандах – жаргах	мартах – санах
инээх – уйлах	татах – түлхэх	нээх – хаах

3. Qualities:

сайн – муу	даруу – их зантай	цэлмэг – үүлтэй
------------	-------------------	-----------------

халуун – хүйтэн	цэнгэг – булингартай	ухаантай – тэнэг
хурдан – удаан	ажилсаг – залхуу	хол – ойр
өндөр – нам	зугаатай – уйтгартай	хүчтэй – хүчгүй

4. Time - Location:

дээр – доор	өглөө – орой
өмнө – хойно	дээр үед – хаа байсан
эрт – орой	өчигдөр – маргааш
ноднин – хойтон	уржигдар – нөгөөдөр

Not every word has an antonym, but some words can have antonyms in their figurative meaning. The concepts are in opposition, certainly, but there are no pairs of antonyms:

Арслан шиг архираад, зурам шиг зугтах.

Тус болох гэсэн биш ус болов.

NOTE: The words of opposite meaning are used together as phrasal words to give the meaning of *everybody*. In this case, the second word takes a negative ending -гүй:

Тэр өвөл зунгүй л усанд сэлдэг.

□ Practice 18. Vocabulary: Antonyms.

Directions: Fill in the blanks with the word that fits the most.

1. Дайсанд цусаа бүү үзүүл, \_\_\_\_\_ (андад, найзад, нөхөрт) муугаа бүү үзүүл.
2. Олон хэлбэл улиг, \_\_\_\_\_ (гани, цөөн, товч, цомхон) хэлбэл билиг.
3. Олон үгний \_\_\_\_\_ (уяа, оосор, бүч) нь нэг. Түмэн үгний түлхүүр нь нэг.
4. Дагданы эхнэрийн \_\_\_\_\_ (мярайлсан, өөхөлсөн, бүдүүрсэн, таргалсан), Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ.
5. Хүн бүр \_\_\_\_\_ (өвгөд, өтгөс, буурал, хөгшин) үдэж, нялхсыг угтана.

□ Practice 19. Vocabulary: Antonyms.

Directions: Find and underline the antonyms.

1. Ой мод урттай богинотой. Олон хүн сайтай муутай.
2. Аавын хүү алагтай цоогтой. Арын мод өндөртэй намтай.
3. Авах хүн бөхийдөг. Өгөх хүн гэдийдэг.
4. Сууж амрахаар явж амар.
5. Эрхийг сурахаар бэрхийг сур.
6. Хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зов.
7. Гашуунаар бүү тэтгэ. Амттанаар бүү цатга. Өнгөнд бүү бялуур. Тансагт бүү умбуул.
8. Цэцэнд хоёр чих цөөдөх, тэнэгт ганц хэл олдох.
9. Бэрхэд битгий цухалд, хялбарт битгий ташуур.
10. Сайн санаа талыг тойрно. Муу санаа биеийг орооно.
11. Хорт могойд нарийн бүдүүн гэж үгүй. Хорт дайсанд хол ойр гэж үгүй.
12. Уулын чинээ харыг туулайн чинээ цагаан дийлнэ.

□ Practice 20. Vocabulary: Antonyms.

Directions: Complete the following allegories.

1. Гараар аваад, \_\_\_\_\_.
2. Орохдоо зүүний чинээ, \_\_\_\_\_.
3. Сайн хүний үг сарын хүнс, \_\_\_\_\_.
4. Тэнүүн явахад тэмээгээр тусалснаас \_\_\_\_\_.
5. Тэнэгүүдийг хагацуулахад хялбар, эвцүүлэхэд бэрх.  
\_\_\_\_\_.
6. Далайсан газар далд орж, \_\_\_\_\_.
7. Гаднаа гяланцаг, \_\_\_\_\_.
8. Сайн санааны үзүүрт тос, \_\_\_\_\_.

9. Өглөө хазаар, \_\_\_\_\_.

□ Practice 21. Vocabulary: Antonyms.

Directions: Complete the sentences with the words in parentheses. Use **-гүй**.

Model: (Хөгшин) Хөгшин залуугүй бүгд баярласан.

1. Тус тэмцээнд (эр) \_\_\_\_\_ бүгд оролцсон.
2. Тэднийхэн (өдөр) \_\_\_\_\_ шуугилддаг.
3. Талын хурц наранд (хүн) \_\_\_\_\_ бүгд нозооров.
4. Аймгийн хуралд (ойр) \_\_\_\_\_ бүх газраас цугларсан.
5. Найз маань (өглөө) \_\_\_\_\_ шалгалтандаа бэлдээд завгүй байгаа.
6. (Том) \_\_\_\_\_ хүүхэд бүр баяртай байсан.

## Ижил Үг Similar Words 12.5

The *similar words* are the words that have the same form but different meaning:

хар – харах

хар өнгө

хар газар хусах

хар хорын

хар хар хийх

Notice how some words are similar in both writing and pronunciation:

- амар (амрах) – амар (хялбар)  
дал (70) – дал (дал мөр)  
авир (авирах) – авир (ааш авир)  
нүд (хүний нүд) – нүд (нүдэх)  
хөө (тогооны) – хөө (хөөх)  
тал (тал нутгийн) – тал (талы нь, хагасы нь)  
өглөө (үүрээр) – өглөө (өгөх)

Notice how some words are similar only in their pronunciation:

- буйр (нуур) – буурь (суурь)  
дайр (дайрах) – даарь (хөлс даарь)  
хуйл (хуйлж эвхэх) – хууль (дүрэм)  
хутга (хутга сэрээ) – хутга (хутгах)  
нялх – нялах  
ангийн (цонх) – ангийн (буу)  
Сангийн (Санги) – сангийн (яам)  
багаас (бага) – багаас (баг)  
аргаар (арга) – аргаар (аргал түүх)

□ Practice 22. Vocabulary: similar words.

Directions: Define the four different meanings of the word **шар**.

1. Шар талын дунд хэдэн цагаан гэр харагдах нь шар дээл дээр хадсан танан эрдэнийн товч адил. \_\_\_\_\_
2. Хасаг тэрэгний хяхнах тутам Лувсангийн сэтгэл уйтгарлаж, хүрэн шарын хашигнах бүр түүний уур хүрнэ. \_\_\_\_\_
3. Дээрээс нар шарж, дэргэдээс элс төөнөсөн Ингэн усны говьд жин үдийн халуун боллоо. Амьтан бүхэн сүүдэр хайж тарчилна. \_\_\_\_\_
4. Номхон борлог морь нь бөг бөг шогшиход богцонд хийсэн дархны хэдэн багаж нь шар шар дугарна. \_\_\_\_\_

## 12.6 Гадаад Үг Foreign Words

As international relations develop, new words enter the language if there's no exact word to match it

in that language. One language takes lexemes from another. In Mongolian language, Tibetan, Chinese, Russian and English words are accepted directly and Greek, Arabic, Persian, Sanscrit, Latin and German – indirectly. Some words are accepted such long time ago that they are hard to differ from native words.

ном	хүхэр	цай
дэвтэр	дарь	аршаан
бадаг	цув	тарни
боть	хүн	чихэр
шүлэг	архи	таяг
саван	суварга	болд

On the other hand, some words that are accepted recently still keep the form of writing and pronunciation of that language. These words are mostly of English, Russian, German or French origin.

диплом	форум	комисс
прокурор	менежер	стратег
бокс	семинар	глобал
вагон	компани	компьютер
шоу	техник	калькулятор

### Practice 23. VOCABULARY.

Directions: Find the foreign words in the text.

Нэг өдөр монтёр ирээд телефон тавьж өгөв. Ажлаа дуусахад нь Ленья цоо шинэ телефон руу харж байснаа:

- Ийм юмтай болох юмсан гэж хэлэв.
- Би хэнд тавьж өгсөн гэж бодож байна вэ? Энэ чинь танай л телефон шүү дээ.
- Үгүй, надад ийм биш, өөрийн телефон хэрэгтэй. Би завод дээрээсээ Иришкийн больниц руу ярьж байх гэсэн юм.
- Больниц, завод гэдэг чинь хаана байдаг юм бэ? гэж монтёр асуув.
- Диваныг больниц гэдэг юм. Завод бол манай өрөө гэж бяцхан Ленья тайлбарлав. Тийм юм бий гэж монтёр хэсэг бодсоноо:
  - Чүдэнз бий юу? гэж асуулаа.
  - Бий.
  - Тэгвэл утас?
  - Утас ч бий.
  - Аваад ир.

Ийнхүү монтёр Ленья охинд чүдэнзэн телефон хийж өгчээ.

## Монгол Хүний Нэр Personal Names 12.7

Mongolian personal names can consist of one name:

Солонго	Ариунаа
Тунгалаг	Алимаа

They can also consist of two names written together, in other words they can form a compound:

Эрдэнэбилэг	Батдорж
Энхсайхан	Ариунтуяа

When addressing people, Mongolians add AA<sup>4</sup> at the end of the word. It is written separately:

аав <u>аа</u>	ээж <u>ээ</u>	ах <u>аа</u>	эгч <u>ээ</u>
Дорж <u>оо</u>	Энх <u>ээ</u>	ахлагч <u>аа</u>	дарга <u>аа</u>

However, when vowels are doubled, they are not necessary:

өвөө	Ариунаа	Солонгоо	Энхээ
эмээ	Болормаа	Туяа	Заяа

When people use nicknames or shorten their names, vowels, however, may stay:

Батыг дуудаарай. – Батааг дуудаарай.  
Энхгэрэлтэй яваарай. – Гэрэлээтэй яваарай.

Some names do not use these endings when being addressed. Instead the last vowel is being stressed:

Онон (Оноон, not Онон оо) Нандин (Нандиан, not Нандин аа)

□Practice 24. Vocabulary: personal names.

Directions: Read the text. Find out about Mongolian PERSONAL names.

Монголчууд үр хүүхэддээ сайн сайхныг бэлгэдэж хүссэн нэр өгөх, элдэв хортон муу юмнаас зайлуулж хамгаалсан нэр өгөх, мөн хүүхэд төрөх үеэр тохиолдсон элдэв учрал, үйл явдал болон төрсөн гариг, цаг улирлын байдал зэргээс үндэслэн нэр хайрладаг билээ.

ХҮИ зууны үеэс эхлэн бурхан шашин Төвдөөр дамжин тархсаны нөлөөгөөр ХХ зуун болоход Монгол хүний ихэнх нь төвд, санскрит нэртэй болсон байна. Тэдгээр нэр нь голдуу бурхны шашны домог, үлгэр, түүх зохиолд гардаг их хүмүүсийн нэр, ном судрын нэр, их лам нар, од гаригийн нэрс ажээ.

Санскрит гаралтай нэр Адьяа (нар), Сумъяа (сар), Ангараг (гал гариг), Буд (усан гариг), Бархасвади (модон гариг), Сугар (төмөр гариг), Санчир (шороон гариг), Базар, Очир, Дармаа (ном), Удвал (лянхуа цэцэг), Дандар (үндэс).

Төвд гаралтай нэр Ням (нар), Даваа (сар), Мягмар (гал гариг), Пүрэв (модон гариг), Баасан (төмөр гариг), Бямба (шороон гариг), Лувсан (сайн оюут), Чойжил (номын хаан), Цэрэн (урт насан), Сүрэн (сахиус), Даш (өлзий), Шарав (билэг), Жамц (далай).

## 12.8 Өвөрмөц Хэллэг Idioms

The *idioms* are a group of words established by usage and having a meaning not deducible from those of individual words:

шар нь гозойх	– атаархах
магнай нь тэнийх	– баярлах
ганзага нийлэх	– мөр нийлэх
гэдэс гарах	– сайн цадах
гол нь харлах	– аягүй, таагүй болох
гууль нь цухуйх	– муу муухай нь илрэх
алтан хошуу өргөх	– ховлох
амаа таглуулах	– хариу тавин дуугүй болгох
бүсээ чанга бүслэх	– гамнах, хямгадах
амаа мэдэхгүй даага шиг	– зөрүүд гөжүүд

□Practice 25. Vocabulary: idioms.

Directions: Write the meaning of the following idioms.

1. модоо барих \_\_\_\_\_
2. хөмсөг зангидах \_\_\_\_\_
3. нүд үзүүрлэх \_\_\_\_\_
4. зүрх алдах \_\_\_\_\_
5. элэг хөших \_\_\_\_\_
6. чих дэлсэх \_\_\_\_\_
7. нүүр улайх \_\_\_\_\_
8. гар цайлгах \_\_\_\_\_
9. гар татах \_\_\_\_\_
10. гар сунгах \_\_\_\_\_
11. ам муруйх \_\_\_\_\_
12. ам ангайх \_\_\_\_\_
13. давсанд явах \_\_\_\_\_

□Practice 26. Vocabulary: idioms.

Directions: Write your own sentences with the given idioms.

1. ам хуурай суухгүй

---

2. аман дээрээ сүрхий, ачир дээр базаахгүй

---

3. амны зууш болох

---

4. ам гарздах

---

□Practice 27. Vocabulary: idioms.

Directions: Write the meaning of the following idioms.

адууныхаа хэрээр исгэрэх \_\_\_\_\_

бодоод бодоод бодын шийр дөрөв \_\_\_\_\_

гуяа ганзагалж ирэх \_\_\_\_\_

мартсанаас мал мэнд үү гэгчээр \_\_\_\_\_

айсан хүн адуу үргээх гэгчээр \_\_\_\_\_

мордохын хазгай болох \_\_\_\_\_

нүд үзүүлэх \_\_\_\_\_

нохойн дуу ойртох \_\_\_\_\_

өөртөө булуу хураах \_\_\_\_\_

сүүл мушгих \_\_\_\_\_

сүүлчийн тэмээний ачаа хүнд \_\_\_\_\_

өөх идэж, тос уух \_\_\_\_\_

хорыг нь малтах \_\_\_\_\_

□Practice 28. Vocabulary: idioms.

Directions: Read the sentences. What is the meaning of the idioms ?

1. Анчин ирэхээс өмнө бид *ам тостож, гэдэс гарлаа*.

---

2. Долингорыг барьж ирэхээр гарсан Бороохой өвгөн Долингорт эмээл хүргэж өгөөд ирсэн нь инээвэл зохих хэрэг. Нэгэнт Долингорыг барьсан гэх нь худал тул *амаа барьж* гэмшив.

---

3. Охин минь биднээс өөр хүн болж *толгойгоо мэдэж, биеэ даасан* хүн боллоо.

---

4. Бид өнөө шөнө хамба багшийн зарлигаар улааныхны сумын дарга Дорж, хамтралын нягтлан бодогч Эрдэнэ бас бүс хэдэн хүний *бодийг нь хөтөлнө*.

---

5. Би үхрээ оллоо, бас алтан дэлхий буянаа хайрлаж, *ганзагаа мялааллаа*.

---

6. Тэгээд өвгөн бид хоёр *голомт залгах* хүүтэй болов.

---

7. Хуйхар харгисууд бие биеийн *гэдсэнд хөлөө хийлцэх* болов.

---

8. Нэг мэдсэн чинь дэнгийн тос дуусч, харанхуй болмогц цэргүүд *давсанд явцгаав*.

---

□Practice 29. Vocabulary: idioms.

Directions: Find the idioms in the sentences. Write them down on the lines given below.

1. Яндаг өвгөнийг сая л нэг ам халж байхад хоёр нөхөр нь улаан зээрд болчихоод байв.

---

2. Энэ хямсгар, цэмцгэр хүүхэн чинь ам хэл нь гүйцэгдэхгүй, заавал өөрийгөө зөвтгөж байж сэтгэл нь амардаг хүүхэн байна.

---

3. Чингис хаан сэрээд, зургаан сайддаа ирж, зарлиг болруун: Би нэг зүүд зүүдлэв. Бор зүрх минь бол бол хийв. Богино хавирга минь шир шир хийв. Болзошгүй дайсан ирэх нь бололтой.

---

4. Гарьд аян замынхаа учралыг сайн нөхөртөө ярьж, булуу нь халаад замын уртыг мэдсэнгүй.

---

5. Гар нь ганзаганд хүрвэл гадаад далайг туулах байх, хөл нь дөрөөнд хүрвэл хөрст дэлхийг туулах байх.

---

6. Тэр хоёр эхний өдөр жаахан будилсан ч дараах өдөр нь хэн хэнээ сайн ойлгож, гар нийлэх болжээ.

---

7. Дагва, Жамсран хоёр зүүний үзүүр оромгүй найзалдаг.

---

8. Би хонинд сууяа гэж Галданг хэлэхэд Сүсэгжавын нүд нь орой дээрээ гарчих шахав.

---

9. Болд хүн болсоор ийм юм үзсэнгүй тул нүд халтирч, сэтгэл сэрчигнэв.

---

10. Тэр ч ёстой од нь гялалзаж яваа залуу.

---

11. Үүр цайж, удалгүй нар мандан, хамаг юм алган дээр байгаа юм шиг харагдав.

---

12. Бас Сорхон шар өгүүлрүүн Ах дүү тайчууд нар ам шүдээ билүүдэн айсуй явна.

---

13. Одоо бол амаа үдүүлсэн юм шиг дуугүй суух цаг биш гэдгийг Базар ойлгож байв.

---

14. Өглөөгүүр тэнгэр арчсан толь шиг мэлтийгээд, нар мандав.

---

□ Practice 30. Vocabulary: idioms.

Directions: Find the idioms in the sentences.

Write them down on the lines given below.

1. Дээр нартай байхад Ховд хотоос яаравчлан гарсан арваад морьтон Да хүрээ орох замаар жолоо хумхилгүй давхисаар нар шингэхэд их замаас салан модон дундуур цувалдан давхилдав.

---

2. Үдэш нь Ямпил бид хоёр түлээн дээр сууж, амаа цууртал хөөрөлдөв.

---

3. За, юу ч бол чи зүгээр эрүүгээ хамхиад л сууж бай.

---

4. Өнөөдөр ирэх юм байгаа биз гэсэн үг Тогоогийн аман дээр гарч ирсэн боловч хэлж зүрхэлсэнгүй.

---

5. Жигжид хар цагаан дуугүй, хувцас хунараа хам хум өмсөөд ум хумгүй гарч одов.

---

6. Энэ нарт хорвоод эцэг эхээс хоёулхнаа үлдсэн алаг бөөрний холбоотой хүмүүс өнө удаан хагацсаны дараа гэнэт уулзан золгов.

---

7. Яндаг өвгөн сая л нэг ам халж байхад хоёр нөхөр нь улаан зээрд болчихоод байв.

---

8. Одоо бол амаа үдүүлсэн юм шиг дуугүй суух цаг биш гэдгийг Базар ойлгох тутмаа айн ичих нь улам их болсоор байв.

---

9. Энэ хооронд Намуу бие шалтгаантай ч гэсэн хонио хариулаад, гэрийнхээ хамаг ажлыг хийнэ.

---

10. Би эмэг эхийн гар дээр борви тэнийсэн бөгөөд сургуулийн босго алхан алхтлаа өврөөс нь гараагүй юм.

---

11. Ядарч яваа цагт нь гараа сунгасан Итгэлтийг уурлуулах хүсэл Долгорт байсангүй.

---

# 13 Өгүүлбэр Зүй Syntax

## 13.1 Өгүүлбэрийн Гишүүд Clause Elements

The *clause elements* are the words that are independent in their form, capable of answering a certain question, connect in terms of syntax, and have an informational function in terms of grammar. Each element expresses a particular kind of meaning.

The two *main elements* **гол гишүүд** of a clause are the *subject* (S) **өгүүлэгдэхүүн** and the *predicate* (P) **өгүүлэхүүн**. These make a starting point for sentence analysis.

The subject (S) identifies the theme or topic of the clause, for example:

Тэр нь амттай байсан.

АХ ирлээ.

When adjectives, numerals, and the verbs with definitive connective endings (-сан<sup>4</sup>, -аа<sup>4</sup>, -даг<sup>4</sup>, -х, -маар<sup>4</sup>) play the role of a noun and are used in the nominative case, they become a subject.

Том нь минийх.

ОЧИХ нь зүйтэй.

The predicate (P) expresses a wide range of meanings, such as actions, sensations, or states of being, for example:

Өнөөдөр хүйтэн байна.

Бид маргааш нүүнэ.

The *auxiliary elements* **туслах гишүүд** of a clause are the *complement* (C) **тодотгол**, the *object* (O) **тусагдахуун**, and the *adverbial* (A) **байц**.

The complement (C) describes and gives further information about the subject, for example:

Суусан цэцнээс явсан тэнэг дээр.

Хүйтэн ус руу бүү ороорой.

The object (O) identifies who or what has been directly affected by the action of the predicate. It is revealed by the accusative case or the transitive verb, for example:

Би ЖИМС түүсэн.

Хүүхдүүд номоо уншаад, гадаа гарч тоглосон.

The adverbial (A) describes the predicate and adds extra information about the situation, such as the time of an action, its location, or its manner of being performed, for example:

Би алхаж ирсэн.

Кино 4 цагаас эхэлнэ.

## Зэрэгцүүлэх Холбоо Coordinating Elements 13.1.1

The *coordinating elements* are the words or clauses that are independent. They are:

1. Coordinating conjunctions, parallel connective endings (See Table 15, p. 79), abbreviations and groups:

баян ба хоосон

яваад очлоо

МУ (Монгол Улс)

арьс өнгөний үзэл

2. Parallel phrasal words:

зах зээл цэцэг хуар

бэлэн зэлэн өвс ургамал

бэл хөрөнгө хүн зон

гүйх харайх тэнтэр тунтар

3. *Series* зэрэгцсэн гишүүд:

### 3.1. A main word with several subordinates:

унших, бичих, бодох тутам ойлгох

### 3.2. Several main words with one subordinate:

миний ном, дэвтэр, үзэг

### 4. Coordinating elements of a sentence:

#### 4.1. Coordinating subjects:

Их найргийн өргөөнд юм бүхэн бий: алтан хоймор, шүтээн, сүү дүүрэн тогоо, гал бадмалсан тулга, хүүхдийн өөжин, шоголтой ном, түүх шаштир, ирээдүй, өнөө, маргааш цөм бий.

#### 4.2. Coordinating predicates:

Мань хүн бүсээ суллаж, энгэрийнхээ товчийг тайлаад, анх удаа дээлээ сугалдаргалав.

#### 4.3. Coordinating objects:

Эрээн ганган цэцэгс нь салхины шившээн, борооны дусал, аянгын дуу, гол горхины хоржигноон, зөгий хэдгэнийн дүнгэнээн зэрэгт дуртай гэнэ.

#### 4.4. Coordinating complements:

Галын захад том духтай, сайхан алаг нүдтэй эмээ сууна.

#### 4.5. Coordinating adverbials:

Хуурай өвсөн дээр, шигүү модтой шилмүүст ойд, борог өвстэй газар ерөөсөө гал түлж болохгүй.

### GRAMMAR RULE:

The particles in the Verb/Noun + Particles structure do also become part of the predicate. These particles are:

даа	биш шүү дээ	шиг юм
сан	шүү дээ хө	биз дээ
вэ дээ	юу даа	аа даа
юм шив	юм л даа	ч дээ
мөн дөг	юм бий	л дээ

□Practice 1. syntax: Coordinating elements.

Directions: Identify and underline the elements in the sentences. Label them

**S** (subject), **P** (predicate), **O** (object), **C** (complement), **A** (adverbial).

1. Энэ нутагт долоон хар ямаатай, бор эсгий гэртэй, ганц бие эмгэн амьдран суудаг байжээ.
2. Тэнгэрт одод, талд адуу, эдний дор бодол бэлчинэ.
3. Цэцгийг шинжиж, түүж, хатааж шахаад, сая хүж хийнэ.

□Practice 2. syntax: Coordinating elements.

Directions: Find and underline the Coordinating elements in the sentences.

1. Тэнгэр муудахын өмнө гол төлөв зүүн өмнөөс эсвэл зүүнээс салхилна.
2. Мөн тэрчлэн үүр цайх үеэр одод анивалзах нь ихэсдэг бөгөөд алсын сулхан чимээ сонстох нь тод болно.
3. Утаа дээшээ хаягдаж, өдрийн цагаар радио хүлээн авагчийн шажигнах нь багасна.

□Practice 3. syntax: Coordinating elements.

Directions: Combine two sentences into one sentence. Use -ж/-ч.

Model: 7 цаг болов. Жүжиг эхлэв .

7 цаг болж, жүжиг эхлэв.

1. Сургуулиа төгсөв. Ажилд оров.

---

2. Шувууд жиргэв. Үүр цайв.

---

3. Бид уулын оройд хүрлээ. Сууж амарлаа.

---

4. Ном уншив. Цаг өнгөрөөв.

---

5. Харанхуй болов. Хотын гэрэл солонгорно.

---

□Practice 4. syntax: Coordinating elements.

Directions: Combine two sentences into one sentence.

Use **-гүйсэн бол ... -х + гүй байх байсан**.

Model: *Өчигдөр бороо орсон. Би гэртээ суусан.*

*Өчигдөр бороо ороогүйсэн бол би гэртээ суухгүй байх байсан.*

1. Энэ хавар бороо элбэг орсон. Цэцэг сайн ургасан.

---

2. Таны ойлгож байна. Би тусалж чадна.

---

3. Тэнгэр цэлмэг байсан. Бид зугаалганд явсан.

---

4. Чи утсаар ярьсан. Би баяртай байсан.

---

5. Манайд зочид ирсэн. Би хоол бэлтгэсэн.

---

6. Энэ дууг мэднэ. Би дуулсан.

---

□Practice 5. syntax: Coordinating elements.

Directions: Combine two sentences into one sentence. Use **чинь, минь**.

Model: *Би түүнд тусалъя гэж хэлэв. Тэр дургүйцэв.*

*Би түүнд тусалъя гэж хэлсэн чинь тэр дургүйцэв.*

1. Өдөр бүр дасгал хийв. Бие минь сайжирлаа.

---

2. Үсээ будав. Түүнд таалагдав.

---

3. Сүхбаатарын талбай дээр очив. Хүн ихтэй байсан.

---

4. Зураг зурав. Түүний анхаарлыг татав.

---

5. Би тийшээ явсан. Тэр нь зөв байж.

---

6. Цас оров. Машинууд осолдлоо.

---

□Practice 6. syntax: Coordinating elements.

Directions: Combine two sentences into one sentence. Use **-вч**.

Model: *Өдөржин оролдож суув. Учрыг нь олсонгүй.*

*Өдөржин оролдож суувч учрыг нь олсонгүй.*

1. Нар гарав. Дулаарсангүй.

---

2. Насанд хүрэв. Густаа гараагүй.

---

3. Сургуулиа төгсөв. Ажил олоогүй байгаа.

---

4. Уул руу мацаж ядрав. Орой дээр нь гарсан хойноо дотор тэнийнэ.

---

5. Нэг хаалга хаагдана. Нөгөө хаалга нээгдэнэ.

---

□Practice 7. syntax: Coordinating elements.

Directions: Combine two sentences into one sentence. Use **боловч**.

Model: Би түүнд хэлэв. Гэвч тэр сонсоогүй.

Би түүнд хэлсэн боловч тэр сонсоогүй.

1. Түүнд бэлэг өгөв. Гэвч тэр задалж үзсэнгүй.

---

2. Баатар гуай хөдөө төрж өссөн. Гэвч хотод амьдардаг.

---

3. Зочид ирэв. Гэвч тэд удалгүй буцсан.

---

4. Би Лас Вегаст очив. Гэвч мөрийтэй тоглоом тоглоогүй.

---

5. Улаанбаатарт хэд хонов. Гэвч хуучин найзтайгаа уулзаж амжаагүй.

---

□Practice 8. syntax: Coordinating elements.

Directions: Identify and underline the elements in the following sentences.

Label the **S** (subject), **P** (predicate), **O** (object), **C** (complement), and **A** (adverbial).

1. Төмөр өглөө эрт босч, Дулмаагийн унадаг жороо зээрд морины дэлийг засч, чихний нь үсийг тэгшлэн, эрүүний сахлыг хайчлаад, мөнгөн тоног, ясан хяртай, боржгон хийцтэй эмээл тохоод уяанаас уяв.
2. Тэр хүн хэсэг яваад зогсож, зүг бүр чих тавин чагнаж байснаа харанхуйн дунд шуугин урсаж байгаа голын эрэг дээр очин, түрүү урагшаа харан хэвтээд, хүд хүд хийтэл баахан ус залгилав.

□Practice 9. syntax: Coordinating elements.

Directions: Find the idioms. What element of a sentence are they?

1. Эд ч ёстой богино жолоотой улс юм аа.  

---
2. Би нэг муу өчүүхэн зарлага, ердөө л будааны хүүхэд.  

---
3. Донхор гаансаа гаргаж, галзуу улаанаа нэрмээр санагдсан боловч багшийнхаа өрөөнд баагиулахаас айжээ.  

---
4. Хүн гэдэг чинь долоон голтой амьтан, тэсэж л үзье.  

---
5. Манай дарга гэж ёстой дүлий толгойтой амьтан.  

---
6. Нэг муу ядарсан дээлийн гол л явсан юм.  

---
7. Амьдрал минь ямар дээсэн дөрөөн дээр яваа биш.  

---
8. Их хүрээний гэж хуалж, дуулж суугаа нь, бодвол, бас нэг их гарын панз ирсэн боллолтой.  

---

### 13.1.2 Угсруулах Холбоо Subordinating Elements

In a connection with *subordinate elements* one element governs the other. They include idioms and

successive compound words:

номын сан	нохой зан
шар айраг	мөнгөн онгоц
амны хишиг	галт тэрэг
хоёр зээрд	хорт хавдар

They can take noun and verb endings:

НОМЫН баяр	УНШИХТАЙ зэрэг ойлгох
ЭХИЙН тухай дуу	СУРАХАД чармайх
УУЛЗМАГЦ баярлах	СУРАХЫН тулд чармайх
УУЛЗАХТАЙ зэрэг санах	УНШСАН ном
ХҮҮХДИЙН баяр	УНШИХ хэрэгтэй ном
УНШМАГЦ ойлгох	МАРТЫН 8

They are connected with subordinating conjunctions, such as:

тул	хэрэгтэй	дэх
төлөө	ёстой	чинээ
тутам	талаарх	шиг
зэрэг	наадах	мэт
бүр	доорх	адил
тухай	дээрх	учир
дээр	дахь	хэр

□Practice 10. syntax: subordinating elements.

Directions: Find the elements with subordinating conjunctions. Write them down on the lines given below.

1. Болд хүн болсоор ийм юм үзсэнгүй тул үнэхээр нүд хальтирч, сэтгэл сэржигнэн, зүүд зэрэглээ, үлгэр домог мэт болж гайхна.  
\_\_\_\_\_
2. Өнөөх гурван хүн хамгийн баруун талын гэрийн дэргэд хүрч очсонд өмнөөс нь хоёр гурван хүн угтан морьдыг авав.  
\_\_\_\_\_
3. Харах нүдний хар цагаан нь хослоод, хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутам миний нүд эрхгүй дагалдан давхина.  
\_\_\_\_\_

## Энгийн Өгүүлбэр Simple Sentences 13.2

A simple sentence can be short **хураангуй өгүүлбэр** or extended **дэлгэрэнгүй өгүүлбэр**.

A short sentence consists of a subject and a predicate:

Зун (S) болов (P).

An extended sentence adds other members of a sentence to a short sentence:

Энэ жил (A) сайхан (C) зун (S) болж өнгөрлөө (P).

Манай аавын (C) морь (S) хурдан (A) давхидаг (P).

A simple sentence can consist of one member of a sentence.

If it consists of a subject, it's called *subject sentence* **нэрлэсэн өгүүлбэр**: Хавар (S).

If it consists of a predicate, it's called *predicate sentence* **эзэн биегүй өгүүлбэр**: Зуншив (P).

□Practice 11. Syntax: simple sentences.

Directions: Identify and underline the **subject (S)** and the **predicate (P)** in each sentence.

1. Хуучин хүү шинэ хүү болов.
2. Үүгээр түүгээр хэдэн тугал оодогнон давхина.
3. Юутай завшаан, юутай баяр!

4. Одоо би хаашаа очих вэ?
5. Сүрхий юм аа.
6. Та нар юун хүн бэ?
7. Ойр хавь дэлгүүр байна уу?
8. Чиний нэр хэн бэ?
9. Тэр чинь хаана байна?
10. Аль вэ, наадах малгайгаа ав.
11. Би мэдэхгүй, мэдэхгүй.
12. Танай айлын Гонгор яасан бэ?
13. Юу болохыг хэн мэднэ.
14. Та сайн байна уу?
15. Нохой хорь!
16. Агаарын онгоц нисч ирэв.
17. Энэ үе Идэрийн гол мөн хэвээр урссаар.
17. Бүрээ, бишгүүрийн дуу үргэлжлэн дүнгэнэнэ.
19. Монгол газар минь уужим юм аа.
20. Ирээдүйн хэргийг яахан болзоно.

### 13.3 Нийлмэл Өгүүлбэр Multiple Sentences

*Multiple sentences* can be analyzed into more than one clause. These constructions are classified into two types: *compound sentences* **энгийн нийлмэл өгүүлбэр** and *complex sentences* **хавсарсан нийлмэл өгүүлбэр**.

In compound sentences, the clauses are linked by coordination. Each clause can in principle stand as a sentence on its own. For example:

Би дэлгүүр **яваад** (main clause), талх авлаа (main clause).

Хавар болж (main clause), цэцэг навч дэлбээллээ (main clause).

In complex sentences, the clauses are linked by subordination. One clause is made dependent upon another. The subordinate clause cannot stand as a sentence on its own. For example:

Өглөөний нар гарч ирэхэд (subordinate clause) миний сэтгэл тэнийнэ (main clause).

A *compound-complex sentence* **холимог нийлмэл өгүүлбэр** consists of both coordination and subordination. Several instances of coordination or subordination may occur at the same level. For example:

Өглөөний нар гарч ирэхэд (subordinate clause) эргэн тойрон гэрэлтэж (main clause), миний сэтгэл баясна (main clause).

Бороо ормогц (subordinate clause) газрын өнгө засарч (main clause), *хүн малын зоо тэнийлээ* (main clause).

Энэ уул давааны энгэрт намрын шар нар жигдлэн тусаад (subordinate clause), мөн ард нимгэн цагаан цас алагласан болоход (subordinate clause) эргэх цагийн улирлыг гайхан явав (main clause).

#### 13.3.1 Өгүүлэгдэхүүн Гишүүн Өгүүлбэр Subject Clauses

*Subject clauses* are formed when a verb attaches the нь:

Хөндий талын зэрэглээ мяралзан жирвэгнэх нь холоос үзэхэд сонин.

Тогтож ядах нь (subject clause) сойлго таарсных.

Энэ жил тэднийх төлөө бүрэн авдаг нь баатар Нанзадын ажил сайтайнх.

□Practice 12. Syntax: subject clauses.

Directions: Combine two sentences. Use **нь**.

*Model:* Би даргадаа хэлсэн. Тэр нь зөв болсон. Би даргадаа хэлсэн нь зөв болсон.

1. Ээж над руу нүүж ирнэ. Тэр нь тодорхой болсон.

2. Аав шинэ ажилд орно. Тэр нь баталгаатай.

---

3. Хол газар явна. Энэ нь хэцүү ч, амар ч байж магадгүй.

---

4. Болжмор шувууд жиргэж байна. Энэ нь сайхан хавар болж байгаа шинж.

---

5. Өмд маань томдож байна. Энэ нь миний турсных байх.

---

□Practice 13. Syntax: subject clauses.

Directions: Identify and underline the Subject clauses in the sentences.

1. Тэр шөнө Эрдэнийн гадаа морьтой хүн ирээд орсон нь Төмөр байв.
2. Цармыг тойрсон бүдүүн баглагар модыг цас хучсан нь элдэв амьтны хөрөг мэт их л сүртэй үзэгдэв.
3. Бусдын муу муухайг зөвшөөрөн хүлээнэ гэдэг бол өөрөө тэр муу муухайг үйлдэж байгаатай адил.
4. Хайдаг ингэний буйлах нь хүртэл гачлантай санагдана.
5. Хаш чулуу ноёны бадар дээр нэгэн бяцхан шувуу нисэн ирж суусан нь галт хараацай ажээ.
6. Эзэд нь наадамд явсан хотын айлыг эмгэн, өвгөн хоёр сахиж байсан нь Цэвэлмаа, Буд хоёр байв.
7. Эхнэрийн нь гал тогоондоо сав суулга торчигнуулах нь дуулдана.
8. Зөөлөн намуун дуугаар сэтгэл догдлонгүй ийн хэлэхдээ шивээлэн дүүргэсэн арагтай аргалаа ахиулан үүрсэн нь уярал бодлынхоо ачааг тэнцүүлэн үүрснийх биз.
9. Нэг залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэх нь зэрлэг бугын адил өнгөтэй.
10. Өрөөсөн нүдний дээд тал дээр хэлтгий зангилан үзүүрийг унжуулсан нь залуу бүсгүйн дэгжин байдлыг үзүүлжээ.
11. Галав юүлнэ гэгч нь арай болоогүй юмсан.
12. Тэрэгч Лувсангийн зуны халуунд хөлсөө урсгаж, өвлийн хүйтэнд хуруугаа хөлдөөж олсон муу гутлыг шавхайдан дүүргэх нь хайрлалтай.

### 13.3.2 Нэрийн Тодотгол Гишүүн Өгүүлбэр Adjective Clauses

The *adjective clauses* describe the subject. They answer the question *ямар?*

Миний хийсэн хоол чамд таалагдав уу?

Чиний уншиж байгаа ном надад бий.

□Practice 14. Syntax: adjective clauses.

Directions: Circle the appropriate verb in parentheses.

1. Би найзынхаа (*бичсэн, бичих*) өгүүллийг уншиж байна.
2. Түүний (*зохиох, зохиосон*) дуу чамд таалагдав уу?
3. Ус бариад ирж (*явсан, яваа*) хөх тэрлэгтэй хүн чинь хэн бэ?
4. Манай хотод ирж (*тоглодог, тоглох*) концертын тухай радиогоор сонслоо.
5. Хүүгийн маань (*зурж байгаа, зурсан*) хөөрхөн зураг хананд өлгөөстэй байгаа.
6. Таны (*уншдаг, уншиж байгаа*) ном юуны тухай вэ?
7. Тэнд (*цуглардаг, цугларсан*) хүмүүс юун тухай ярьж байна вэ?
8. Өвөөгийн (*магтсан, магтаад байсан*) морь энэ мөн үү?

□Practice 15. Syntax: adjective clauses.

Directions: Combine the sentences with the adjective clause.

Model: *Ширээн дээр нэг ном бий. Тэр миний найзынх.*

*Ширээн дээр байгаа нэг ном миний найзынх.*

1. Манай гэрийн гадаа урд нэг машин бий. Тэр миний машин.
-

2. Би хоол хийсэн. Хөргөгчинд байгаа.

---

3. Бат нэг хүнтэй танилцсан. Тэр хүн нь Германаас ирсэн.

---

4. Туяа шүлэг уншсан. Тэр нь өөрийх нь зохиосон шүлэг.

---

5. Бид дарс уусан. Тэр дарс амттай байсан.

---

6. Шууданч захиа авчирсан. Тэр захиаг ширээн дээр тавьсан шүү.

---

□Practice 16. Syntax: adjective clauses.

Directions: Find and underline the ADJECTIVE clauses in the following sentences.

1. Маргаашнаас эхлээд хоёулаа ээжийн бэлэглэсэн тэрлэгийг өмсөж, ижил зүсмийн морь унаж, Балжидынхаа ах дүүсээр хэсэж гарлаа.
2. Бидний жуулчилж яваа автобусны тайлбарлагч эмэгтэй бол уран сайхнаар ярьдаг, хотын бүх байдлыг гүнзгий мэддэг боловсролтой хүн байлаа.
3. Модот их уулын хөндийгөөр шуугин урсах Хараа голын нэгэн давчуухан дэнжид төмөр замын эртний нэгэн өртөө байдаг.
4. Хар ус нуурын мандалд лянхуа цэцэг дэлгэрсэн тэр цагаар би Явуугийн нутагт очсонсон.
5. Атан тэмээ хонгортон байдаг алагхан говьдоо би хайртай.
6. Өмнө хөндийгөөр угалзалсан эрээн майхан бүрэг бараг үзэгдэнэ.
7. Тэрхүү хийдийн суврагын тэнд гайхамшигтай манжлага цамхагт өлгөсөн хонхны дуу хангинан жингэнэнэ.
8. Хаврын хурц наранд өвлийн хунгарласан цас хайлж, газрын хөрсийг чийгтүүлнэ.
9. Энгэр нударгыг хар торгоор эмжиж, нарийхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмссөн.
10. Бас хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйна.
11. Ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зурайсан ялгуун саарал морь нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилна.
12. Хээр талын дунд хөндлөн гулд давхиж, хөдөөгийн саруулд биеэ гайхуулсан ийм нэг үзэсгэлэнт охинтой учрав.

### 13.3.3 Оронт Гишүүн Өгүүлбэр Adverbial Clauses

The *adverbial clauses* relate to the predicate group. They answer the questions *яаж? хэрхэн? ямар байдалтай? ямархуу байдалтай? юунд?*

When an event happens following the previous event at the same location, the words of location, such as газар, орон, зам, буурь, бэлчээр, булан, тохой, нуга, тал can be omitted.

The adverbial clause can be revealed by the dative, ablative, instrumental and comitative case endings:

Би бороо орсонд баярлав.

Би чиний хөрөөдсөнөөр хөрөөдөв.

Чиний авснаас авав.

Чиний явахтай явсан.

□Practice 17. Syntax: adverbial clauses.

Directions: Complete the sentences with the words in parentheses.

Model: Би чиний (ирсэн) ирснээр ирлээ.

1. Энэ хоолыг тэд нарын (авч явах) \_\_\_\_\_ бэлтгэв.

2. Энэ утсыг чиний (авсан) \_\_\_\_\_ авлаа.
3. Чиний (арилгасан) \_\_\_\_\_ арилгалаа.
4. Би өчигдрийн та нарын (түүсэн) \_\_\_\_\_ жимс түүлээ.
5. Түүний онц (аваагүй) \_\_\_\_\_ ээж нь гутрав.
6. Би үсээ чиний (зассан) \_\_\_\_\_ засмаар байна.
7. Тэд миний (ирэх) \_\_\_\_\_ ирсэн.
8. Би зургаа ахын зур (гэсэн) \_\_\_\_\_ зурсан
9. Та хэд миний (явсан) \_\_\_\_\_ явбал төөрөхгүй.
10. Миний найз кино (эхлэх) \_\_\_\_\_ ирсэн.
11. Миний (ярьсан) \_\_\_\_\_ яриарай.
12. Түүний (ниссэн) \_\_\_\_\_ битгий нисээрэй.
13. Бүгдээрээ тэд нарын (олсон) \_\_\_\_\_ хайя.
14. Танайхан хүүхэдтэй (болсон) \_\_\_\_\_ бид баяртай байгаа.

## Шууд Тусагдахуун Гишүүн Өгүүлбэр Noun Clauses 13.3.4

When the predicate is in the accusative case or when the verb is transitive, it becomes a noun clause.

*Noun clauses answer questions юу? яасныг? юун тухай? яасан тухай?:*

Тэр хоёрын юу авсныг хэн ч мэдсэнгүй.

Та хоёр маргааш миний гэрт гийгүүлэн очихыг урьж байна.

Монгол хүн мориндоо хайртайг өгүүлж юун барах вэ!

Би чамайг онцсайн суралцсаны тухай ханын сонинд бичсэн.

□ Practice 18. Syntax: noun clauses.

Directions: Combine two sentences into one sentence with a noun clause.

Model: *Би морь худалдаж авсан. Чи мэдсэн үү?*

*Намайг морь худалдаж авсныг чи мэдсэн үү?*

1. Хэн ерөнхийлөгчийн сонгуульд ялсан бэ? Би сая л мэдлээ.

---

2. Тамир хүүтэй болсон. Би дүүгээс нь сонслоо.

---

3. Ямар кино гарч байгаа вэ? Зарлалаас мэдлээ.

---

4. Монголын мисс хэн болсон бэ? Чи мэдэх үү?

---

5. Би юу авсан бэ? Чи харах уу?

---

6. Чи хэдэн размерын гутал өмсдөг вэ? Би мэдэхгүй.

---

7. Тэр уйлсан байсан. Чи харсан уу?

---

8. Энэ програм яаж ажилладаг вэ? Та түүнд сайн зааж өгөөрэй.

---

9. Улаан лооль яаж тарьдаг вэ? Надад зааж өгнө үү.

---

10. Чанар нь муу байна. Чи харж байна уу?

---

11. Бууз яаж хийдэг вэ? Би зааж өгье.

---

12. Онгоц хэдэн цагт нисэх вэ? Би мэдмээр байна.

---

□Practice 19. Syntax: noun clauses.

Directions: Complete the sentences with the words in parentheses.

Use a **VERB TENSE ENDING + ТУХАЙ**.

Model: Тэднийхэн ам бүл (нэм) нэмсэн тухай ээж надад хэлсэн.

1. Чамайг (яв) \_\_\_\_\_ би хэнд ч хэлээгүй байгаа.
2. Очир аквариумтай (бол) \_\_\_\_\_ надад хэлсэн.
3. Тэр дэлгүүр байнга хямдрал (үзүүл) \_\_\_\_\_ миний хөрш хэлсэн.
4. Би ямар ажил (хий) \_\_\_\_\_ эгчдээ бичсэн.
5. Тэр ресторанд амьд хөгжим (тогло) \_\_\_\_\_ сониноос уншлаа.
6. Тэр Япон (яв) \_\_\_\_\_ ярьж өгөв.

□Practice 20. Syntax: noun clauses.

Directions: Change two sentences into one. Use the form **-х . . . -х + гүй + г**.

Model: Би ирэх жил нүүнэ. Би ирэх жил нүүхгүй.

Би ирэх жил нүүх нүүхгүйгээ мэдэхгүй байна.

1. Түүний охин дуулдаг. Түүний охин дуулдаггүй.  
\_\_\_\_\_
2. Тэр Монгол руугаа буцсан. Тэр Монгол руугаа буцаагүй.  
\_\_\_\_\_
3. Аав зайрмаг авчирна. Аав зайрмаг авчрахгүй.  
\_\_\_\_\_
4. Тэднийхэн энэ жил зуслан гарна. Тэднийхэн энэ жил зуслан гарахгүй.  
\_\_\_\_\_
5. Туулд энэ толь бичиг хэрэгтэй. Туулд энэ толь бичиг хэрэггүй.  
\_\_\_\_\_
6. Карина цай ууж чадна. Карина цай ууж чадахгүй.  
\_\_\_\_\_
7. Бид нар энд зогсож болно. Бид нар энд зогсож болохгүй.  
\_\_\_\_\_
8. Эхнэр нь энэ долоо хоногт төрнө. Эхнэр нь энэ долоо хоногт төрөхгүй.  
\_\_\_\_\_

## Шалтгаант Гишүүн Өгүүлбэр Reason Clauses 13.3.5

In *reason clauses*, the first event becomes the cause for the next one. They answer the questions *ямар учраас? юуны учир? яаж? яахлаар? яавал? яасанд? яагаад? яаснаас? юу гэж? яана гэж? юуны тул?*

Reason Clause Conjunctions

-х + аар <sup>4</sup>	-х + ын <sup>2</sup> тоолонгоор	-х нь битгий хэл	учир
-х тутам	-х + ын <sup>2</sup> тоолонд	-х болгонд	учраас
-х тусам	-сан <sup>4</sup> +аар <sup>4</sup> барахгүй	-сан <sup>4</sup> төдийгүй	тийм учраас
-х бүр(дээ)	-х байтугай	-х төдийгүй	яагаад гэвэл

For example:

Ишиг эврээ ургахаар ээжийгээ мөргөнө, ус эргээ нурахаар гадагш халина.

Нимгэн цагаан цаасны дэлгэх бүр өтгөн хар бэх энд тэнд будна.

□Practice 21. Syntax: reason clauses.

Directions: Combine the sentences. Use **-х байтугай, -сан + аар барахгүй**.

1. Би мотоцикл унадаггүй. Би бас дугуй унадаггүй.  
\_\_\_\_\_
2. Төгс эхнэр авсан. Тэр бас хоёр ихэр хүүтэй болсон.

---

3. Тэр хөл бөмбөгөөр хичээллэсэн. Тэр бас улсын тэмцээнд оролцсон.

---

4. Машинтай явж болохгүй. Бас морьтой явж болохгүй.

---

5. Лхагвасүрэн шүлэг бичсэн. Тэр бас кино зохиол бичсэн.

---

6. Би дэлхийгээр аялж үзээгүй. Би хаяагаа бас сайн мэдэхгүй хүн.

---

Practice 22. Syntax: reason clauses.

Directions: Complete the sentences with the words in parentheses. Use **-сан<sup>4</sup>учраас**.

1. Санаа их (зов) \_\_\_\_\_ шөнө унтсангүй.
2. Хөл маань (ядар) \_\_\_\_\_ хурдан алхаж чадахгүй нь.
3. Бороо орно (гэ) \_\_\_\_\_ шүхрээ авлаа.
4. Бямба гаригт (хүйтэр) \_\_\_\_\_ гол руу яваагүй.
5. Болдбаатар гүйлтийн уралдаанд (түрүүл) \_\_\_\_\_ ялагч нь болсон.
6. Ариунбатын амралт нь (эхэл) \_\_\_\_\_ аав ээжийнх рүүгээ явлаа.
7. Миний компьютер (эвдэр) \_\_\_\_\_ застлаа бичиж чадахгүй байх.

Practice 23. Syntax: reason clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-САН<sup>4</sup> + аас<sup>4</sup>болж** form.

Model: Бороо (ор) орсноос болж хөл бөмбөгийн тэмцээн хойшлогдлоо.

1. Бодолгүй яарч шийдвэр (гарга) \_\_\_\_\_ саар үр дагавар гарч магад.
2. Эмч оноший нь буруу (тогтоо) \_\_\_\_\_ өвчин нь хүндэрсэн.
3. Архинд (хорд) \_\_\_\_\_ талийгаач болсон.
4. Хүүхэд (төрүүл) \_\_\_\_\_ хөл нь хавдсан.
5. Жоры нь (тааруулаагүй) \_\_\_\_\_ амтгүй болжээ.

6. Хоолоо залгаад (*март*) \_\_\_\_\_ түлэгджээ.  
7. Анхааралтай (*уншаагүй*) \_\_\_\_\_ юу ч ойлгоогүй.

□Practice 24. Syntax: reason clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-хаар**<sup>4</sup>.

Model: Би мөнгө (*тушаа*) тушаахаар банк руу явсан.

1. Ээж илгээмж (*явуул*) \_\_\_\_\_ шуудангийн салбар луу явсан.
2. Ах машиндаа бензин (*хий*) \_\_\_\_\_ шатахуун түгээх газар луу явсан.
3. Өвөө эм (*ав*) \_\_\_\_\_ эмийн сан руу явсан.
4. Би өөртөө уншчихаар сонирхолтой ном (*ол*) \_\_\_\_\_ номын дэлгүүр лүү өнөөдөр явна.
5. Нартай сайхан дулаан өдөр цэвэр агаар (*амьсгал*) \_\_\_\_\_ гол руу явна.
6. Найзынхаа төрсөн өдрийг (*тэмдэглэ*) \_\_\_\_\_ ресторан орно гэж бодож байгаа.
7. Хүүхдүүддээ янз бүрийн амьтан (*сонирхуул*) \_\_\_\_\_ амьтны хүрээлэн рүү явж байна.
8. Наадам (*үз*) \_\_\_\_\_ цэнгэлдэх хүрээлэн рүү явна.
9. Цагаан сараар (*золго*) \_\_\_\_\_ хэдэн айлаар орно.

## Болзолт Гишүүн Өгүүлбэр Conditional Clauses 13.3.6

Conditional clauses answer the questions *яавал? ямар болбол? яахлаар? яамагц? яатал? яамаажин? яахлаар зэрэг? яавал ч?*

Conditional Clause Conjunctions

-вал<sup>4</sup> -бал<sup>4</sup> -тал<sup>4</sup> -хлаар<sup>4</sup> -магц<sup>4</sup>

For example:

Сургуульд сурвал эрх чөлөөгөө олсны хэрэг сая бүтнэ.

Хааяа зуд болж бэлчээр муудвал хээр морь айлын адуутай нийлж, бэлчээрт гардаг.

Эрдэмтэн үхвэл нэр нь цаасан дээр, дархан үхвэл нэр нь эдэн дээр.

Тоолбол нас чацуу, төөлбөл бие чацуу.

Мах идье гэвэл малаа хариул, мантуу идье гэвэл тариагаа тарь.

Биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал.

Залгиж идвэл хор болно, ажилж идвэл хоол болно.

Мэргэдийг хорсговол эрдэм гарах, мунхгийг хорсговол балаг гарах.

Үнэн явбал үс цайна, худал явбал яс цайна.

Хүнийг шинжье гэвэл нөхрий нь шинж,

Нутгийг шинжье гэвэл усы нь шинж.

Дээрх хүн суудлаа олохгүй бол доорх хүн гүйдлээ олохгүй.

Хэлэлцэж суувал сэтгэлийн чимэг, хичээж явбал биеийн чимэг.

□Practice 25. Syntax: conditional clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-хлAAP**<sup>4</sup>+ **AA**<sup>4</sup>.

Model: Дорж манайд (*ип*) ирэхлээрээ инээдтэй юм ярьдаг.

1. Баатар анхаарлаа (*төвлөрүүл*) \_\_\_\_\_ юмыг маш сайн хийдэг.
2. Сүрэн (*гомд*) \_\_\_\_\_ өрөөндөө ороод, хаалгаа хаадаг.
3. Миний охин бүжгээр (*хичээллэ*) \_\_\_\_\_ сэтгэл санаа нь сэргэдэг.
4. Би том (*бол*) \_\_\_\_\_ аав ээждээ тусална.
5. Түмэн номын сан (*ор*) \_\_\_\_\_ нэг цаг суудаг.
6. Заяа хичээл (*заа*) \_\_\_\_\_ ойлгомжтой тайлбарлаж өгдөг.
7. Саран галзуу хулгана дээр (*тогло*) \_\_\_\_\_ дотор нь муухай оргидог.

8. Балдан (*барилд*) \_\_\_\_\_ бууж өгдөггүй.

□Practice 26. Syntax: conditional clauses.

Directions: Combine the sentences into one sentence. Use **-вал<sup>4</sup>/-бал<sup>4</sup>**.

Model: *Маргааш бороо орох байх. Тэгвэл гэртээ кино үзэж сууна.*

*Маргааш бороо орвол бид гэртээ кино үзэж сууна.*

1. Должин утсаар ярих байх. Тэгвэл намайг ажлаа тараад, тэднийд очно гэж хэлээрэй.

2. Төмөр эмч ирэх байх. Тэгвэл надад түүнээс асуух юм байна.

3. Чи надтай хамт кино үзмээр байна уу? Тэгвэл над руу утсаар яриарай.

4. Хүү минь даарах байх. Ноосон цамц өмсүүлээрэй.

5. Та ядрах байх. Тэгвэл сууж амраарай.

6. Би ажил дээрээ өлсөх байх. Тэгвэл хоол авч иднэ.

7. Тэмцээнд түрүүлэх байх. Тэгвэл шагнал авна.

8. Багаасаа хичээ. Ирээдүйд аштай.

9. Чи түүнд захиа бич. Цаадах чинь маш их баярлана.

□Practice 27. Syntax: conditional clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-аа<sup>4</sup> + гүй бол**, or **-х + гүй бол**.

1. Таныг (*ядар*) \_\_\_\_\_ энэ дэлгүүрээр орё.

2. Балданг утсаар (*ярь*) \_\_\_\_\_ эх нь санаа зовно.

3. Намайг (*хэл*) \_\_\_\_\_ тэр мэдэхгүй байх байсан.

4. Чи хоолоо (*хий*) \_\_\_\_\_ би бэлэн хоол аваад очё.

5. Тэр (*залхуур*) \_\_\_\_\_ уг нь толгой сайтай хүү.

6. Эм уугаад (*эдгэр*) \_\_\_\_\_ эмчид үзүүлье.

7. Тамир төрсөн өдрөө (*тэмдэглэ*) \_\_\_\_\_ түүнийг баярлуулъя.

8. Тэд нар энэ долоо хоногт засвараа хийж (*дуус*) \_\_\_\_\_ аав ээж нь хөдөөнөөс ирнэ.

9. Сэлж (*чад*) \_\_\_\_\_ гүнзгий усанд бүү ор.

□Practice 28. Syntax: conditional clauses.

Directions: Combine the sentences. Use **-хлАар<sup>4</sup>**.

Model: *Нар гарна. Миний сэтгэл баясна.*

*Нар гарахлаар миний сэтгэл баясна.*

1. Гуриландаа өндөг хий. Амттай болдог.

2. Ном уншиж өгдөг. Хүүхдүүд дуртай сонсдог.

3. Утас дугарна. Гэрэлээ сандран гүйж очиж авдаг.

4. Зурагт их үзсэн. Толгой өвддөг.

5. Хүүгээ үнсэнэ. Миний хүү ээжийгээ тэвэрдэг.

---

6. Өнөөдөр ажил эрт тарна. Найз нартайгаа уулзана.

---

7. Завтай болно. Би чам руу ярья.

---

8. Тэр баярладаг. Би дагаж баярладаг.

---

9. Галт тэрэг ирнэ. Бид явна.

---

### 13.3.7 Цагт Гишүүн Өгүүлбэр Time Clauses

*Time clauses* answer the question *хэзээ? хэдий хүртэл? хэзээнээс? хэдийд? хэдийгээр? хэдий үеэс? аль үеэс?*

Time Clause Conjunctions

өмнө	-х + д + аа <sup>4</sup>	-хлаар <sup>4</sup>
дараа		
хойно	-хад <sup>4</sup>	-тал <sup>4</sup>

For example:

Хурсан үүлийг завхрахын өмнө хур бороо орох нь сайн.

Идэр ногоо хөгшрөхийн өмнө их хэргийг бүтээх нь сайн.

Галуус өвөл болохын өмнө газрын халууныг эрэх нь сайн.

Номчин хүн үхэхийн өмнө номын батжилыг олох нь сайн.

Амраг хувирч салахын өмнө алсын бодлогыг таних нь сайн.

Ачит багшаас холдохын өмнө анхааран авахыг бүтээх нь сайн.

Эрээн цэцгийг хуучрахын өмнө эрхэм шүтээнээ тахих нь сайн.

Эрхтэн билгээ хомстохын өмнө эрдмийн шимийг авах нь сайн.

Би багшийг хичээлээ заагаад иртэл энд байна.

Би зуны амралт өнгөрсний дараа очно.

Аавыгаа ирэхээс өмнө би энэ ажлаа дуусгана.

Намайг иртэл та энэ зүйлээ орчуулж байгаарай.

Мал төллөж дуусахлаар тэд буцна.

Ертөнц дээр төрсөн хойно юм юмыг үзэх нь зүй.

Ахыг ирснээс хойш манайх унагаа тавив.

GRAMMAR RULE:

When a time numeral takes a genitive case ending, a suffix -н appears:

хорины үеэр

гучны үед

When the time is exact, a numeral takes a dative case ending (-Д/-Т):

хоринд

гучинд

таванд

□ Practice 29. Syntax: time clauses.

Directions: Combine the sentences into a one sentence. Use **-тал<sup>4</sup>**.

Model: Би эргээж ирнэ. Та хүлээж байх уу?

Намайг эргээж иртэл та хүлээж байх уу?

1. Зун болно. Ах ирэхгүй.

---

2. Би ирнэ. Та битгий яваарай.

3. Машин ирнэ. Энд жаахан суух уу?

4. Зургадугаар сар гарна. Би амралтаа авч чадахгүй.

5. Хоол болно. Кофе ууж бай.

6. Бороо зогсоно. Бүү гар.

7. Хүүхэдтэй болно. Энэ ажлаа хийсээр байна.

8. Дулаарна. Хөдөө явахгүй.

9. Кино эхэлнэ. Би найзтайгаа ярилцаж байлаа.

10. Энэ долоо хоног өнгөрнө. Тэд Чингис зочид буудалд байрлана.

□ Practice 30. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences with the words in parentheses.

Use **-аас<sup>4</sup> . . . хүртэл**.

Model: (Өглөө/орой) Өглөөнөөс орой хүртэл бороо орлоо.

1. Би (гэр/ажил) \_\_\_\_\_ хорин минут машинаар явдаг.
2. (Энд/дэлгүүр) \_\_\_\_\_ ойрхон, таван минутын л зайтай.
3. (Улаанбаатар/Чойбалсан) \_\_\_\_\_ хэдэн километр вэ?
4. (Энд/Монгол) \_\_\_\_\_ хэдэн цаг нисэх вэ?
5. (Гэр/сургууль) \_\_\_\_\_ би явган явдаг.
6. Би (1980 он/1990 он) \_\_\_\_\_ арван жилийн дунд боловсролын сургуульд сурсан.
7. Ээж (өглөөний 8 цаг/оройн 5 цаг) \_\_\_\_\_ ажилладаг.

□ Practice 31. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-тал<sup>4</sup> + аа<sup>4</sup>**.

Model: Энэ ажлыг хийж (дуус) дуустлаа явж чадахгүй.

1. Би тэнд (оч) \_\_\_\_\_ хөгжим сонссон.
2. Би арван найман нас (хүр) \_\_\_\_\_ машин барьж болохгүй.
3. Эгч их сургуульд (ор) \_\_\_\_\_ урлагийн ажил хийдэг байсан.
4. Би ахынх руу (яв) \_\_\_\_\_ гэрээ цэвэрлэж байя.
5. Хүү минь (унт) \_\_\_\_\_ гэрийн даалгавраа хийсэн.

□ Practice 32. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences. Use the following list.

барихдаа	✓ уулзахдаа	явахдаа	орохдоо
болохдоо	угтахдаа	гарахдаа	авахдаа

1. Би Баттай \_\_\_\_\_ уулзахдаа сайхан мэдээ дуулгана.
2. Би машин \_\_\_\_\_ дандаа хөгжим сонсдог.
3. Манайхан намайг \_\_\_\_\_ олуулаа ирсэн байсан.
4. Жаргал том \_\_\_\_\_ нисэгч болно гэж ярьдаг.
5. Тамир сая \_\_\_\_\_ малгайгаа авахаа мартаж.
6. Тэр аливаа юм \_\_\_\_\_ чанарыг эрхэмлэдэг.

7. Ээж өнөөдөр өглөө \_\_\_\_\_ ааваар хүргүүлсэн.  
 8. Тэр ажилд \_\_\_\_\_ гэрээ хийсэн.

□ Practice 33. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses. Use **-хад<sup>4</sup>** endings.

Model: Чамайг (утаст) утастахад би дөнгөж босоод байлаа.

- Зун (бол) \_\_\_\_\_ манайхан зусланд гардаг.
- Намайг ажиллаж (эхэл) \_\_\_\_\_ хүү маань дөнгөж нялх байсан.
- Өчигдөр орой арван цаг болж (бай) \_\_\_\_\_ бид нар унтсан.
- Туулыг манайд (ир) \_\_\_\_\_ би хоолоо хийж байв.
- Ээжийг (дуул) \_\_\_\_\_ та сонсож чадав уу?
- Монгол руу (яв) \_\_\_\_\_ манай гэрийнхэн бүгд гаргаж өгсөн.
- 9 цаг (бол) \_\_\_\_\_ дэлгүүр онгойсон.
- Алтансүхийг эмнэлэгт (хүргэ) \_\_\_\_\_ цаг нэлээн орой болсон байв.
- Байшин (барь) \_\_\_\_\_ чанартай сайн материал хэрэгтэй.

□ Practice 34. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences. Use **гэхэд, -д/-т, үеэр, үед**.

- Ирэх жилийн зун \_\_\_\_\_ би сургуулиа төгсөнө.
- Маргааш \_\_\_\_\_ машинаа засуулмаар байна.
- Миний найз нэгдүгээр сарын (зургаа) \_\_\_\_\_ буцна.
- Би төрсөн өдрөө наймдугаар сарын (арав) \_\_\_\_\_ тэмдэглэнэ.
- Нар жаргах \_\_\_\_\_ гадаа агаарт алхая.
- (Баяр) \_\_\_\_\_ хөл хөдөлгөөн ихэсдэг.
- Есдүгээр сарын (нэг) \_\_\_\_\_ хичээл эхэлнэ.
- Хоёулаа орой (зургаа) \_\_\_\_\_ уулзъя.
- Үүр цайх \_\_\_\_\_ хүүхдүүд босож эхэллээ.

□ Practice 35. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-Х + ын<sup>2</sup> + аа<sup>4</sup> өмнө**.

Model: Чухал шийдвэр (гарга) гаргахынхаа өмнө эхлээд сайн бод.

- Жаргал ажилд (ор) \_\_\_\_\_ машин худалдаж авсан.
- Цэндмаа шуудан (оч) \_\_\_\_\_ банк руу орсон.
- Байшин (барь) \_\_\_\_\_ орчноо сайн сонго.
- Аялалд (яв) \_\_\_\_\_ авч явах зүйлсээ бэлдэх хэрэгтэй.
- Би гэр бүлтэй (бол) \_\_\_\_\_ боловсрол эзэмшмээр байна.

□ Practice 36. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-сан<sup>4</sup> + ы/ий + аа<sup>4</sup> дараа**.

Model: Номоо (унисан) унисаныхаа дараа хөгжим сонс.

- Шинэ хичээл (урсан) \_\_\_\_\_ сайн давт.
- Хоол (идсэн) \_\_\_\_\_ шүдээ цэвэрлэ.
- Өрөөгөө (цэвэрлэсэн) \_\_\_\_\_ тогло.
- Ажлаа (тарсан) \_\_\_\_\_ дэлгүүр ороорой.
- Америкт (очсон) \_\_\_\_\_ захиа бичээрэй.

\* Please notice that in spoken language **очсон хойноо** can be used instead of **очсоныхоо дараа** if it has possessive meaning.

For example:

Би очсон хойноо ярья. Чи очсон хойноо яриарай. Тэр очсон хойноо ярина.

□ Practice 37. Syntax: time clauses.

Directions: Combine the sentences into one sentence. Use **-сан<sup>4</sup> + ы/ий дараа**.

Model: Би ажлаасаа ирсэн. Би шүршүүрт оров.

Би ажлаасаа ирсний дараа шүршүүрт оров.

1. Би гэрлэсэн. Би хүүхэдтэй болсон.

---

2. Чи явсан. Цэрмаа ирсэн.

---

3. Би өөр хотод нүүж очсон. Би ажил олсон.

---

4. Би дунд сургуулиа төгссөн. Би их сургуульд орсон.

---

5. Бороо орсон. Мөөг их ургажээ.

---

6. Нар жаргасан. Бид гадаа гарч, агаарын теннис тоглолоо.

---

□ Practice 38. Syntax: time clauses.

Directions: Complete the sentences with the verbs in parentheses.

Use **-х + аас<sup>4</sup> + аа<sup>4</sup>өмнө**.

Model: (Явах) явахаасаа өмнө надтай яриарай.

1. Даргатай (уулз) \_\_\_\_\_ надтай зөвлөөрэй.

2. Машинаа (уна) \_\_\_\_\_ тосы нь шалгаарай.

3. Гадаа (гар) \_\_\_\_\_ сайн дулаалаарай.

4. Хоолоо (хий) \_\_\_\_\_ дэлгүүр орж, сонгино авъя.

5. Тоглолтын билет (ав) \_\_\_\_\_ суудлы нь хараарай.

□ Practice 39. Syntax: time clauses.

Directions: Fill in the blanks with the verbs in parentheses. Use **-сан<sup>4</sup> + аас<sup>4</sup>хойш**.

Model: Түүнийг (явсан) явнаас хойш олон жил өнгөрчээ.

1. Та энд (ир) \_\_\_\_\_ хэр удаж байна?

2. Түүний тайлбарлаж (өг) \_\_\_\_\_ ойлголоо.

3. Кофе (уу) \_\_\_\_\_ нүд минь сэргэлээ.

4. Бороо (ор) \_\_\_\_\_ агаар сайхан байна.

5. Захиа (ав) \_\_\_\_\_ маш баяртай байгаа.

## Өгүүлбэрийг Холбох Арга Connecting Ideas 13.4

1. With No Endings. It is revealed by the *enumeration* **тоочих** or the series:

Хүний дотор баясгалантай бол юутай сайхан, Ø

Хүний дотор зовлонгүй бол юутай сайхан, Ø

Эрүүл биед зүдгүүр гачигдалгүй сайхан, Ø

Энх тайван жаргалд саадгүй сайхан.

2. With Endings:

Батыг гадагшаа **гарангуут** Туяа орж ирэв.

3. With The Particles:

Гишүүдийн ирц бүрдээгүй **Ч** хурлын үйл ажиллагаа эхлэв.

**Ялангуяа** тэднийг ирэхийг маш хүлээж байлаа.

4. With Conjunctions:

Уулаар цас маш их орсон **тул** бид бүгд цанаар гулгахгаар явав.

Аав ээж **хоёр** ажлаасаа хамт ирсэн.

5. With The Connecting Verbs: **гэ-**, **хэмээ-**:

Маргааш цаг хойшилно шүү ГЭЖ ээж минь сануулав.

Өвгөн түүнд бүү оройтоорой ХЭМЭЭХЭД хүү толгойгоо дохиод гарлаа.

NOTE: The connecting verb ГЭ- is also used in reported speech, for example:

Чамайг дугуйгаа хаана тавьсан бэ ГЭЖ аав асууж байна.

Дарга бид хоёрыг хүн бүрт энэ хуудсыг тарааж өг ГЭЖ хэлсэн.

6. With DISJUNCTS. *Disjuncts* **оруулсан үг** convey the speaker's comment about what is being said, express an attitude, make an observation about the truth of a clause, or a value judgment about its content. Disjuncts may be words or phrases. Coordinating conjunctions of explanation (Table 20, page 125) may become disjuncts. Examples:

Азаар, тэд гэртээ байхгүй байсан.

Миний бодлоор, энэ нутаг хосгүй сайхан газар.

Үнэнийг хэлэхэд, би сайн мэдэхгүй байна.

Иймээс, та нар одооноос эртхэн эхэлсэн нь дээр.

Үүнд дараах хэдэн зүйл багтана.

Тийм учраас, би очиж чадахгүй.

Хэн мэдэх вэ, түүнээс асуугаад үзэхгүй юу.

Миний сонссоноор, цаадах чинь ирсэн гэсэн шүү.

Юу гэвэл, Цэрмаагийн нутаг Гурван сайханы өвөрт бөлгөө.

NOTE: *Interjections* **аялга үг** are considered as word class. An interjection is a word or sound added into a sentence to express some feeling, for example:

Хүүе!

Ээ чааваас!

Пөөх!

□ Practice 40. Syntax: sentence analysis.

Directions: Find the CLAUSES. Underline and label them Subject clause, Noun clause, Adverbial clause, Conditional clause, Adjective clause, Reason clause, Time clause.

1. Шинэ ёс мандаж, шинжлэх ухаан дэлгэрэхэд шинэ цагийн хүмүүс шим үрийн нь хүртэнэ.
2. Буруу замаар будаа зөөсөн хүн буцахдаа шороо зөөнө.
3. Цэцгийн шимийг тэтгэсэн цэнгэлийн хавар айлчлахаар Мөрөн гол дуугаа дуулж, мөнгөн сарьдаг нь мишээдэг ээ.
4. Энэ бүхнийг эргэцүүлэн бодохын цагт Борын зүрхний цохилт хурдсаж, хүсэл мөрөөдлийн их давалгаа сэтгэлд нь долгилох ажээ.
5. Чиний инээмсэглэхэд бүхэл ертөнц дээр найман нр гарсан шиг болдог.
6. Итгэлтийн хэлсэн үг сэтгэлий нь шөвөгдөөд амар суулгадаггүй.
7. Сэрхийж сэрвийсэн өндөр оргилуудыг ажиглахад үр ач нартаа уурлаж, загнах занчихыг завдаж байгаа зэвхий царайтай буурал өвгөд шиг харагдах тул аргагүй сүрдэж, ямар ч хүний зүрх шимширч, сэтгэл ширвээдэж, царай барайх юм.
8. Балгадын хаалга татан оронгуут хоймор зүг тоотой хэд алхаад, гурвантаа сөгдөж, есөнтөө мөргөөд, алга хавсран, ихсийн өмнө хүндэтгэхийн үүрэг ардаа үүрч, сурсан заншлаар бөхөсхийн зогсов.
9. Гэнэхэн насны өдлөөгүй ухаанд уртхан юм шиг санагдаж басан ч гэрлийн хурдаар өнгөрсөн жилүүдийг энэхэн насандаа бид мартахгүй.
10. Хожим дуулахнаа, манай нутгийн багадаа залуу хочтой болсон Маам тийм ч арчаагүй амьтан биш, аймгийн яаманд хэлтсийн дарга хийж байгаад, дөчин таван оны чөлөөлөх дайнд саналаараа мордож, давшиж яваад гэдсээ зад буудуулсан боловч хол айлын дайтай мөлхсөөр үхсэн юм гэдэг.
11. Озоны мандал бол нарны хэт ягаан, хэт богино туяаны хөнөөлтэй нөлөөнөөс дэлхийн хамаг амьд биетнийг хамгаалдаг бөгөөд энэхүү озоны давхаргын ачаар манай дэлхийд амьдрал үүссэн гэж эрдэмтэд үздэг.

12. Үнэнийг хэлэхэд, санасан хэрэг минь бүтээгүй ч санаа тавьсан та бүхний тусыг үл мартана.
13. Сүрэн, Хонгор хоёрын сэтгэлийг Ням, Хишигт нар сайн мэдэж байсан авч, Итгэлт хоосон хүний охинтой ганц хүүгээ суулгахгүй гэж зовно.
14. Өнгөрсөн намар баруун аймгийн бололтой тууварчид ирж отоглосон гэх бөгөөд тэд нэг өглөө малаа тушаахаар одохдоо алс нутгаас энэ хүртэл хань болгож, малаа харуулж мануулж явсан хоточ нохойгоо орхичихжээ.
15. Эх охиндоо эмэгтэй хүн үзэсгэлэнтэй байхын тулд олны өмнө биеэ яаж авч явах тухай захижээ.

□Practice 41. Syntax: sentence analysis.

Directions: Identify the clauses within the following compound-complex sentences. Underline and label them Subject clause, Noun clause, Adverbial clause, Conditional clause, Adjective clause, Reason clause, Time clause.

1. Тэгээд машиндаа зүүрмэглэн суутал удалгүй үүр цайж, нар гарлаа.
2. Зүүн харцуулын баруун өмнө этгээдэд хэдийнээс байсан нэг хонин хашаатай бор гэрээс аргалын утаа баагьж, түүний дотор түг түг хийх уурын чимээ холхон сонстоно.
3. Хүүхдийн дуу ягуухнаар хол харвах тул хажуугаар өнгөрсөн хүмүүс цөм сонсох бөгөөд эхнийх нь хөөрхийлөн хэлэлцэж өнгөрнө.
4. Дэжид үс хэдийгээр цайсан боловч аанай л зан урьд хэвээр, ялангуяа арга ухаан хэнээс ч дутахгүй.
5. Нэг өглөө хэдэн гамин манай хотыг чиглэн ирж яваа харагдахад нь айл амьтан сандран бужигнаж, залуу охид хураалттай эсгий доор нуугдаж билээ.
6. Зам мэдэх өвгөн улаач түрүүлж, би түүнийг дагаж явлаа.
7. Нарны элч буурахад навч шарлан ногоо гандлаа.
8. Жихүүн салхи үлээхэд үхэр шар мөөрөлдөн, хүний сэтгэл гэлэлзэнэ.
9. Тэнгэр хүйтрэхлээр уулын толгойд цас бударч, голын мөс хөлдөв.
10. Цас ормогц хүүхдүүд дулаан дээлээ өмсөж, анчид мөр хөөв.
11. Намрын улирал дуусах үед малчид хашаа саравчаа дулаалж, тариаланчид тариа ногоогоо хурааж гүйцлээ.
12. Тэнгэр эвгүйцэхлээр хоньчид хонио нөмөр бараадуулж, адуучид адуугаа цуглуулна.
13. Манайхыг өвөлжөөнд буутал цас орж, хүйтэрлээ.
14. Салхи сэвэлзэн, навчис хийсэхэд шувуу буцав.
15. Сурагчид цугларч, хичээл эхэлмэгц хур татарч эхлэв.
16. Тэнгэр цэлийн, нар ээх үед хүн амьтан налайна.
17. Тал уужирч, тариа долгион, трактор комбайн хүнгэнэ ажил өрнөхлөөр хүн бүр баяртай.
18. Хяруу унаж, гол зайрмагтсан боловч сөл тасраагүй байна.

### 13.5 Цэг Цэглэл Punctuation

*Punctuation* plays a critical role in the modern writing system and helps to understand and clarify the meaning of a sentence. Its primary purpose is to enable stretches of written language to be read coherently, by displaying their grammatical structure. There are specific rules that are followed in their usage with words and sentences.

Punctuation Marks	Usage	Example
Цэг Цэглэл	Хэрэглэх тохиолдол	Жишээ
.	1. At the end of a sentence to indicate finality, absoluteness. 2. At the end of a number to indicate the order. 3. At the end of a shortened word.	1. Норов баярласандаа нүд нь сэргэжээ. 2. Хичээл №1. 3. Д. Сүхбаатар
?	1. At the end of a question.	1. Чиний нэр хэн бэ?

<p>Асуултын Тэмдэг Question Mark</p> <p>!</p> <p>Анхаарлын Тэмдэг Exclamation Point</p> <p>...</p> <p>Цуваа Цэг Series of Points</p> <p>:</p> <p>Давхар Цэг Colon</p> <p>,</p> <p>Таслал Comma</p>	<p>2. When a sentence has series of question, only one question mark is used at the end of a sentence.</p> <p>3. At the end of the quoted speech in a sentence that has a quoted speech in it.</p> <p>1. At the end of an exclaimed sentence.</p> <p>2. After the address.</p> <p>1. Sentence is not finished.</p> <p>2. Some words in a sentence are not mentioned.</p> <p>1. Before the quoted speech.</p> <p>2. Before the series and after the word that unites them, such as <i>жишээ нь, тухайлбал, үлгэрлэвэл.</i></p> <p>1. In series.</p> <p>2. To separate the clauses.</p> <p>3. If auxiliary words are used after the predicate of a clause.</p> <p>4. After the disjunct if it's at the beginning of a sentence; on both sides of the disjunct if it's in the middle of a sentence; and before the disjunct if it's at the end of a sentence.</p>	<p>2. Та энэ зургийг авмаар байна уу, эсвэл тэр зургийг авмаар байна уу?</p> <p>3. Аав надаас: “Миний охин хэзээ гэртээ ирэх гэж байна?” гэж асуусан.</p> <p>1. Эх орон маань цэцэглэн хөгжих болтугай!</p> <p>2. Нөхөд өө!</p> <p>1. Морьтой болоод завтай сан бол ...</p> <p>2. Р. Чойном бичсэн нь: “ ... Ийм сайхан орноо хамгаалахгүй юм бол иргэн нь болж төрсний минь хэрэг юусан билээ!”</p> <p>1. Гэрэлмаа: “Явъя” гэж хэлэв.</p> <p>2. Тухайлбал: би, чи, тэр гэх мэт.</p> <p>1. Би Архангай, Өвөрхангай, Булган, Дорнод гэх мэт зөндөө аймгаар явсан.</p> <p>2. Бат ирж, Дорж явлаа.</p> <p>3. Би авлаа шүү, энэ номыг чинь.</p> <p>4. 1) Бодвол, бид маргааш орой хүрэх байх. 2) Чи, адаглаад, өчигдөр надад хэлэхгүй дээ. 3) Би үүнд дургүй, үнэнийг хэлэхэд.</p>
--	--	--

Punctuation Marks Цэг Цэглэл	Usage Хэрэглэх тохиолдол	Example Жишээ
<p>;</p> <p>Цэгтэй Таслал Semicolon</p>	<p>1. Classify the series by their meaning.</p> <p>2. In series if they are incomplete sentences.</p>	<p>1. Ертөнц гэдэгт газар дээрх уул ус, шороо чулуу; хүн амьтан, ургамал мод, ан гөрөөс цөм орно.</p> <p>2. Үүнд: 1) төлбөрөө хугацаанд нь төлөх; 2) орчин тойрноо цэвэрхэн байлгах; 3) дэг журмыг сахих зэрэг орно.</p>
<p>“ ”</p> <p>Хашилт Quotation Mark</p>	<p>1. In a quoted speech.</p> <p>2. For special emphasis or hidden meaning.</p> <p>3. For the titles of published works</p>	<p>1. Сүхбаатар хэлсэн нь: “Сурахыг эрхэм болговол зорих чиглэл өөрөө тогтоно.”</p> <p>2. Мөн ч “гавшгай” хүн байна даа. (meaning “гавшгай биш”)</p> <p>3. Би Ч. Лодойдамбын “Тунгалаг Тамир” романыг уншив.</p>
<p>( )</p> <p>Хаалт Parentheses</p>	<p>For explanation.</p> <p>1. For transferring the syllable of the word to the next line.</p>	<p>Төрийн үйл хэргийг бүтээхэд улс, олон нийтийн байгууллага (нам, эвсэл, холбоо) туслалцана.</p> <p>1. хам-гаа-лал</p>

-  
Богино Зураас  
Hyphen

2. After the abbreviation, before the case endings.
3. Between numerals to show the period of time.
4. In compound proper nouns if the second part of the name starts with a vowel.

2. НҮБ-ын төлөөлөгч
3. XV-XX зууны үед
4. Төмөр-Очир, Бат-Эрдэнэ, Энх-Амар

—  
Урт  
Зураас Dash

In a conversation.

Дамба:  
– Чи хэзээ ирэх вэ?

§  
Зүйлийн тэмдэг  
Paragraph Symbol

In article numbering

§67 is read as 67 дугаар зүйл

Догол мөр  
New Paragraph

A sentence or a group of sentences that are close in terms of content and general meaning.

Данзан гуай нэг ёсондоо Өмнөговийн амьдралын лавлах гэсэн үг.  
Орох оронгүй өнчин ядуу явж, хувьсгалын жилд өтлөх насандаа жаргаж сууна.

When *transferring* **үг шилжүүлэх дүрэм** the word from one line to another, a word has to be broken into syllables – combined units of consonants and vowels. Only a syllable can be transferred. A vowel syllable after the separatives can be transferred. One letter is not transferred.

Ал-дар гавь-яа эр-дэм мэд-лэ-гийн тө-лөө төрс-нөөс биш,  
ад-гуу-сан амь-тан шиг амь зуу-хын тө-лөө тө-рөө-гүй бид.

□ Practice 42. syntax: punctuation.

Directions: Add Punctuation marks and capital letters as necessary.

булаг усан бургилж цэцэг ногоо жигдэрсэн өргөн сайхан талын дунд уяхан эгшиг хангинаж уургын үзүүр үе үе сэрвэлзэнэ хээрийн салхи урьхнаар үлээж ногооны үзүүр намилзан халиурна хүний сэтгэл тэнийм энэ уудам хээр хөдөөгийн талбарт сүрэг хонь бэлчээрлэж яргуй цэцгийн шимтэй сайхныг эрэн усны тунгалаг ариуныг хүснэ үд дунд болоход нарны элч маш халуунаар шарав бэлчээрийн хоньд хурж үдшийн сэрүүн амьсгалыг хүлээхэд хоньчин Найдан тэрлэгээрээ халхавч босгож сүүдэрт нь сууна энэ завсар Найдан хүү ойр хол олон зүйлийг эргэцүүлэн бодохын зуур гэрийн зүг хааяа ширтэнэ

ийнхүү Найдангийн сууж байхад түүний өнчин Халзаадай гэдэг хурга нь гүйж ирээд эзэндээ эрхэлж гар нүүрий нь зөөлхөн халуун хошуугаараа үнэртэж үзнэ Найдан бяцхан хүүдий дотроос хурууд гаргаж

миний өнчин Халзаадай ид дээ гэж өгөхөд хурга нь амталж үзээд өөрөө ид гэсэн мэт Найдангийн нүүрийг ширтэн гары нь үнэрлэн эрхлэн байхад дэргэдээс нь агь таана түүж

чиний дуртай хоол чинь энэ шүү дээ ид гэж өгөв хоньчин Найдан өнчин Халзаадайтайгаа тоглохдоо энэ олон хонь дотроос ганцхан чи минийх шүү дээ чи том болоод надад олон хурга гаргаж өгнө гэх зэргээр хэл мэддэг амьтанд үг хэлж байгаа юм шиг өнчин Халзаадайгаа эрхлүүлнэ

энэ хургыг хавар цаг баруун зүг нүүж явсан нүүдэл айлын хониноос унтаад гээгдэж хоцорсныг нь Найдан олж хонинд авахуулан тэжээсэн билээ

өндөрт мандсан үдийн наран баруунаа хэлбийв алс нүдний үзүүрт Холбоо нуурын ус нь цэнхэрлээд түүний дэргэд хэдэн гэр зэрэглээнд сарниж эрвийн үзэгдэнэ Найдангийн эх араг үүрч савар бариад аргал түүх завсартаа хоньчин хүүгийн хойноос холын барааг ширтэнэ

Найдангийн эцэг Зоригт мориндоо мордоод нуурын усанд зогссон адуун сүргийн зүг одох зуур хүүдээ сайн морь олж өгөх арга юу билээ гэж эргэцүүлж бодно

орчлон дахиныг туяа гэрлээрээ тэтгэгч алтан шар наран хэлбийж оройн сэрүүн амьсгал оров

хурсан хонь сэргэж таран бэлчээрлэв

хоньчин Найдан сайхнаар бэлчээрлэн байгаа хонио тууж гэртээ харихыг түвдсэнгүй сэрүүн цагт нэлээд бэлчээрлүүлэн идээшлүүлээд үдэш хотлуулахаар шийдвэрлэв болжмор шувуу сайхан хоолойгоор уянгатай жиргэнэ уулын толгой дээр очсон нарны гэрэлд өрнө зүгийн хээр талын ногоо цэцэг нь гялтганан гэрэлтээд алтан сувдын хэлхээ татан харагдана алс уулын сүүдэр бууж бэлчээрийг газар хүрэв гэр хүртэл нэлээд зайтай тул шамдахгүй бол горьгүй гэдгийг Найдан мэдэж хонио бэлчээрээс хурааж эхлэв

□Practice 43. syntax: punctuation.

Directions: Add Punctuation marks and capital letters as necessary.

*Насанбатын хаалганд дугтуйтай захиа хавчууластай байна Насанбатыг гарч ирэхэд дугтуй унана Цэцэгээ мөн гарч ирнэ*

Насанбат хэн манай хонх дарав аа

Цэцэгээ мэдэхгүй манай хонх бас дугараад би гарч ирлээ

Насанбат үгүй танайх биш манайх дугарсан

Цэцэгээ мэдэхгүй манайх л дугараад байх шиг болсон

Агваан шагайж та минь та нар чинь юунд хонх тачигнуулаад байна вэ

Насанбат үгүй танайх биш манайх дугарсан одоо гэтэл хэн дугаргасныг бүү мэд эзэн нь олдохгүй боллоо

Агваан хачин юм даа манайх л дугарах шиг болсон юм

Цэцэгээ хэнийх ч байлаа гэсэн эзэн нь олдохгүй байгаа нь хачин юм

Агваан инээмсэглэж ээ хай мэдэхгүй аягүй бол чи ч өөрөө дарсан байж мэдэх дэг ээ

Цэцэгээ хүүе яадаг билээ би юу гэж танайхыг дарах билээ

Агваан манайхыг ч үгүй л дээ эднийхийг алиалан аяархан хэлнэ

Цэцэгээ мөн хариуд нь инээж чухам ингэж ярих дээр хүрвэл байна шүү харин та л манайхыг дарсан байж мэднэ

Агваан хүүе хүүе хүүхээн би зүгээр л тоглоод хэлж байна

Цэцэгээ арай ч юу бол юу ч атугай та манайхыг тоглох шоглох хоёрын хооронд гэж мэдээрэй үгүй энд нэг захиа хэвтэх нь юу вэ захиаг авч үзэн хаяггүй юм байна хэнд ирсэн байж таарах вэ

Агваан өө надад ирсэн байж мэднэ би нэг газраас захиа хүлээсээр удаж байгаа юм захиаг авч яаралтай задалж үзнэ үгүй минийх л биш

Цэцэгээ үгүй та сайн үз

(Д. Намдаг “Шинэ байшинд” жүжгээс)

□Practice 44. syntax: punctuation.

Directions: Add COMMAS and PERIODS as necessary.

Жаргалтай дэлгэр зуныхаа гурван сард

Жигдлэн ургасан таван өнгийн бадам найгалзаад

Жигүүртэн олон шувуу нуурын дунд цэнгэхэд

Жавартай өвлийн хүйтнийг мартана л

Захирч сургагчдын сургаалыг орхиод

Зальхай найман номыг даган явсаар

Завдлага үгүй дөрвөн далайн

Жамыг эс мэдэв л

(Д. Нацагдорж “Дөрвөн улирал. Зун. Идэр цаг”)

# Хэл Зүйн Нэр Томъёо

## Glossary of Grammar Terms

### A

ablative case	гарахын тийн ялгал
absolute degree	ижил зэрэг
accusative case	заахын тийн ялгал
added subordinating connection	хамжиж угсарсан харьцаа
adjective	тэмдэг нэр
adjective clause	нэрийн тодотгол гишүүн өгүүлбэр
advancive circumstantial connective ending	урьдчилан нөхцөлдүүлэн холбох нөхцөл
adverbial	байц
adverbial clause	оронт гишүүн өгүүлбэр
advise-command completing ending	зөвлөн захирах төгсгөх нөхцөл
allow-want completing ending	зөвшөөрч хүсэх төгсгөх нөхцөл
alphabet	цагаан толгой
antonyms	эсрэг утгатай үг
assign-command completing ending	даалган захирах төгсгөх нөхцөл
auxiliary verb	туслах үйл үг
auxiliary vowel	туслах эгшиг

### B

base	үндэс
basic vowel	үндсэн эгшиг
benefitive circumstantial connective ending	дашрамдан нөхцөлдүүлэн холбох нөхцөл

### C

capitalization	том үсэг хэрэглэх
cardinal number	үндсэн тоо
causative form	бусдаар үйлдүүлэх хэв
collective number	хам тоо
colon	давхар цэг
comitative case	хамтрахын тийн ялгал
comma	таслал
common noun	ерийн нэр
comparative degree	илүү зэрэг
complement	тодотгол
complete conditional ending	бүрмөсөн үйлдэх байдлын нөхцөл
complex sentence	хавсарсан нийлмэл өгүүлбэр
compound word	хоршоо үг
compound-complex sentence	холимог нийлмэл өгүүлбэр
compound sentence	энгийн нийлмэл өгүүлбэр
concessive circumstantial connective ending	дутагдан нөхцөлдүүлэн холбох нөхцөл
conditional circumstantial connective ending	болзон нөхцөлдүүлэн холбох нөхцөл
conditional clause	болзолт гишүүн өгүүлбэр
conjunction	холбох үг
consonant	гийгүүлэгч үсэг
continuous circumstantial connective ending	үргэлжлэн нөхцөлдүүлэн холбох нөхцөл
cooperative form	хамтран үйлдэх хэв
coordinating connection	зэрэгцсэн харьцаа

**D**

dash  
 dative case  
 decide-want completing ending  
 definitive connective ending  
 demand-command completing ending  
 demonstrative pronoun  
 derivative  
 diminished adjective  
 diphtong  
 direct meaning  
 directional case  
 distinguishing pronoun  
 distributive number  
 dream-wish completing ending

**E**

ending  
 exclamation point  
 extended sentence

**F**

feminine vowel  
 feminine word  
 figure speech (figurative meaning)  
 foreign word  
 formative ending  
 fraction number

**G**

genitive case

**H**

hyphen

**I**

idiom  
 imperative completing ending  
 indefinite pronoun  
 instrumental case  
 intensified adjective  
 intensive conditional ending  
 interaction form  
 interrogative pronoun  
 intransitive verb

**L**

long vowel

**M**

masculine vowel  
 masculine word  
 mass conditional ending  
 mixed subordinating connection  
 morphology

урт зураас  
 өгөх оршихын тийн ялгал  
 шийдэн хүсэх төгсгөх нөхцөл  
 тодотгон холбох нөхцөл  
 шаардан захирах төгсгөх нөхцөл  
 заах төлөөний үг  
 үүсмэл  
 бууруулсан тэмдэг нэр  
 хос эгшиг  
 шууд утга  
 чиглэхийн тийн ялгал  
 ялгах төлөөний үг  
 түгээл тоо  
 мөрөөдөн хүсэх төгсгөх нөхцөл

**нөхцөл**

анхаарлын тэмдэг  
 дэлгэрэнгүй өгүүлбэр

**эм эгшиг**

эм үг  
 шилжсэн утга  
 гадаад үг  
 хэвийн нөхцөл  
 бутархай тоо

**харьяалахын тийн ялгал****богино зураас****өвөрмөц хэллэг**

тушаан захирах төгсгөх нөхцөл  
 тодорхойгүй төлөөний үг  
 үйлдэхийн тийн ялгал  
 эрчимжүүлсэн тэмдэг нэр  
 эрчимтэй үйлдэх байдлын нөхцөл  
 харилцан үйлдэх хэв  
 асуух төлөөний үг  
 эс тусах үйл үг

**урт эгшиг****эр эгшиг**

эр үг  
 олноор үйлдэх байдлын нөхцөл  
 найрч угсарсан харьцаа  
 үг зүй

**N**

negative circumstantial connective ending  
 neuter vowel  
 new paragraph  
 nominative case  
 non-derivative  
 noun  
 noun clause  
 numeral

үгүйсгэн нөхцөлдүүлэн холбох нөхцөл  
 саармаг эгшиг  
 догол мөр  
 нэрлэхийн тийн ялгал  
 үүсмэл биш  
 нэр үг  
 шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр  
 тооны нэр

**O**

object  
 ordinal number  
 orthography

тусагдахуун  
 дэс тоо  
 зөв бичих зүй

**P**

paragraph symbol  
 parallel circumstantial connective ending  
 parallel compound word  
 parallel verb  
 parentheses  
 particle  
 passive form  
 period  
 personal pronoun  
 phoneme  
 phoneme adding  
 phoneme differentiation  
 phoneme dropping  
 phoneme similarization  
 phonology  
 phrasal verb  
 polysemantics  
 possessive endings  
 predicate  
 preparative circumstantial connective ending  
 preposition  
 pronoun  
 proper noun  
 punctuation

зүйлийн тэмдэг  
 зэрэгцэн нөхцөлдүүлэн холбох нөхцөл  
 зэрэгцсэн хоршоо үг  
 зэрэгцсэн үйл үг  
 хаалт  
 чимэх үг  
 бусдын эрхэнд үйлдэх хэв  
 цэг  
 биеийн төлөөний үг  
 авиалбар  
 авиалбар нэмэгдэх  
 авиалбар ондооших  
 авиалбар гээгдэх  
 авиалбар ижилсэх  
 авиалбар зүй  
 нийлмэл үйл үг  
 олон утгат үг  
 хамаатуулах нөхцөл  
 өгүүлэхүүн  
 бэлтгэн нөхцөлдүүлэн холбох нөхцөл  
 орон цагийн нэр  
 төлөөний үг  
 оноосон нэр  
 цэг цэглэл хэрэглэх

**Q**

question mark  
 quotation mark

асуултын тэмдэг  
 хашилт

**R**

reason clause  
 reflexive pronoun  
 remind-command completing ending  
 repeat number  
 respect-command completing ending  
 round number

шалтгаант гишүүн өгүүлбэр  
 өөрийн төлөөний үг  
 сануулан захирах төгсгөх нөхцөл  
 дахих тоо  
 хүндэтгэн захирах төгсгөх нөхцөл  
 тойм тоо

## **S**

self-action form  
semi-colon  
separative  
series of points  
short vowel  
short sentence  
sign letter  
similar words  
simple conditional ending  
simple sentence  
special consonant  
stem  
subject  
subject clause  
successive compound word  
subordinating connection  
suffix  
superlative degree  
syllable  
synonyms

өөрөө үйлдэх хэв  
цэгтэй таслал  
тусгаарлагч  
